



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМ



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН



THE WORLD BANK  
IBRD • IDA | WORLD BANK GROUP

# МОНГОЛ ХЭЛ V ГАРЫН АВЛАГА



Улаанбаатар хот  
2023 он



Б.ЦАСАНЧИМЭГ, Б.АЯУЖАН, А.ХАБДОЛДА, Т.САУЛЕ

# МОНГОЛ ХЭЛ V

## ГАРЫН АВЛАГА

Хос хэлний сургалттай ерөнхий боловсролын  
сургуулийн 5 дугаар ангид үзнэ.

Улаанбаатар хот  
2023 он

ННА 74.1  
ДАА 372  
М-692

Монгол хэл V: Хос хэлний сургалттай ерөнхий боловсролын сургуулийн  
5 дугаар ангийн гарын авлага., (УБ.2023-120 нүүр)

Энэхүү гарын авлагыг Боловсрол, Шинжлэх Ухааны Яам, Дэлхийн Банкны  
хамтран хэрэгжүүлж буй "Боловсролын чанарын шинэчлэл" төслийн  
дэмжлэгээр боловсруулж, хэвлэв.

© Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэн

ISBN: 978-9919-9004-4-1

## ГАРЧИГ

НЭГ. БИ .....	5
ХОЁР. ГЭР БҮЛ.....	17
ГУРАВ. ЭРДЭМ НОМ.....	27
ДӨРӨВ. АЖИЛ ХӨДӨЛМӨР .....	37
ТАВ. ДЭЛХИЙН УЛС ОРОН .....	49
ЗУРГАА. ЭРҮҮЛ АМЬДРАЛ .....	59
ДОЛОО. АМЬТАД.....	69
НАЙМ. ЭХ ДЭЛХИЙ .....	79
ЕС. ХАРИЛЦАА.....	91
АРАВ. ЁС ЗАНШИЛ.....	103
БАТАТГАЛ.....	115

### ТАНИХ ТЭМДЭГ



УНШИХ



БИЧИХ



ЯРИХ



ДҮРЭМ

1

НЭМЭЛТ ДААЛГАВАР

## ӨМНӨХ ҮГ

Хос хэлний сургалттай ерөнхий боловсролын сургуулийн тавдугаар ангийн сурагчдын Монгол хэлний “Сонсох – Ярих – Унших – Бичих” чадварыг хөгжүүлэхэд зориулсан “Гарын авлага” болон “Дасгал ажлын дэвтэр”-ийг та бүхний гарт хүргэж байгаад баяртай байна.

Энэхүү хоёр номын дасгал даалгавар нь сурагчдын монгол хэлний дараах чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

- Монгол хэлээр идэвхтэй, зорилготой сонсох, чухал зүйлийг лавшруулан тодруулж, тэмдэглэж сонсох, санаа бодлоо илэрхийлэх, цээжлэн тогтоох чадварыг хөгжүүлэх
- Монгол хэлээр унших, бичих, сонсох чадвартай болох, зөв хурдан, ойлгож, уран унших, эхийг задлан тайлбарлах чадварыг хөгжүүлэх
- Санаа бодлоо жишээ татан, оновчтой, ойлгомжтой, товч тодорхой, дэс дараалалтай илэрхийлэх чадварыг хөгжүүлэх
- Алдаагүй цэвэр сайхан бичих, дуурайн зохиож бичих, зорилгодоо нийцүүлэн, бүтцийн дагуу бичих, учир шалтгааны уялдаа холбоотой өрнүүлэн бичих чадварыг хөгжүүлэхэд энэхүү гарын авлага тусална.


Хүүхдүүд та нарын хичээнгүйлэн суралцах үйлсэд нь амжилт хүсье!

Номын цагаан буян дэлгэрэх болтугай.

Зохиогчид

# I БҮЛЭГ. БИ

## ДАСГАЛ 1

 А. Эхийг уншаад ярилцаарай.

### Уншихдаа анхаараарай.



- ☞ Үе, үгийг зөв хэлэх
- ☞ Үгийг сольж гээлгүй унших
- ☞ Амьсгалаа зөв тохируулах
- ☞ Асуулт, хариулт уншихдаа дууны өнгө, аялгаа тохируулах
- ☞ Түгдрэлгүй унших
- ☞ Буруу дуудаж, алгасаж уншсан бол алдаагаа залруулах



### Бүртгэл

Нямаа ном уншихаар аймгийн номын санд очлоо. Номын санч түүнд эхлээд уншигчаар бүртгүүлэх хэрэгтэй гэв. Номын санч асуулт асууж, Нямаа асуултад хариуллаа.

- Чамайг хэний хэн гэдэг вэ?
- Намайг Даваагийн Нямаа гэдэг.
- Төрсөн он, сар, өдрөө хэлнэ үү?
- Би хоёр мянга арван хоёр оны есдүгээр сарын арван найманд төрсөн.

- Хаана төрсөн бэ?
- Баян-Өлгий аймгийн Буянт сумд.
- Аль сургуулийн хэддүгээр ангид сурдаг вэ?
- Өлгий сумын ерөнхий боловсролын “Бастама” сургуулийн 5б ангид сурдаг.
- Гэрийн хаягаа хэлээрэй.
- Өлгий сумын 10 дугаар баг, Нисэхийн 204 тоот хаалга.
- Мэдээлэл өгсөнд баярлалаа. Дуртай номоо сонгон авч уншаарай.
- Баярлалаа.

Нямаа шинэ уншигч болсондоо баяртай байлаа. (А.Хишгээ)



### Үгийн утгыг мэдье

**бүртгэл** - байвал зохих юм бүхэн буй эсэхийг шалган бичих тэмдэглэгээ  
“Монгол хэлний хураангуй тайлбар толь”-оос

1 Асуултад хариулж ярилцаарай.

- ✓ Хэрвээ чи номын санчийн оронд байсан бол ямар асуулт асуух байсан бэ?
- ✓ Номын санч чиний тухай мэдэж авах нь ямар хэрэгтэй юм бол?



Б. Чи номын санч болж, найзаасаа асуулт асууж ярилцаарай.



Асуултаа тод, ойлгомжтой хэлээрэй.



Дууны өнгө, аялга бодоорой.



Ярьж байгаа найз руугаа толгой дохин, инээмсэглээрэй.



Бүтэн өгүүлбэрээр яриарай.

- ✓ Чамайг хэний хэн гэдэг вэ?
- ✓ Төрсөн он, сар, өдрөө хэлнэ үү?
- ✓ Хаана төрсөн бэ?
- ✓ Аль сургуулийн хэддүгээр ангид сурдаг вэ?
- ✓ Гэрийн хаяг, холбоо барих утсаа хэлээрэй.

Чи ямар ном унших дуртай вэ?



Ямар зохиолын ямар баатарт хайртай вэ?  
Тэр баатраа дүрсэлж ярина уу?

Чиний хамгийн дуртай ямар ном байдаг вэ?  
Ямар учраас энэ номд дуртай болсон бэ?


Найз нартаа юу гэж хэлмээр байна вэ?

Чи номын тэмдэглэл хөтөлдөг үү?  
Тэмдэглэлдээ юу юуны тухай бичдэг вэ?



В. Цагаан толгойн үсгийн ангиллыг тайлбарлаж бичээрэй.

Жишээ нь: Цагаан толгой 35 үсэгтэй. Үүнийг "Эгшиг, гийгүүлэгч, тэмдэг үсэг" гэж ангилдаг.





А. Хүүхдүүд ээ, та нар өдрийн тэмдэглэл хөтөлдөг үү? Жарас тэмдэглэлдээ өөрийнхөө тухай бичсэнийг анхаарч уншаарай.



### Миний намтар

Миний төрсөн өдрийн хамгийн сайхан бэлэг бол дэвтэр минь чи байлаа. Би тэмдэглэлийн дэвтэр чамтай найз болсондоо хязгааргүй баяртай байна. Дэвтрийнхээ хамгийн эхэнд өөрийнхөө тухай ярихыг хүснэ.

Намайг Мурат овогтой Жарас гэдэг. Би 2012 оны 4 дүгээр сарын 20-нд Баян-Өлгий аймгийн Улаанхус сумд төрсөн. Би арван настай, эмэгтэй.

Аав, ээж, ах, хоёр эгчтэйгээ хамт Өлгий сумын есдүгээр багийн 86 тоотод амьдардаг. Өлгий сумын ерөнхий боловсролын тавдугаар сургуулийн тавдугаар ангийн “А” бүлэгт сурдаг. Биеийн тамир, тооны хичээлийг илүү сонирхдог. Зураг зурах, дуулах, доомбор тоглох авьяастай.

Чөлөөт цагаараа гар бөмбөг, шатар тоглож, пүрэв гараг бүр найзуудтайгаа хамт номын санд очдог. Ирээдүйд инженер болохыг хүсдэг. Энэ мөрөөдлөө биелүүлэх зорилгоо дэвтэртээ бичээд, би хичээнэ ээ. Надад туслаарай дэвтэр минь.



Б. Жарас тэмдэглэлдээ эхлээд, дараа нь, төгсгөлд нь өөрийнхөө тухай юу бичсэн байна вэ?

### Жарасын намтар

Төрсөн үеийн талаар

Намайг Мурат овогтой Жарас гэдэг. Би 2012 оны 4 дүгээр сарын 20-нд Баян-Өлгий аймгийн Улаанхус сумд төрсөн.

Одоогийн амьдрал

Би арван настай, эмэгтэй. Аав, ээж, ах, хоёр эгчтэйгээ хамт Өлгий сумын 9 дүгээр багийн 86 тоотод амьдардаг. Өлгий сумын ерөнхий боловсролын тавдугаар сургуулийн тавдугаар ангийн “А” бүлэгт сурдаг. Биеийн тамир, тооны хичээлийг илүү сонирхдог. Зураг зурах, дуулах, доомбор тоглох авьяастай. Чөлөөт цагаараа гар бөмбөг, шатар тоглож, ном унших дуртай.

Ирээдүйн талаар

Ирээдүйд инженер болохыг хүсдэг.



В. Өөрийгөө товч танилцуулж бичээд, найз нартаа уншаарай.

Би ямар хүүхэд вэ?

Би .....

Би .....

Би .....

Би .....

Би .....

Би .....

Би .....

Би .....



Эгшигт гийгүүлэгчийн дүрмээ саная.

**М, н, г, л, б, в, р - 7**  
**(Монгол баавар)**  
 Эдгээр 7 гийгүүлэгч өмнөө буюу хойноо заавал эгшигтэй бичигддэг тул **эгшигт гийгүүлэгч (ЭГ)** гэнэ.

Дүрэм

ЭГ + ЭГ = + Э +  
 (гавар, намар, сийлбэр...)

ЭГ + ЗГ = - Э -  
 (гарц, хүрз, цамц...)

Дараах тулгуур дохиог тайлан уншиж сурцгаая.

**1. 7 = + Э**  
 Эгшигт гийгүүлэгч заавал эгшигтэй бичигдэнэ.  
 гавар, тохон, цацрал, модон, гарав

**2. 7 + 7 = + Э**  
 Эгшигт гийгүүлэгчийн дараа эгшигт гийгүүлэгч орвол заавал эгшигтэй бичнэ.  
 Гүрвэл, хавар, самбар, суман

## ДАСГАЛ 3



А. Сургаалыг анхааралтай уншаарай.



Эрхэм сайн хөвгүүний ёс нь  
Эцгийн сургаалаар явагч  
Эрдэм билиг сурахад дуртай.  
Энэрэх ухаантай хөвгүүн  
Ах дүү хэнд ч ачлалтай  
Ааш зан нь дөлгөөн номхон  
Арга ухаанд цэцэн сайн  
Аж төрөхөд маш зүтгэлтэй  
Ашид бүтээмжтэй хөвгүүн.



Сайн охины ёс нь  
Сайн сайхан гоо зүстэй  
Санаа сэтгэл нь номхон дөлгөөн  
Саруул ухаантай охин.  
Эхийн сургаалаар явагч  
Эгч дүүтэйгээ эвтэй.  
Эсгэх оёход уран  
Эрхэм сайн охин.

*"Тоть шувууны сургаал"-аас*



### Үгийн утгыг мэдье

**ашид** - үүрд, мөнхөд  
**дөлгөөн** - удаан, тайван  
**зүтгэлтэй** - идэвхтэй, зүтгэл сайтай  
**саруул** - цэцэн мэргэн ухаан  
**цэцэн** - ухаан сэргэлэн, үг нь оновчтой сайн  
**энэрэх** - хайрлах, өрөвдөх  
**эрдэм билиг** - эрдэм ном  
**эрхэм сайн** - хамгийн сайн

*"Монгол хэлний хураангуй тайлбар толь"-оос*

1 Асуултад хариулаарай.

- ✓ Хүнд өөр ямар сайн зан чанар байдаг вэ?
- ✓ Шүлгийн гол санааг илэрхийлсэн зүйр цэцэн үг аль нь вэ?

Сайн явдал  
гайхамшиг.

Хүн нэрээ  
Тогос өдөө.

Ах нь сургадаг.  
Дүү нь сонсдог.



Б. Шүлгээс сонгон цээжилж, уран уншаарай.



В. Хоёр эхийг харьцуулж уншаад аль хэсэг нь өргөн утга илэрхийлж байгааг ярилцаарай.

Ах дүү хэнд ч ачлалтай  
Ааш зан нь дөлгөөн номхон  
Арга ухаанд цэцэн сайн  
Аж төрөхөд маш зүтгэлтэй  
Ашид бүтээмжтэй хөвгүүн.

Ахад ачлалтай  
Ааш нь дөлгөөн номхон  
Арга нь цэцэн сайн  
Аж төрөхөд маш зүтгэлтэй  
Ашид бүтээмжтэй хөвгүүн.



Г. Найзынхаа сайн шинжийг 4 мөрөөр тоочин магтаарай.

1 Бичсэнээ засаж сайжруулж, нөхдөдөө уншиж өгөөрэй.

□ Дараах үгсээс хэрэглэж болно.

<b>Үгс:</b> ном эрдэм, хүч чадал, авхаалж самбаа, уян зөөлөн,	цэвэрч нямбай, ажигч гярхай, цовоо сэргэлэн, ажилч хөдөлмөрч, үнэнч шударга,	хурдан шуурхай, ухаан бодол, үзэсгэлэн төгөлдөр, амгалан тогтуун, намуун дөлгөөн,	цэвэр ариун, аз жаргал, эв эе, цэцэн мэргэн, эрдэм ухаан
---	--	---	--



Заримдаг гийгүүлэгчийн дүрмээ эргэн саная. Дүрэмд холбогдох үгийн жишээг сургаалаас олж хэлээрэй.



**Ц, ж, з, с, д, т, ш, ч, х - 9**

(Цоожоо засаад тушаачих)

Эдгээр 9 гийгүүлэгчийг заримдаа эгшигтэй, заримдаа эгшиггүй бичдэг тул заримдаг гийгүүлэгч (ЗГ) гэнэ.



**Заримдаг 9 гийгүүлэгч**



Заримдаг гийгүүлэгчийн араас орсон заримдаг заавал эгшигтэй бичигдэнэ.

- Модот, модтод, хожид, хождох, бусад, бусдад, эзэд, Батад, ахад, мөчид, хойшид, буцаж, эцэс, очит, анжис гэх мэт.

Эгшигт гийгүүлэгчийн араас орсон заримдаг гийгүүлэгчийг эгшиггүй бичнэ.

- Ховд, хагд, амт, тэнд, ард, тэвш, багш, булш, зунш, дарш, эзэмш



А. Эхийг дараах зааврын дагуу уншаарай.

**Унших заавар:**



- 👉 Эхний хүүхэд 1 минут уншина. Хэт чанга биш дуугаар, энгийн хурдаар уншина.
- 👉 Нөгөө хүүхэд зөв уншиж байгаа эсэхийг хянана.
- 👉 Буруу дуудсан, өөр үгтэй андуурсан, таасан, алгассан үгсийг алдаанд тооцно. Үгээ өөрөө залруулж, зөв болгосон бол алдаанд тооцохгүй.
- 👉 Минутаад хэдэн үг уншсанаа дэвтэртээ тэмдэглэнэ.
- 👉 Дараагийн хүүхэд мөн адил уншина.

**Найзууд**

Үгийн тоог тэмдэглэв.



Чимэг Цэцэг хоёр таван жил үерхжээ. Сургуульд орсон өдрөө нэг ширээнд сууснаас хойш ганц ч удаа бие биеэ гомдоосонгүй. Тэд хаана ч хамт явна. Хичээл тарсан хойно хэн нэгнийдээ ирж, даалгавраа хамт хийнэ. 31

Тэгтэл тоолбол нас чацуу, төөлбөл бие чацуу хоёр охины сурлагын ялгаа сар улирал өнгөрөх тусам мэдэгдэх боллоо. Цэцэг тавдугаар ангид орсон жилээсээ тооны хичээлд тааруухан болж, харин Чимэг сайн сурдаг хэвээрээ байлаа. Чимэг найзынхаа төлөө санаа зовж эхлэв. Тэр: 70

- Надаас боллоо. Би л муу тусаллаа гэж боджээ. Нэг өдөр Чимэг хичээлийн дараа найзындаа очжээ. Цэцэг уруу царайлж сууна. 93

- Гэрийн даалгаврын тоог бодсон уу?
- Амжаагүй.

- "Алив ном, дэвтрээ аваад ир. Найз нь бодоод өгье" гэж Чимэг хэлээд найзынхаа тоог нэгд нэгэнгүй бодож өгөв. Маргааш нь Цэцэг "сайн" дүн авчээ. Үүнээс хойш Чимэг найзынхаа тоог бодож өгдөг болов. Сүүлдээ Цэцэг даалгавар хийлгүй ирээд хичээлд орохын өмнө Чимэгийн дэвтрээс шууд хуулдаг болов. Ганцхан үнэнч найз Чимэг л түүнд тусална. Ингэсээр улсын шалгалттай золгов. 152

Энэ өдөр Цэцэг шиг өрөвдөлтэй хүүхэд байсангүй. 182

- Найз аа минийхийг бодоод өгөөч! гэж байн байн тохойгоороо түлхэж, нүдээрээ гуйсаар байлаа. Чимэг өөрийнхөө тоог хагас дутуу бодоод, найздаа туслах ажилд оров. Эхний тоог бодоод, дэвтрийнхээ доогуур сэмхэн гулгуулсанд багш нь харчихжээ. Багш: 184

- Чимэг, чи яаж байна. Найздаа ингэж тусалж болохгүй. Энэ чинь тусалж байгаа хэрэг биш шүү! гэж хэллээ. Хоёр найз ичихийн ихээр ичив. (С.Надмид) 205




**Үгийн утгыг мэдье**

**тоолбол нас чацуу, төөлбөл бие чацуу** - үе тэнгийн

**сэмхэн** - хүнд мэдэгдэхгүй

**өрөвдөлтэй** - тусалж тэтгэмээр

“Монгол хэлний хураангуй тайлбар толь”-оос

 Б. Хоёр найзын үйлдлийг дүгнэн бичье.

Чимэгийн хийсэн үйл



Таван жил үерхжээ.  
Ганц ч удаа бие биеэ гомдоосонгүй  
Хэн нэгнийдээ ирж, даалгавраа хамт хийнэ.  
Тоолбол нас чацуу, төөлбөл бие чацуу

Цэцэгийн хийсэн үйл



- сайн сурдаг хэвээрээ
- найзын төлөө санаа зовж эхлэв.
- ...муу тусаллаа гэж боджээ.
- Найз нь бодоод өгье.
- нэгд нэгэнгүй бодож өгөв.
- тоог бодож өгдөг болов.
- ...үнэнч найз түүнд тусална.
- өөрийнхөө тоог хагас дутуу бодоод,
- найздаа туслах ажилд оров.
- Эхний тоог бодоод,
- дэвтрийнхээ доогуур сэмхэн гулгуулсанд...

Чимэгийн үйлдлийг чи юу гэж бодож байна вэ? Дүгнээрэй.

- ...тооны хичээлд тааруухан болж,
- Цэцэг уруу царайлж сууна.
- Амжаагүй.
- Цэцэг “сайн” дүн авчээ.
- ...даалгавар хийлгүй ирээд
- дэвтрээс шууд хуулдаг болов.
- өрөвдөлтэй хүүхэд байсангүй.
- Найз аа, минийхийг бодоод өгөөч!

Цэцэгийн үйлдлийг чи юу гэж бодож байна вэ? Дүгнээрэй.

1 Ярилцаарай.

- Багш: Найздаа ингэж тусалж болохгүй. (Багш яагаад ингэж хэлсэн бэ?)
- Хоёр найз ичихийн ихээр ичив. (Хоёр найз яагаад ичсэн бэ?)


2 Баатруудын хэлэх үгийг өөрчлөн ярилцаарай.



Хэрэв би Чимэг байсан бол?



Хэрэв би Цэцэг байсан бол?

 В. “Найзууд” эхийн эхлэл хэсэг аль нь вэ? Яагаад тэгж бодож байгаагаа тайлбарлаарай.

Эхийн эхлэл



Чимэг Цэцэг хоёр таван жил үерхжээ. Сургуульд орсон өдрөө нэг ширээнд сууснаас хойш ганц ч удаа бие биеэ гомдоосонгүй.

Чимэг Цэцэг хоёр таван жил үерхжээ. Сургуульд орсон өдрөө нэг ширээнд сууснаас хойш ганц ч удаа бие биеэ гомдоосонгүй. Тэд хаана ч хамт явна. Хичээл тарсан хойно хэн нэгнийдээ ирж, даалгавраа хамт хийнэ.





Г. Эхийг уншаад, "Эхлэл, гол, төгсгөл хэсэг"-ийн ялгааг ярилцаарай.

### Миний найз

#### Эхлэл хэсэг:

Хэний, юуны тухай өгүүлэх вэ? гэдгээ танилцуулна.

#### Гол хэсэг:

Үйл явдал өрнөнө. Эхний санааг дэлгэрүүлнэ.

#### Төгсгөл хэсэг:

Эхлэл, гол хэсгийг дүгнэнэ.

Үнэнийг хэлэхэд надад олон сайн, үнэнч найз бий. Гэхдээ Энэрэл миний хамгийн сайн найз, **Эхэд Энэрэлийн тухай өгүүлнэ гэдгээ танилцуулжээ.**

Энэрэл бид хоёр дөрвөн жил гаруй найзалж байна. Тэр 12 настай. Найз маань хөгжмөөр, усан спортоор хичээллэдэг тул үнэхээр эрүүл, чийрэг биетэй.

Миний найз шулуун, урт, хүрэндүү үстэй, тунгалаг бор нүдтэй, урт сормуустай бөгөөд үргэлж дэгжин хувцасладаг. Ер нь найз маань хэзээд үзэсгэлэнтэй харагддаг. Энэрэл бол хүмүүжилтэй, хөгжилтэй, сайхан сэтгэлтэй охин.

**Энэрэлийг хэн бэ? гэдгийг дэлгэрүүлэн бичжээ.**

Энэрэл бол миний жинхэнэ сайн найз. Би найзаараа бахархдаг.

**Энэрэлийг жинхэнэ найз, бахархдаг зэргээр дүгнэж төгссөн байна.**



Д. Энэрэл ямар хүүхэд вэ? гэсэн асуултад хариулагдах үгсийг эхээс түүж бичээрэй.

Жишээ нь:

Шулуун, урт, хүрэндүү үстэй



Е. "Миний найзтай танилц" сэдвээр найзыгаа тоочин танилцуулж бичээрэй.



- Найзын зан араншин, царай төрх, хүсэл мөрөөдөл, авьяас
- Найзын тухай сонин сайхан дурсамж
- Найздаа хэлмээр байгаа үг, сэтгэгдэл

#### Бичихдээ дараах үгсээс ашиглаарай.

**нүд:** бор, хар, онигор, алаг, бүлтгэр, торомгор

**хөмсөг:** өтгөн, нарийхан, өргөн, гоё

**үс:** богино, урт, хүрэн, өтгөн, буржгар, шулуун, долгионтой, хөвсгөр, шингэн

**чих:** дэлдэн, хулгар, жижиг, том

**хамар:** намхан, шулуун, монхор, шонтгор, өндөр

**уруул:** зузаан, нимгэн, булбарай, цорвогор

## ДАСГАЛ 5



А. Дараах хэсгүүдийн аль нь хүсэл мөрөөдөл, аль нь зорилго, аль нь үйл ажиллагаа вэ? гэдгийг ярилцаарай.

Хүн хүсэл мөрөөдөлтэй байх хэрэгтэй. Түүнийгээ зорилго болгож, зорилгоо үйл ажиллагаагаар хэрэгжүүлснээр чиний хүсэл мөрөөдөл биелнэ.

Би алдартай зохиолч болохыг мөрөөддөг.

Би хэлний чадвараа хөгжүүлнэ.

### Би

1. Эхлээд багшаасаа зөвлөгөө авна.
2. Хүүхдийн зохиолын номуудыг уншиж дуусгана.
3. Зохион бичлэгийн уралдаанд оролцоно.
4. Зохиол бичих дугуйланд суралцана.

1 Алдартай зохиолч болохын тулд өөр юуг нэмж хийж болох вэ? Бичээрэй.

Мөрөөдөл бол зөвхөн хийсвэр бодож, хүсэж байгаа зүйл. Зорилго бол мөрөөдлөө биелүүлэхийн төлөө хийж буй бодит алхам.

2 Анхааралтай уншаарай.

**Хувийн төлөвлөгөө гаргахын тулд:**

Би юуг хүсэж, мөрөөдөж байна вэ?

Түүнийгээ яаж хэрэгжүүлэх вэ?

Хэзээ, яаж хийх вэ?

Зорилгоо тодорхойлно.

Юу хийхээ төлөвлөнө.

Сар, өдөр, цагаа товлон.



Б. Хоёр хүүхдийн яриаг харьцуулж, уншаарай.



Юу хийх вэ?  
Уйдаад байх юм.

Юу хийх вэ?  
Өнөөдөр би ном унших ёстой.



Найзуудтайгаа тоглох уу? Эсвэл хичээлээ хийх үү?

Яагаад гэвэл би энэ жил монгол хэлний хичээлдээ сайн болох зорилго тавьсан.



Хичээл тараад 3 цаг болсон байна. Би нэг сууж, нэг босож, орж гарч байтал ийм олон цаг өнгөрсөн гэж үү?

Зорилгодоо хүрэхийн тулд төлөвлөгөө гаргасан. Манай гэр бүл намайг дэмжиж тусалдаг.



Хичээлээ хийх үү? Тоглоом тоглох уу? Зурагт үзэх үү? гэж бодож суутал дахиад 2 цаг өнгөрчээ.



Үгийн утгыг мэдье

**зорилго** - Алсын ирээдүйд хүрнэ гэсэн эрмэлзэл

**төлөвлөгөө** - Хийж гүйцэтгэх ажлын урьдчилсан жагсаалт

**уйдах** - Уйтгарлах, дургүй болох

*“Монгол хэлний хураангуй тайлбар толь”-оос*

1

Асуултын дагуу ярилцаарай.

- ✓ Хоёр хүүд хэн гэж нэр өгөх вэ?
- ✓ Аль хүүхдийн ярианаас чи юуг ойлгож байна вэ?
- ✓ Чиний зорилго юу вэ? Зорилгодоо хүрэхийн тулд юу хийж байна вэ?
- ✓ Хоёр хүү тус бүрд юу гэж хэлмээр байна вэ?



В. Чи өнөөдөр юу хийж амжуулах вэ? Өдрийн ажлаа төлөвлөдөг үү? Дараах өглөөний төлөвлөгөөг уншаарай.

### Миний өглөөний төлөвлөгөө:

- ✓ 7:15 сэрэх
- ✓ 7:15 - 7:17 ороо хураах
- ✓ 7:17 - 7:20 гурван аяга ус уух, витамин "D" уух
- ✓ 7:20 - 7:30 усанд орох
- ✓ 7:30 - 7:40 хувцсаа өмсөж, сургуульдаа явахад бэлтгэх

### Миний өдрийн төлөвлөгөө:

- Өглөө юу хийх вэ?
- Өдөр юу хийх вэ?
- Орой юу хийх вэ?



Г. Нэг өдрийн төлөвлөгөө зохиож бичээрэй.

- Төлөвлөгөө зохиохдоо дараах өдрийн дэглэмээс санаа аваарай.

## ӨДРИЙН ДЭГЛЭМ

### ӨГЛӨӨ



### ӨДӨР



### ОРОЙ



### АМРАЛТЫН ӨДӨР



## II БҮЛЭГ. ГЭР БҮЛ

### ДАСГАЛ 1

А. Харилцан яриаг хосоороо уншаарай.

□ Үг, үеийг зөв хэлээрэй. Асуулт хариултыг уншихдаа дууны өнгөө тохируулаарай.



Сайн байна уу? Айна



Сайн, сайн байна уу? Мурат



Чамд дүү нар бий юу?



Тийм ээ, би хоёр дүүтэй.



Өө, ямар сайхан юм бэ? Чи тэдний тухай надад ярьж өгөөч.



За. Нэг дүүгийн нэр Хабдолда. Тэр тийм ч өндөр биш. Дүү маань долоо хоногт хоёр удаа иог, усан спортоор хичээллэдэг тул бие галбир нь үнэхээр эрүүл, чийрэг, тэгш сайхан. Харин бага дүү Сауле маань авхаалжтай, өгөөмөр сайхан сэтгэлтэй.



Та гурав маш хөгжилтэй байдаг байх даа.



Тийм ээ, тэдэнтэй байхад хөгжилтэй шүү. Харин чи өөрийнхөө гэр бүлийн талаар ярина уу.



Харин би нэг ахтай. Тэр мэддэг чаддагаа бусадтай хуваалцах дуртай, бусдад чин сэтгэлээс тусалдаг.



Чамд маш их баярлалаа. Ярилцсандаа таатай байна.



Дараа хоёулаа ярилцана аа. Баярлалаа.



Б. Хос хосоороо гэр бүлийнхээ талаар ярилцаарай. Ярихдаа санаа аваарай.

Энэ миний аав Баяраа. Аав маань мужаан. Тэр хүчтэй, зоригтой, бид хоёр хөл бөмбөг тоглох дуртай.



Намайг Баяраа овогтой Билгүүн гэдэг. Энэ бол миний гэр бүл. Манайх 5 ам бүлтэй.

Ээж минь гоё хоол хийдэг, сайхан сэтгэлтэй.



В. Хэн олон, сонирхолтой асуулт зохиох вэ? тэмцээн зохион байгуулаарай.

Хүнтэй харилцан ярилцахад оновчтой асуулт тавьж сурах нь маш чухал.

1 Дараах зургийн үйл явдлыг сайн харж асуулт зохиогоорой.

- Багийн гишүүн бүр 5, 5 асуулт зохиох
- Зохиосон асуултаа хосоороо ярилцан, санал нийлсэн 5 асуултаа сонгох
- Хосоороо ярилцаж сонгосон асуултыг багаар хэлэлцэж, 5 асуулт сонгох

2 Асуултынхаа дагуу ярилцаарай.



3 Асуултыг ашиглаарай.

- ✓ Яагаад ..... -даг вэ?
- ✓ Ямар учраас .....?
- ✓ Хэрэв .....?
- ✓ Чи хэрхэн ..... -х вэ?



А. Дараах хэсгийг уншаад, өдрийн тэмдэглэл хөтлөх нь ямар хэрэгтэй талаар ярилцаарай.



### Өдрийн тэмдэглэлээс

Хүн өдрийн тэмдэглэлдээ "Өөрийгөө хэрхэн хөгжүүлэх вэ?, Миний зан чанарт ямар дутагдал байна вэ? Түүнийг яаж засаж өөрчлөх вэ?" зэргээр зорилго тавьж, өөрийнхөө яаж өөрчлөгдөж байгааг бичээд явж болно.

...Би өдрийн тэмдэглэлээ сэтгэл зүрхнийхээ хамаг нууцыг дэлгэж болох хамгаас итгэлт анд найзаа болгох гэсэн юм. Үнэхээр өдрийн тэмдэглэл чам шиг хамаг бүхнээ итгэн ярих тийм найз надад алга даа.  
(Анна 1944 он.)

- 1 Өдрийн тэмдэглэлийг "Сэтгэл зүрхнийхээ хамаг нууцыг дэлгэж болох хамгаас итгэлт анд найз"-аа гэж нэрлэсэн учрыг тайлбарлаарай.
- 2 Өдрийн тэмдэглэлийг уншаад, асуултад хариулж бичээрэй.

2021 оны 07 сарын 20

Баян-Өлгий аймаг, Цэнгэл сум

Би ээж, аавтайгаа хөдөө байдаг найзындаа ирээд хэд хонолоо. Тэднийх долоон хүүхэдтэй. Том охин нь надаас хоёрхон насаар эгч. Дүү нар нь цөөн насны зөрөөтэй ч том эгчийнхээ үгэнд сайн орох юм. Эгч нь юу л гэж хэлнэ, уриалгахан нь аргагүй "За, эгч ээ" гээд гүйлдэнэ. Энэ харилцаа надад гайхалтай сайхан санагдаж байна.

Тэд маш завгүй, өглөөнөөс орой болтол ажиллана. Орой бүгдээрээ цуглан, ширээгээ тойрч суугаад хоолоо идэхдээ хөгжилтэй зүйлийг ярьцгаана. Тэд бидэн шиг өрөөнийнхөө хаалгыг хаагаад таг чимээгүй болдоггүй. Бусдыгаа үл тоож, гар утсаараа оролддоггүй.

Гэртээ бүгдээрээ эвтэй, хөгжилтэй байх нь үнэхээр биширмээр байна.

- ✓ Өдрийн тэмдэглэлд он, сар, өдөр бичихийн учрыг юу гэж бодож байна вэ?
- ✓ Зуны амралтаараа бичсэн өдрийн тэмдэглэлд юуг онцолж бичсэн байна вэ?
- ✓ Аль үг, өгүүлбэрээс чамд ямар сэтгэгдэл төрж байна вэ?

- 3 Дараах өгүүлбэрийг гүйцээж бичээрэй.

...гайхалтай сайхан санагдаж байна.

Бусдыгаа үл тоож...


Ширээгээ тойрч суугаад...



Б. Ураг удмын бүдүүвчийг тайлбарлаж ярилцаарай.

1 Өгсөн үгсээс сонгож, асуултад хариулж бичээрэй.

### Ураг удмаа нэрлэж суръя



2 Гэр бүл, ураг удмынхаа хүмүүсийг танилцуулсан бүдүүвч зураарай.



В. Алдаатай үгийг олж, зөв болгож бичээд, дүрмийг хэлээрэй.

- Бид бие биеэ ойлгдог.
- Би аав ээжээсээ зөвлгөө авдаг.
- Би дүүгээ цэцрлэгт хүргж өгдөг.
- Миний өвгө дээдс ухаантай.
- Ахынхаа мэдсн сурсныг би хүндэлдэг.


А. Зургийг хараад ямар шүлэг болохыг сэргээн санаж, цээжээр уншаарай.

Гэр бүл

	МИНЬ		уудам	
	МИНЬ		цэлмэг	
	МИНЬ		ханагар	
	МИНЬ		гэрэлт	
	МИНЬ		ургаа	
	МИНЬ		гоёхон	
	МИНЬ		бөжин	
			өөрөө ганган	

1 Шүлгийн мөр бүрийг асуултын дагуу ярилцъя.

- ✓ Шүлэгт хэн хэнийг юу юутай зүйрлэсэн бэ? Яагаад ингэж зүйрлэсэн бэ?
- ✓ Жишээ нь: Өвөөг “Уудам тал” гэжээ. Учир нь өвөө уужим ухаантай.



2 Шүлгээ уран уншаарай. Уншихдаа юуг юутай зүйрлэснийг сэтгэлдээ сайн төсөөлж бодоорой.




### Шүлгийг уран уншихдаа:

- 👉 Үгийг ойлгомжтой, тод хэлнэ.
- 👉 Цэг, таслалыг ялган зогсолт хийнэ.
- 👉 Утга агуулгыг илэрхийлэн уншина.

3 Шүлгээ дэвтэртээ цээжээр бичээрэй.  
Бичсэнээ найзтайгаа дэвтрээ сольж уншаад, үгийн алдаагаа засаарай.



Б. Зургийн үйл явдлыг анхааралтай ажиглаарай.



“Миний гэр бүл” сэдвээр 6 мөрт шүлэг зохиож бичээрэй.





А. Хурдан, ойлгож уншъя. Минутын уншлага хийгээд, өөрийгөө үнэлээрэй.

Үгийн тоог тэмдэглэв.

### ЭРЭЭН АЛЧУУРТ



Нэгэн удаа түүнд айлынх нь хүн шүүдрийн дусал түүн, ээждээ цай чанаж өгвөл ачийг нь хариулж болох тухай **ярьжээ**. Эрээн алчуурт өглөө эрт босож, хувин аваад цэцэгт хөндийг **зорив**. Ямар гоё вэ? Шүүдрийн ус ийм их байхад хувин дүүргэх юухан байх вэ!

Бушуухан түүж ээждээ цай чанаж өгье гэж **яарна**. Гэвч жимс түүхээс ч хэцүү ажээ. Түүж түүж харахад савны ёроол хэвээрээ. Тэгэхээр эхийн ачийг хариулна гэдэг тийм ч амар юм биш байх нь. Эрээн алчуурт ядарч нэг мэдэхэд **унтчихжээ**. 73

Хэрэв зөгий алчуурыг нь цэцэг гэж андуурч буугаагүй бол хэдий болтол унтах байсныг бүү мэд. Эрээн алчуурт **уйллаа**. Ээжийнхээ ачийг хариулж чадахгүй нь гэж бодохоос нулимс нь аяндаа шүүдрийн дусал шиг **бөмбөрч байлаа**. 103

Яая гэх вэ, хоосон савтайгаа гэрийн зүг эргэтэл нэг чоно **зогсож байлаа**. Эрээн алчуурт “Ээж ээ” гээд хашхиран **зугтлаа**. Тэр агшинд Эрээн алчуурт руу дайрсан чоно гэнэт эргэн цэцэгт талын дундуур бараа сураггүй **алга болов**. 135

Ээж нь охиноо үгүйлэн гэрээс **гүйж гарлаа**. Тал руу саравчлан хартал цэцэгнээс ялгаагүй эрээн алчуурт охин “Ээж ээ” гэсээр ирж байлаа. Ээж охин хоёр тэврэлдэн **уулзав**. 158

“Эвий бяцхан охин минь ээждээ хүрээд ирсэн хойно шүүдрийн дуслаар чанасан цайг чинь ууснаас ялгаагүй” гээд охиноо **үнсэв**. Нийт үг: 174

(Ж.Дашдондог)

Өөрийгөө үнэлээрэй:

1 минутад уншсан үгийн тоо

Амандаа үглэж уншсан уу?

Нүдээрээ гүйлгэн уншсан уу?



#### Үгийн утгыг мэдье

**шүүдрийн дусал** - өвсний толгойд тогтсон жижиг усан дусал

“Сурагчийн монгол хэлний хураангуй тайлбар толь”-оос

1 Дараах өгүүлбэр тус бүрд асуулт зохиогоод, уншаарай.


- ... шүүдрийн дусал түүн, ээждээ цай чанаж ...
- ... эрт босож, хувин аваад цэцэгт хөндийг зорив.
- Гэвч жимс түүхээс ч хэцүү ажээ.
- Эрээн алчуурт уйллаа.
- ... чоно гэнэт эргэн цэцэгт талын дундуур бараа сураггүй алга болов.
- ... шүүдрийн дуслар чанасан цайг чинь ууснаас ялгаагүй.

2 Ярилцаарай.

- ✓ Охины үйлдлээр түүнийг ямар хүүхэд вэ? гэдгийг дүгнээрэй.
- ✓ Охины үйлдэл чиний сэтгэлийг хөдөлгөсөн үү? Яагаад вэ?



Б. Дараах хоёр зургийг харьцуулж хараад, яагаад “... нулимс нь аяндаа **шүүдрийн дусал шиг бөмбөрч байлаа**” гэж дүрсэлсний учрыг тайлбарлаж бичээрэй.



В. Эхэд тодруулсан үйл үгийн нөхцөлийн утгыг сайтар бодоорой. Охины үйлдэл “Одоо, өнгөрсөн, ирээдүй” аль цагт болж байна вэ? Үйл үгийн жишээгээр яриарай.



- ярь**жээ**.
- зорив**.**
- яар**на**.
- унтчих**жээ**.
- уйл**лаа**.
- бөмбөрч бай**лаа**.
- зугт**лаа**.
- алга боло**в**.
- гүйж гар**лаа**.
- уулзав**.**
- үнсэ**в**.



Монгол хэлэнд цаг заадаг нөхцөл байдаг.

- Ирээдүй цагийн утга заасан нөхцөл: -на (-нэ,-но,-нө)
- Одоо цагийн утга заасан нөхцөл: -на (-нэ,-но,-нө)
- Өнгөрсөн цагийн утга заасан нөхцөл: -жээ (-чээ), -лаа (-лээ, -лоо, -лөө), -в



Г. Эхийн "Эхлэл, гол, төгсгөл" хэсгийн ялгааг анхаарч уншаарай.



## ТОМ БОЛСОН НЬ

"Эхлэл хэсэг"  
мөн эсэхийг  
ярилцаарай.

"Гол хэсэг"  
мөн эсэхийг  
ярилцаарай.

Жижигхэн Хулан том болохыг маш их мөрөөддөг байв.

Яаж том болохыг мэдэхгүй байсан тул ээжийнхээ өсгийтэй гутлыг, эмээгийнхээ цамцыг өмслөө. Үсээ эгчийнхээ үс шиг янзалж, бугуйн цаг зүүлээ.

Гэвч том болсонгүй. Бүгд түүнийг хараад инээлдэж байв.

Нэг өдөр Хулан гэрээ цэвэрлэхээр шийдэж, цэвэрлэж гарлаа. Гэр нь цэв цэвэрхэн болсон байв. Ээж нь гайхаж:

-Манай Хулан том болсон байна даа гэв. Өдрийн хоолны дараа Хулан бүх аяга тавгийг угааж цэвэрлэв. Тэдний гэр бүлийнхэн Хуланг хараад үнэхээр гайхав. Бүгдээрээ:

"Төгсгөл хэсэг"  
мөн эсэхийг  
ярилцаарай.

Бид Хулангийн ямар том болсныг анзааралгүй явсан байна даа. Гэрээ цэвэрлээд, бас аяга таваг угааж чаддаг болсон байна гэв.

Одоо бүгд жижиг Хуланг том Хулан гэж дууддаг болсон байна.

1

Асуултад хариулж ярилцаарай.

- ✓ Хулан ээжийнхээ гутлыг ямар учраас өмссөн бэ?
- ✓ Ээж нь Хуланг гутал, цамц өмсөхөд том болсон гэж хэлээгүй мөртлөө гэрээ цэвэрлэхээр "Том болсон байна даа" гэж хэлсний учир юу вэ?
- ✓ Тэдний гэр бүлийнхэн Хуланг хараад гайхсан учир нь юу вэ?
- ✓ Хулан яаж том болсон бэ?
- ✓ Чи "жижигхэн" хүүхэд, "том" хүүхэд хоёрын аль нь вэ? Яагаад вэ?



Д. Өгүүлбэрийг утгаар нь зөв харгалзуулаарай.

Хулан гэрээ цэвэрлэсэн тул...

Хулан бүх аяга тавгийг угааж цэвэрлэсэн тул...

Тэр гэрээ цэвэрлээд, бас аяга таваг угааж чаддаг болсон.

Гэр бүлийнхэн үнэхээр гайхав.

Бүгд том Хулан гэж дууддаг болсон.

Ээж нь гайхсан.




Е. "БИ ТОМ БОЛСОН" сэдвээр бусдадаа илтгээрэй.

### ЧИ ХЭР ТОМ БОЛСОН БЭ?

"Би том болсон" сэдвээр яриарай.  
Зургуудаас санаа аваарай.  
Ярих төлөвлөгөө гаргаарай.



- Өөртөө итгэлтэй ярих
- Дууныхаа өнгийг тохируулах
- Чин сэтгэлээсээ ярих



# III БҮЛЭГ. ЭРДЭМ НОМ

## ДАСГАЛ 1



А. Эхийг уншаад утгыг ярилцъя. Асуулт, хариултыг уншихдаа дууны өнгө, аялгаа тохируулаарай.

### Ямар насанд эрдэм сурвал сайн бэ?

Багш: Өчүүхэн насанд эрдэм сурваас юутай адил вэ?

Хөвгүүн: Өчүүхэн насанд эрдэм сурваас шинэ ургах наран мэт.

Багш: Дунд насанд эрдэм сурваас юутай адил вэ?

Хөвгүүн: Дунд насанд сурсан эрдэм үдийн наран мэт.

Багш: Их болсон хойно эрдэм сурваас юутай адил вэ?

Хөвгүүн: Их болсон хойно эрдэм сурваас үдэш мэт.

Багш: Өтөл насанд эрдэм сурваас юутай адил вэ?

Хөвгүүн: Өтөл насанд эрдэм сурваас харанхуй шөнө мэт.

*"Хар үхэрт хөвгүүний тууж" сургаал зохиолоос*

Чи аль насандаа байна вэ?

Өчүүхэн нас	12 нас хүртэл
Дунд нас	35 нас хүртэл
Их нас	60 нас хүртэл
Өтөл нас	60 наснаас дээш

### Үгийн утга мэдье

**ӨЧҮҮХЭН НАС** - Юмны хэмжээ маш бага, жижигхэн (өчүүхэн бага, өчүүхэн жижиг, өчүүхэн цас унах)

**ӨТӨЛ НАС** - Хөгширч нас ахисан байдал

*"Монгол хэлний хураангуй тайлбар толь"-оос*

1 Үгс тус бүрээр хоёр өгүүлбэр зохиож, үгийн утгыг бодъё.

өчүүхэн, өтөл



Б. Дараах хоёр эхийг уншаад, юу ойлгосноо бичээрэй.



Өчүүхэн насанд эрдэм сурвал

Шинэ ургах нар мэт.

Дунд насанд эрдэм сурвал

Үдийн наран мэт.

Их насанд эрдэм сурвал

Үдэш мэт.

Өтөл насанд эрдэм сурвал

Харанхуй шөнө мэт.



...Тустай болгон эрдэм ...

Мал маллаж сурсан ч эрдэм.

Машин жолоодож сурсан ч эрдэм.

Ном бичиг сурсан ч эрдэм.

Ногоо тарьж сурсан ч эрдэм.

Хоол хийж сурсан ч эрдэм.

Хог арилгаж сурсан ч эрдэм.


*(Л.Хуушаан)*



В. "Эрдэм номын ач тус" сэдвээр хэлэлцье.

**Баг болоод хэлэлцүүлэгт бэлдье.**

1. "Эрдэм номын ач тус" сэдвээр санаа бодлоо илэрхийлэхийн тулд жишээ сайн бичиж бэлдээрэй. Жишээ баримтгүй бол чиний яриа итгэл үнэмшил багатай болно. Баримтыг хаанаас олж болох вэ?



2. Сэдвийн хүрээнд бусад багаас асуух 2 асуулт зохиогоорой.

- Найз нараа анхааралтай сонсьё. Энэ маш чухал.



Бусдын яриаг бүү тасал. Саад бүү болоорой.



Найзынхаа нүүр, нүд рүү нь харж сонсоорой.



Ярьж байгаа найз руугаа толгой дохиж, инээмсэглээрэй.



Асуулт асуугаарай.

1. Өөрийнхөө санаа бодол, сэтгэгдлээ илэрхийлж яриарай. Энэ маш чухал. Жишээг уншаарай.

Миний бодлоор: Хүн эрдэм номыг сайн сурвал гэр бүл, аав ээжийнхээ ачийг хариулж, эх орныхоо хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулдаг.

Би багадаа үлгэрийн ном их уншдаг байсан болохоор миний үгийн сан их баян. Тиймээс би их сайн ярьж, бичиж сурсан.

Ээж маань цагаан идээг их цэвэрхэн, амттай сайхан боловсруулдаг. Би ээждээ тусалсаар маш сайн сурсан гэж бодож байна.

2. Сэтгэгдлээ илэрхийлэхдээ дараах үгсээс ашиглаарай.



- Минийхээр бол...
- Надад ... санагдаж/бодогдож байна.
- Миний бодлоор бол...
- Би ... гэж бодож байна (итгэх, бодох)
- Надад өөр санал байна.
- Би үүнийг хэлж чадахгүй...

## ДАСГАЛ 2



А. Бид өмнө нэг өдрийн төлөвлөгөө бичсэн. Төлөвлөснөө биелүүлж чадсан уу? 2-3 өгүүлбэрээр хариулж бичээрэй.



### АМЖИЛТАА ТӨЛӨВЛӨӨ

Чиний хүсэл мөрөөдөл юу вэ?

Хүсэл мөрөөдлөө зорилго болгоё.

Зорилгоо биелүүлэхийн тулд төлөвлөгөө гаргая.

Төлөвлөгөөний хугацаа:

өдөр

7 хоног

сар

улирал

жил



Б. Хоёр сурагчийн 7 хоногийн төлөвлөгөөтэй танилцъя.

Данагийн төлөвлөгөө:

**Зорилго:** Монгол хэлээ сайн сурна.

Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням
Нэг цаг монгол нэвтрүүлэг үзнэ.		Номын санд сууж, монгол ном уншина.		Нэг цаг монгол нэвтрүүлэг үзнэ.	Нэг цаг монгол нэвтрүүлэг үзнэ.	

✓ Өдөр бүр 5-8 шинэ үг цээжилнэ.

✓ Найз нөхөдтэйгөө монгол хэлээр ярилцана.

Сарангийн төлөвлөгөө:

**Зорилго:** Өөртөө цаг гаргах

**Хугацаа:** 2022 оны 6 сарын 20-26

хийх ажил

- Өглөөний цайгаа тогтмол уух
- Гэр бүлээрээ салхинд гарах
- Морь унаж сурах
- Бясалгал хийх

хугацаа

- өдөр бүр
- ням гараг
- пүрэв, бямба гараг
- өдөр бүр

1

Дана Саран хоёрын төлөвлөгөөний ижил ба ялгаатай талыг гаргаж бичээрэй.





В. Долоо хоногийн төлөвлөгөө бичиж, нөхдөдөө танилцуулъя.

1 Бие биедээ төлөвлөгөөнийхөө зорилгыг хэлье.

Зорилго:  
-----

-----

-----

2 Хүүхдүүдийн өөрийгөө хөгжүүлэх зорилгоос харъя.

Зурах чадвараа хөгжүүлэх

Зөв хооллоход сурах


Гадаад хэл сурах

Гар утаснаас татгалзах

Спортоор хичээллэх


Гэрийнхэндээ туслах

3 Зорилгодоо хүрэх үйл ажиллагааг уншъя.




Үг цээжлэх, ном унших, бичлэг сонсох, орчуулга хийх

Гадаад хэл сурах




Гар утсаа хол байлгах, утас хэр их хэрэглэж байгаагаа хянах

Гар утаснаасаа татгалзах



Гэр орноо цэвэрлэх, дүүгээ харах, аяга таваг угаах

Гэрийнхэндээ туслах



Дасгал хөдөлгөөн хийх, дугуйланд явах

Спортоор хичээллэх

4 7 хоногийн төлөвлөгөөгөө нөхдөдөө танилцуулъя.

- Яриагаа сонирхолтой болгохын тулд санаа аваарай.
  - Өөрийнхөө ирээдүйн хүсэл мөрөөдлөө хэлээрэй. Хүсэл мөрөөдлөө ямар нэг зүйлтэй зүйрлэж, жишээ нь үзсэн киноныхоо баатартай холбож ярьж болно.
  - Яагаад ийм зорилго сонгосон бэ? гэдгээ яриарай. Өөрт тохиолдсон үйл явдалтай холбож ярьж болно.
  - Зорилгодоо хүрэхийн тулд юу хийх вэ? гэдгээ яриарай.
  - Сэтгэл хөдлөлөө илэрхийлж ярьж болно.



А. Дууны шүлгийг уншиж, утгыг нь мэдэхгүй үгсийг мэдэж авъя.

### Сургууль минь амархан сайн байна уу?

Ариун эрдмийн шимийг хүртэхээр  
Андуудтайгаа алхаж ирэхэд минь  
Алтан хаалгаа нээсэн миний өргөө  
Алгаа тосоод угтсан миний багш аа

Дуулъя, дуулъя багшаа дуулъя.  
Дурсамж үлдээх сургуулиа дуулъя.  
Ай хө, зэ хө бидний ордон  
Ачтай сургууль минь амархан сайн байна уу.

Номтой багшийн эрдмээс өвөрлөхөөр  
Наргиантай явсан өдрүүд минь  
Найзын минь үлдээсэн дурсамж  
Намхан ширээнд минь шингэн үлдэнэ.



### Үгийн утга мэдье

**ариун** – хир буртаггүй, цэвэр тунгалаг

**шим** – үр шим, ашиг тус

**хүртэх** – “авах” гэсэн үгийн хүндэтгэлийн утга

**анд** (андууд) – итгэлт нөхөр

**наргиан** – хөгжөөн цэнгэл

*“Монгол хэлний хураангуй тайлбар толь”-оос*



Б. Шүлгийн мөр бүрийн утгыг асуултын дагуу ярилцаарай.




“Ариун эрдмийн шим хүртэх” - Эрдэм номыг яагаад “ариун” гэж хэлсэн юм бол?

“Эрдмийн шимийг хүртэх” - “Яагаад шим”, “хүртэх” гэсэн үгийг сонгосон бол?

“Алтан хаалгаа нээсэн миний өргөө” - Сургуулийн хаалгыг яагаад “алт”-тай зүйрлэсэн юм бол? Мөн зарим шүлэгт сургуулийн “алтан босго” гэсэн байдаг.

Сургуулиа өөр юутай зүйрлэж болох вэ? Яагаад вэ?





**“Алгаа тосоод угтсан** миний багш аа” – Багш минь биднийг ямар байдлаар угтсан бэ?

**“Үзэг барьсан амьд бурхан**

Үгүйлэн санах миний багш та” гэж өөр нэг шүлэгт багшийг дүрсэлсэн байдаг. Багшийг яагаад бурхантай зүйрлэдэг вэ? Та нар юу гэж бодож байна вэ?



**В. Шүлгийнхээ утгыг мэдсэн бол шүлгээ цээжлээд, уран уншъя.**

### Шүлгийг уран уншихдаа:



- 👉 Дууны шүлгийг хоёр хоёр мөрөөр давтан уншъя.
- 👉 Шүлгээ уран уншихад ямар хөдөлгөөн хийж болохыг бодъё.
- 👉 Утгыг нь ойлгож, цээжилсэн шүлгээ уран уншъя.
- 👉 Шүлгийн хаана зогсолт хийх, ямар хурдаар унших, дууны өнгө ямар байх зэргийг бодоорой.
- 👉 Нэг гол анхаарах юм бол шүлгийн үг, өгүүлбэрийг тод, зөв дуудах хэрэгтэй шүү.

Шүлгээ уран уншиж байгаа найз руугаа инээмсэглэж, толгой дохиж, түүнийг дэмжээрэй.



**Г. Дараах дурсамжийг уншиж, санаа аваад, нэгдүгээр ангид орсон тухайгаа товч дурсаж бичээрэй.**

### Нэгдүгээр ангид орсон минь

Тэр жилийн 9 дүгээр сарын 1-ний өглөө ааваараа хөтлүүлэн анх удаагаа сургуульдаа ирэхэд нарлаг сайхан өдөр байв. Сургуулийн гаднах талбайд олон хүүхэд бужигналдан, дуу шуу ихтэй.

Сургуулийн хаалгаар ороход бүх юм цоо шинэ, гял цал, уужим цэлгэр байв. Ангид ороход хана туурга, ширээ сандал, самбар цонх гээд юм бүхэн цэвэр цэмцгэр, өнгөлөг гэгээлэг. Багш намайг хамгийн урд талын ширээнд, ханан талд суулгав.

**1** Үгсээр өгүүлбэр зохиож бичээрэй.

гял цал

өнгөлөг гэгээлэг

уужим цэлгэр

цэвэр цэмцгэр



А. Үлгэрийг уншаарай. Үлгэрийг уншихад дууны өнгө ямар байх вэ? Яаж уншвал найз нартаа ойлгомжтой, тод унших вэ? гэдгээ бодоорой.



**Эрдэм сурсан нь**

Эрт цагт элээ чогчиго хоёр дуу сурахаар алсын алсад явах болжээ. Нисэн ниссээр зорьсон газраа хүрч гэнэ.

Тэгээд ээрэм их талд нэгэн чулуун дээр сууж эрдэм сурч эхэлжээ. Гэтэл элээний нойр нь хүрээд унтаад өгчээ. Энэ хугацаанд чогчиго уйгагүй оролдсоор маш их зүйл сурч авчээ. Харин элээ гэнэт сэртэл эхээсээ төөрсөн унаганы янцгаах дуу сонсогдож байжээ. Элээ зөвхөн түүнийг сурчээ.

Ийнхүү чогчиго их зүйл сурч, олон янзаар дуугарч байхад элээ зөвхөн унага шиг дуугардаг болсон юм гэнэ.



**Үгийн утга мэдье**

**ээрэм их тал** – эзгүй тал газар

**төөрөх** – зүг чигээ алдах

**янцгаах** – адуу ижил сүргээ эрэх зэрэгт хангинатал уртхан дуу гаргах  
 “Монгол хэлний хураангуй тайлбар толь”-оос

1 Эхийг задлан ярилцъя. Элээ, чогчигын хийсэн үйл бүрийг ялгаж бичээрэй.

Элээ яав?

Сурахаар, явах болжээ.  
 Нисэн ниссээр, хүрч гэнэ.  
 .....

Чогчиго яав?

Сурахаар, явах болжээ.  
 Нисэн ниссээр, хүрч гэнэ.  
 .....

2 Чогчиго элээ хоёрын хийсэн үйлийг өөрийн үгээр дүгнэж яриарай.



- Миний бодлоор, чогчиго  
 .....

- Миний бодлоор, элээ  
 .....

- Миний бодлоор, элээ  
 .....

- Миний бодлоор, чогчиго  
 .....



3 Үлгэрээс ямар сургамж авсан бэ? 1-2 өгүүлбэрээр бичээрэй.



Б. Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсэгт нэр өгөөрэй.

Эхлэл

.....

Гол

.....

Төгсгөл

.....

1 Эхийн гол санааг илэрхийлсэн зүйр цэцэн үг аль нь вэ?

а. Оролдлого сайт оройд нь гарах

б. Эрдэм багатын омог их.



В. Өгүүлбэр зохиож бичээрэй.

1 Өгүүлбэр дуурайж, өгүүлбэр зохиоё.  
Үг бүрийг өөр үгээр сольж дуурайж бичээрэй.

Жишээ нь:

Эрт цагт элээ чогчиго хоёр дуу сурахаар алсын алсад явах болжээ.

Урьд цагт үнэг чоно хоёр ан хийхээр холын холд одох болжээ.

#### Дуурайж бичих өгүүлбэрүүд:

- Нисэн ниссээр зорьсон газраа хүрч гэнэ.
- Элээ гэнэт сэртэл эхээсээ төөрсөн унаганы янцгаах дуу сонсогдож байжээ.
- Ээрэм талд чулуун дээр сууж эрдэм сурч эхэлжээ.

3 Дараах өгүүлбэрүүдийг асуух өгүүлбэр болгож бичээрэй.

"Ямар учраас, яагаад, яах гэж" гэсэн үгсийг хэрэглээрэй.



- Элээ, чогчиго хоёр алсын алсад явах болжээ.
- Чогчиго уйгагүй оролдсоор маш их зүйл сурч авчээ.
- Элээ зөвхөн янцгаах дуу сурчээ.



Г. Зөв бичье. Хүснэгтийн дагуу дэвтэртээ бичээд, ярилцаарай.

Манай ангийн баатар сургуулийн шатрын аварга. Манай аймгаас төрөн гарсан хөдөлмөрийн Баатар Улболганы талаар та нар сонссон уу? Айлын хүү энхээ аав ээждээ тусалдаг. Баруун бүсэд Говь-Алтай, Баян-Өлгий, завхан, увс, ховд аймаг байдаг. Манай ахын нэрийг болд гэдэг.

Алдаатай үг	Зассан нь	Ямар дүрэм алдсан бэ?
Манай ангийн баатар ...	Манай ангийн Баатар	Оноосон нэрийн эхний үсгийг томоор бичнэ.

## ДАСГАЛ 5

### А. Товч мэдээг уншиж, бүтцийг нь мэдье.

- “Монголчууд дэлхийн шатрын аваргатай боллоо” мэдээний бүтцийг асуултын дагуу өнгөөр ялган, задалсныг ажигла.
- “Ногоон алт аянд нэгдлээ” гэсэн мэдээг асуултын дагуу задалж ярилцаарай.



Монголчууд шатрын дэлхийн аваргатай боллоо.

Шатрын өсвөр үеийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн 9 дүгээр сарын 6-нд Румын улсад боллоо. Охидын 16 насны ангилалд Монгол улсын тамирчин Д.Мөнхзул “Дэлхийн аварга” хэмээх алдрыг хүртлээ. Эх орныхоо нэрийг тив дэлхийд цуурайтуулж яваа тамирчин охиндоо спортын их амжилт хүсье.



### Б. Мэдээ бичихэд график мэдээллийг хэрэглэж болох уу? Ярилцаарай.



1 Хоёроос гурван оныг сонгон, мэдээллийг өгүүлбэрээр илэрхийлж бичээрэй.



В. Сургууль, ангидаа болсон чухал үйл явдлын талаар мэдээ бичье.



Чи өөрийгөө телевизээр мэдээ уншиж байна гэж төсөөл.  
Дууны өнгө ямар байхыг бод.  
Үг, өгүүлбэрээ тод хэл.

Бусдад мэдээлэх ямар үйл явдал болсон бэ?

Бүгдээрээ ярилцаж, ТВ дэлгэц бүтээгээрэй.  
Дэлгэцийнхээ дунд ганцаараа эсвэл хоёулаа суугаад мэдээгээ уншаарай.



Ярих бэлтгэлээ дахин дахин хий.  
Толины өмнө сууж, өөрийгөө яаж ярьж байгааг ажиглах дасгал хий.

Мэдээний баримтаа бүтцийн дагуу цуглуул.

Хэн?

Юу?

Хаана?


Хэзээ?

Яагаад?

Юу болов?

- Мэдээгээ бичээд, бүтцийн дагуу шалга.
- Сонирхолтой гарчиг өг.
- Мэдээнийхээ алдааг хяна.
- Мэдээгээ яавал сонирхолтой, үр дүнтэй болгох вэ? гэдгийг бодоорой.
- Зураг, график мэдээлэл зэргийг оруулахыг хичээгээрэй.

Жишээ нь: Ном унших сэдвээр график мэдээллийг уншъя.



# IV БҮЛЭГ. АЖИЛ ХӨДӨЛМӨР

## ДАСГАЛ 1



А. Эхийг уншаад, тодруулсан үгсийн утгыг зурагтай харьцуулж, ярилцаарай. Хосоороо харилцан уншаарай.

### Эсгий яаж хийдэг вэ?

Эсгий яаж хийдэг вэ?

Эхлээд ноосоо **савдаг** юм

Савсан ноосоо яадаг вэ?

Сайхан жигд **зулдаг** юм.

Зулсан ноосоо яадаг вэ?

Зузаан нимгэнгүй **усалдаг** юм.

Усалсан ноосоо яадаг вэ?

Урт булд **ороодог** юм.

Ороож боогоод яадаг вэ?

Өнөө булнаас нь морьтой хүн

Өнхрүүлж бөмбөрүүлж **чирдэг** юм.

Чирч давхихаар яадаг вэ?

Чигжирч нягтраад эсгий болдог.



### Үгийн утгыг мэдье

**савах** – саваа модоор цохих

**зулах** – савсан ноос хөвөн

зэргийг жигд дэлгэн дэвсэх

**ороох** – тойруулан боох

**бул** – эсгийг чирэхэд

хэрэглэдэг мод

**чирэх** – юмыг татах, чангаах

**чигжрэх, нягтрах** – шигүү нягт

болох

*“Монгол хэлний хураангуй тайлбар толь”-оос*



## Б. Харилцан яриаг гүйцээж зохиоё.

- Харилцан ярианы эхлэлийг уншаарай. Үргэлжлэлийг сонгоорой. Утгыг мэдэхгүй үгийг багшаасаа асуугаарай.

### Эхлэл хэсэг

Болд: Хулан чи зун хаана амрах вэ? Өвөө маань дөрвөн улирлын турш малаа малладаг. Тиймээс би очиж тусална. Бас сайхан амарна. Хөдөө нутаг үнэхээр сайхан, тийм ээ? Хулан: Би ч бас хөдөө явна аа. Чи хөдөө очоод юу юу хийдэг вэ?

### Үргэлжлэл хэсэг


Болд Хулан хоёрын харилцан яриаг дараах хэсгээс сонгон, үргэлжлүүлэн ярилцаарай.

Болдын хөдөө очоод хийдэг ажлыг сонгож хэлээрэй.

Болд: Би хөдөө очоод:



Уралдааны морь унаж, түрүү магнайд ирж, морио цоллуулж байсан. Би хөдөө морь унах дуртай.



Эмээгээ гүү саахад нь унагыг нь татаж өгдөг. Эрт гарсан том унагыг дийлэхгүй алдчих гээд байдаг сан.



Зуны халуунд олон мал усалдаг. Хааяа ховоогоо даахаа больчих гээд байдаг.

### Үргэлжлэл хэсэг

Болд: Хулан чи харин хөдөө зуны амралтаараа юу хийдэг вэ?

Хулангийн хөдөө очоод хийдэг ажлыг сонгож хэлээрэй.

Хулан: Би хөдөө очоод:



Уутанд шүүж шахсан аарцыг дэлгэц дээр тавиад, нарийн утсаар зүсэж, модон тавиур дээр хатааж, ааруул хийнэ.



Өнгөрсөн зун анх удаа үнээ сааж үзсэн. Анх үнээний дэлэнг шувтраад шувтраад сүү нь гарахгүй, гар цуцаад байсан.



Шээзгий үүрч, савар бариад аргал түүхдээ нойтон аргал тааралдвал эргүүлээд үлдээнэ. Би аргалд явдаг.

### Төгсгөл хэсэг

Харилцан яриагаа төгсгөөрэй.

Болд: ...

Хулан: ...

Хос хосоороо харилцан яриагаа уншаарай.

## ДАСГАЛ 2



А. Эхийг анхааралтай уншаад, асуултад хариулаарай.

### Хөдөө нутагт дурласан минь

Миний нэр Билиг. Би гуравдугаар ангиа төгссөн зун ахтайгаа хөдөө явж амрав. Зунжингаа тэнд байвал уйдаx байх гэж бодож байв. Энд ирээд хэдхэн хоноход би хөдөө нутагт үнэн сэтгэлээсээ дурлаж, өдөр болгон шинэ зүйлийг мэдэж, уйдаx ч зав олдохгүй байлаа.

Хурдан морь унах, бөх барилдах, адуугаа эргүүлэх, тараг бүрэх, айраг бүлэх, хашаа хороогоо засах, малаа услах гээд хөдөөгийн ажил тасрахгүй юм билээ. Гэхдээ хамгийн дуртай зүйл минь юу вэ? гэвэл, "Хурдан морь унаад салхи татуулан давхих" байв.

Нэг мэдэхэд л зун өнгөрч, хичээл эхлэх болсон тул гэртээ харих болов. Би хөдөө нутагт үнэхээр дурласан даа.

- ✓ Хүү хөдөө нутагт дурласан учрыг чи юу гэж бодож байна вэ?
- ✓ Чиний хувьд хөдөө очоод хийх хамгийн дуртай зүйл нь юу вэ?

1 Эхийг уншаад ямар сэтгэгдэл төрсөн бэ?



Надад хөдөө очсон мэт санагдсан.



.....

2 Цэгийн оронд тохирох үгийг сонгон, өгүүлбэрийг гүйцээж, үгийн утгыг мэдэж аваарай.

Нөхөх үг:      давхих, тараг бүрэх, салхи татуулан уралдах, айраг бүлэх



1. Хөөрүүлсэн сүүнд тараг хольж сайтар самраад, таглан дулаан зүйлээр хучихыг ..... гэнэ.

2. Хөхүүрт буй айргийг бүлүүрээр цохилон хутгахыг ..... гэнэ.



3. Мориор хурдан давхихыг ..... гэнэ.  
4. Морин дэл дээр ..... сайхан.

2 Үгсийн утгыг зөв харгалзуулаарай.

- 1. хонины морь ●
- 2. хурдны морь ●
- 3. уургын морь ●
- 4. хашин морь ●

- а. хойрго морь ●
- б. морь уургалахад сургасан морь ●
- в. сойсон морь ●
- г. номхон морь ●



Б. "Малчин айлын нэг өдөр" сэдвээр ярилцаарай. Өглөөнөөс үдэш болтол малчин айлд өрнөдөг ажил үйлийг дэвтэртээ жагсаан бичээрэй.

Морь унах

Үнээ, гүү саах

Тараг бүрэх

Айраг бүлэх

Мал услах

Ааруул тавих

Аргал түүх

Бөх барилдах

Адуугаа эргүүлэх

Малын хашаа  
хороогоо засах

Өвс хадах

1 Багаараа дөрвөн улирлаас сонгон, хөдөө нутагт тухайн улиралд ямар ямар ажил өрнөдөг талаар яриа бэлтгээрэй. Хөдөө очоод өөрийнхөө хийдэг ажлаас жишээ татаж яриарай.



Айл хотлоороо намаржаандаа буув.  
Төмс ногоогоо хураана.  
Сургуулийн хүүхдүүд ирэхээр сум  
дуу шуутай болоод явчихна.



Хэдэн үхрээ нэмнээд ...  
Мөсөнд явах, мөсөн дээр тоглоно.  
Цасаар өвлийн өвгөн хийгээд...  
Өвлийн үдэш үлгэр хүүрнэх сайхан.



Ишиг хурга нийлсэн 30 гаруй төлийг  
угжиж байна.  
Усны шувуудыг хараад ...




Аргал хормойлон оруулав.  
Гол руу усанд явах ч сайхан шүү.  
Гол дээр тоглоно...



## В. Амралтаа хэрхэн өнгөрүүлэх төлөвлөгөө бичье.

Төлөвлөгөө зохиохдоо хугацаагаа сонгоно.

- ✓ 7 хоног
- ✓ сар
- ✓ улирал
- ✓ жил



1 Хоёр найзаасаа амралтаа хэрхэн өнгөрүүлэх талаар асууж ярилцаад, хүснэгтийг бөглөж хамтран төлөвлөгөө гаргаарай.

Улирлын амралт дөхөж байна. Чи хаана, юу хийж амрах вэ?

Найзын нэр	Хаашаа явах вэ?	Юу хийх вэ?	Юу сурах вэ?

2 Найзынхаа амралтын төлөвлөгөөг товч, тодорхой тайлбарлаж яриарай.



“Гээгдэх эгшиг”-ийн дүрмийг ярилцъя.



Гийгүүлэгчээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад эцсийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшгийг гээнэ.

эг + ээ = ~~эгээ~~

нутаг + ийн = нутгийн  
аймаг + аас = аймгаас  
эрдэм + ээс = эрдмээс  
элдэв + ийг = элдвийг

“өдөр, айраг” – гэсэн үгсийг тийн ялгалаар хувилгаж бичээрэй.

**Жишээ нь:** газар, газрын, газарт, газрыг, газраас, газраар, газартай, газар луу



Эгшгээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад эцсийн богино эгшгийг гээнэ.

э + ээ = ~~эээ~~

бага + аар = багаар  
унага + ыг = унагыг  
ботго + оор = ботгоор  
сана + уул = сануул

“уурга, ингэ” – гэсэн үгсийг тийн ялгалаар хувилгаж бичээрэй.

**Жишээ нь:** дарга, даргын, даргад, даргыг, даргаас, даргаар, даргатай, дарга руу

□ Үгсийг зөв бичээрэй.

## ДАСГАЛ 3



А. Шүлгийн мөр бүрийг анхааралтай уншаад, асуултын дагуу ярилцаарай.

### Миний хэнз хурга

Миний хэнз хурга  
Магнай халзан зурвастай  
Мянган хонины дундаас  
Би хармагц таньдаг.  
Мярс мярс майлж  
Намайг чиглэсээр ирдэг.

Энэ хэсэгт юуны  
тухай өгүүлж  
байна вэ?

Чамд ямар  
сэтгэгдэл төрж  
байна вэ?

Дун цагаан үстэй.  
Дуран хар нүдтэй.  
Түмэн хонины дундаас  
Түүнээс хөөрхөн амьтангүй.  
Төрсөн хотон дотроо  
Тэр бид хоёр тоглодог.

Энэ хэсэгт юуны  
тухай өгүүлж  
байна вэ?

Чамд ямар  
сэтгэгдэл төрж  
байна вэ?

Өвдгөө сөгдөөд  
Өөрийнхөө ээжийг хөхдөг.  
Өвөр дээр минь гараад  
Өхөөрдмөөр өхөөрдмөөр эрхэлдэг.  
Нааш цааш дэгдэн  
Малчин эзнээ баясгадаг.

Энэ хэсэгт юуны  
тухай өгүүлж  
байна вэ?

Чамд ямар  
сэтгэгдэл төрж  
байна вэ?

(Д.Нацагдорж)



### Үгийн утгыг мэдье

**хэнз** - хожуу гарсан хурга

**магнай халзан** - мал амьтны дух, магнай, хамрын дагуух зурвас цагаан үс

**дун цагаан үс** - маш цагаан, дун тана мэт цагаан (адилтгал)

**дуран хар нүд** - хурц хараатай, дуран мэт нүд (адилтгал)

**мярс мярс майлах** - хурганы майлах авиа

“Монгол хэлний хураангуй тайлбар толь”-оос



Б. Асуултын дагуу багаараа ярилцаж бичээрэй.

Ямар хурга вэ?

1. Хэнз
2. ....
3. ....
4. ....
5. ....



Хурга яаж яаж байна вэ?

1. Ирдэг.
2. ....
3. ....
4. ....
5. ....



## В. Шүлэгт хургыг яаж дүрсэлснийг ярилцъя.



### Үгийн утгыг мэдье

- дун** - 1. Зөөлөн биетэн амьтны бие хамгаалах хатуу бүрхүүл гэр  
2. Дунгаар хийсэн үлээдэг хөгжмийн зэмсэг
- дуран** - Холыг ойртуулж харах хэрэгсэл



“Дунцагаанүстэй” Хурганы үсийг цав цагаан гэдгийг дүрслэхийн тулд дунгийн өнгөтэй адилтгажээ.



Дун цагаан үстэй  
Дуран хар нүдтэй



“Дуран хар нүдтэй” Нүдээ тойрсон хар зүстэй хонийг “хар нүдэн хонь”

гэж монголчууд нэрлэдэг. “Маш сайн хардаг, дуран мэт хардаг” гэсэн санааг илэрхийлэхийн тулд дурантай адилтгажээ.

- 1 Малчин хүүхдийн хургыг өхөөрдсөн, малаа хайрласан сэтгэлийг илэрхийлсэн үгсийн доогуур тэмдэглэж, сэтгэгдлээ яриарай.



## Г. Шүлгээ уран уншицгаая.

### Шүлгийг уран уншихдаа:



- Хавар цагт мал төллөсөн малчны хотыг нүдэндээ төсөөлнө.
- Дууны өндөр нам, хурд хэмнэл тохируулж, төл малын хөөрхнийг сэтгэлдээ төсөөлж, өөртөө итгэлтэй, уран тодоор, зөв дуудаж уншина.
- Шүлгийнхээ санааг сэтгэлдээ дүрслэн бодоод шүлгээ цээжилнэ.
- Шүлгээ унших дасгал олон удаа хийсний дараа найзуудынхаа өмнө уран уншина.
- Ангиараа “Миний хэнз хурга” дууг сонсож, дагаж дуулаарай.



### “Гээгдэх эгшиг”-ийн дүрмийг ярилцъя.



Гийгүүлэгчээр төгссөн үгэнд гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад эцсийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшиг гээгдэж, хоёр гийгүүлэгчийн хооронд эгшиг жийрэглэнэ.

эг + г = ~~г~~гэг

нөхөд + д = нөхөд  
боловсор + л = боловсрол  
үсэр + х = үсрэх

Үгсийг нүдлээрэй.

хүүхдэд, амьтдад, малчдад,  
бусдад, сурагчдад, ноход



А. Эхийн үг, өгүүлбэрийг хурдан, зөв дуудаж уншаад, өөрийгөө үнэлээрэй.

### Ааруул

Үгийн тоог тэмдэглэв.

Бадрах өглөөний нарны хурц гэрэлд нүдээ онийлгон зогсоно. Ээж нь гэр дээр дэлгэцтэй ааруул тавихдаа нэгийг Бадрахад өгсөн юм. Ааруулын амтны сайхныг зүйрлэшгүй. Бадрах гэртээ гүйн орлоо. 28

- Ээж ээ!
- Өөв!
- Би аргал оруулах уу? гэж Бадрах асуув.
- Тэг тэг, Миний хүү гээд ээж нь хурганы арьс элдсээр байлаа.

Бадрах баярлан, гүйн гарч цамцандаа гурав дөрвөн аргал хормойлж ирээд, дүүрэн аргал авчирсан мэт зуухны хажууд их чимээ гарган асгав. Яасан сайн хүү вэ? гэж ээж нь юмаа хийх зуур магтав.

- Бадрах хэсэг зогссоноо: 76
- Ээж ээ, Би ус авчрах уу? гэв.
- Тэг тэг, “Миний хүү харин усны гүехнээс хутгаарай” гээд ээж жижиг модон хувин өгөв. Хүү хувингаа авч гарахдаа гэр дээрх ааруул өөд хорхойсон харав. Тэр ус авчирч явахдаа тун ч их баяртай байв.



- Ээж ээ! Би ус авчирлаа гээд тавиурын тэнд тавив.
- Мөн ч сайн хүү шүү! гэж юмаа оёх зуур ээж хэлэв.
- Ээж ээ! гэж Бадрах ахиад л дуудав.
- Юу гэв? Миний хүү.
- Би хургаа харах уу? гэж Бадрах аяархан асуув. 156
- Тэг ээ, миний хүү. Зүүн толгой дээр гараад ир гэлээ.

Гэрийн үүдээр зөөлөн салхи сэвэлзэхэд өнөөх ааруулын сайхан үнэр ханхална. Хургаа нь зүүн толгойн цаахан талд бэлчиж явав. Бадрах эргэн гүйв.

- Ээж ээ, Би хургаа харлаа, энүүхэнд байна гэж баяртай хэлэв.
- Ёстой сайн хүү шүү! гээд ээж нь дэлгэцтэй ааруулаасаа хамгийн томоос нь хүүдээ өгөв.

Бадрах нар өөд нүдээ онийлгон харж, ааруулаа идэв. Их ажлын дараа идсэн ааруул илүү сайхан амттай байв. Нийт үг: 212

Уншсан үгийн тоо

1


Үгийн утгыг мэдье. Үг тус бүрээр өгүүлбэр зохиож, уншаарай.



нүдээ онийлгох



модон хувин



тавиур



толгод




Б. Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийн ялгааг дараах жишээгээр тайлбарлаж бичээрэй.

**Эхлэл хэсэг:**  
Хэний, юуны тухай өгүүлэх вэ? гэдгээ танилцуулна.

Бадрах өглөөний нарны хурц гэрэлд нүдээ онилгон зогсоно. Ээж нь гэр дээр дэлгэцтэй ааруул тавихдаа нэгийг Бадрахад өгсөн юм. Ааруулын амтны сайхныг зүйрлэшгүй.

□ Үйл явдал яаж өрнөснийг ажиглаарай.

**Гол хэсэг:**  
Үйл явдал өрнөнө.



**Төгсгөл хэсэг:**  
Эхлэл, гол хэсгийг дүгнэнэ.

Бадрах нар өөд нүдээ онилгон харж, ааруулаа идэв. Их ажлын дараа идсэн ааруул илүү сайхан амттай байв

1 Эхээс юуг ойлгож авав. Нэг өгүүлбэрээр бичээрэй.

Хүн сайн хөдөлмөрлөвөл урам авна.

2 Бадрахад ааруул илүү сайхан амттай санагдсан учрыг хэлээрэй.

Ээж нь гэр дээр дэлгэцтэй ааруул тавихдаа нэгийг Бадрахад өгсөн юм.

**Ааруулын амтны сайхныг зүйрлэшгүй.**



Ёстой сайн хүү шүү! гээд ээж нь дэлгэцтэй ааруулаасаа хамгийн томоос нь хүүдээ өгөв. Бадрах нар өөд нүдээ онилгон харж, ааруулаа идэв.

**Их ажлын дараа идсэн ааруул илүү сайхан амттай байв.**



В. Хөдөө тохиолдож байсан хөгжилтэй явдлаа хуваалцъя.

- Зургийг сайтар ажиглаж, цэгийн оронд тохирох үгийг нөхөж, зургийн үйл явдлыг тайлбарлаж бичээрэй.

Нохой ..... идэж байсан. Хүү ..... мөчрөөр айлгасан. Нохой ..... харамласан. Нохой ..... **учраас** хүү рүү дайрсан. Хүү сандарсан **тул** .....

- 1 Хоёрдугаар зургийг дээрхийн адил таван өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй. Өгүүлбэртээ “**учраас, тул**” гэсэн үг хэрэглээрэй.



- 2 Амралтаараа өөрт тохиолдож байсан хөгтэй явдлаа бие биедээ яриарай. Хөгтэй явдал тохиолдох болсон шалтгааныг бас хэлээрэй.

Жишээ нь:

- Тоглож байгаад хонь хургаа нийлүүлсэн.
- Тугал татах гээд дийлэхгүй хөлөө гишгүүлж, уйлсан.
- Морь сайн унаж сураагүй тул мориноосоо унасан.



А. Мэдээг анхааралтай уншаарай. Асуултын дагуу задалж ярилцаарай.

хэн?	юу?	хаана?
хэзээ?	яагаад?	юу болов?

### Үзэсгэлэн худалдаанд урьж байна

Монголын уламжлалт Цагаан сарын баярыг угтан “Цагаан идээний үзэсгэлэн худалдаа” өнөөдрөөс энэ сарын 06-ыг хүртэл “Бөхийн өргөө”-ний гадна талбайд нээгдлээ.

Тус үзэсгэлэн худалдаа нь экологийн цэвэр бүтээгдэхүүнийг нийслэлчүүдэд борлуулдгаараа онцлогтой. Үзэсгэлэнд малчид уламжлалт аргаар боловсруулсан ааруул, тараг, айраг, сүү, өрөм, шар тос, бяслаг, аарц, цөцгий, эзэгий, хайлмаг зэрэг бүх төрлийн цагаан идээ худалдаалж байна.

Иргэд өргөнөөр оролцоно уу.



#### Үгийн утгыг мэдье

**уламжлал** – Үеэс үед дамжин ирдэг соёлын өв

**үзэсгэлэн худалдаа** – Ямар нэгэн зүйлийг олон нийтэд танилцуулан сурталчлахын зэрэгцээ худалдаа хийх

**боловсруулах** – засаж сайжруулах

*“Монгол хэлний хураангуй тайлбар толь”-оос*

1 Асуултад хариулаарай.

- ✓ Мэдээнд өөр ямар гарчиг өгч болох вэ?
  - ✓ Мэдээний зургаан асуултын аль нэг нь байхгүй байж болох уу?
  - ✓ Чи юуны талаарх мэдээг хаанаас сонсдог, уншдаг вэ?
  - ✓ Мэдээг сонсох, уншихын ач тус юу вэ?
  - ✓ Мэдээг сонирхолтой болгох ямар ямар арга байж болох вэ?
- Жишээ нь: Дээрх мэдээнд агуулгыг илэрхийлсэн зураг ашиглаж болох уу?

2 Асуултад хариулж бичээрэй.


- нийслэлчүүдэд – гэж хэнийг хэлж байна вэ? Яагаад “-чүүд” гэсэн олон тооны дагавар авсан бэ?
- малчид – Яагаад “малчин” гэж бичээгүй. “малчид” гэж олон тоогоор бичсэн бэ?
- “Бөхийн өргөө”-ний гэхэд ямар учраас эм үгийн “-ий” бичсэн бэ?
- “...энэ сарын 06-ыг хүртэл” гэхэд ямар учраас эр үгийн “-ыг” бичсэн бэ?

3 Цагаан идээний нэрсээс мэдэхгүй үг байвал хоорондоо ярилцаж мэдэж аваарай. Чи аль цагаан идээнд ямар учраас дуртай вэ? Ярилцаарай.

ааруул тараг айраг сүү өрөм шар тос аарц бяслаг цөцгий эээзгий хайлмаг

Б. Өгүүлбэр зохиож бичье.

1 Үйл үгийг гүйцээж бичээрэй.



2 “Ямар + юу + яав” бүтцээр 3 өгүүлбэр зохиогоорой. Жишээ нь: Шаргал өрөм загсаав.

В. Өгүүлбэрүүдийг зөв дараалалд оруулж, ааруул хийх аргыг мэдэж аваарай.

1. Дулаан газар тавьж тараг бүрнэ.
2. Сүүгээ зөөлөн гал дээр буцалгана.
3. Аарцаа хэвлэж, дэлгэц дээр тавьж хатаана.
4. Бүрэлдсэн таргаа шүүж, аарц болгоно.
5. Халуун бүлээн байхад тарагны хөрөнгө хийнэ.



Г. Өгүүлбэрүүдийг холбож бичье.

- “Өрөм загсаах” эхийг уншаарай.
- Мэдэхгүй үгээ толь бичгээс харж мэдэж аваарай.
- Өгүүлбэрүүдийг дараах нөхцөл, үгийг ашиглан, хоёр хоёроор нь холбож бичээрэй.
- Өгүүлбэрүүдийн үйл үгийн утгыг хоорондоо ярилцаарай.

Холбох үг: бөгөөд

нөхцөл: -ж, -вал<sup>4</sup>, -бал<sup>4</sup>



### Өрөм загсаах

Түүхий сүүг аргалын галаар хөөрүүлнэ. Хорголын гал ширүүднэ. Галаа цогшуулна. Сүүгээ сайтар самарна. Цог удаан төөнөнө. Дарайсан шаргал өрөм загсана. Ширүүн галаар сүүгээ хөөрүүлнэ. Сүү түлэгдэнэ.

# V БҮЛЭГ. ДЭЛХИЙН УЛС ОРОН

## ДАСГАЛ 1



А. Дараах харилцан яриаг хосоороо уншихдаа өгүүлбэрийн аялгыг зөв тохируулахыг хичээгээрэй.

1 Цэг тэмдэггүй өгүүлбэрийг уншихад бэрхшээл гарсан уу? Цэг тэмдгийг хэрэглэхийн учрыг ярилцаарай.

### Автобусны буудал дээр

Автобусны буудал дээр гадаад хүн байхыг Мөнхжаргал харлаа Тэрээр түүнтэй уулзаж ийнхүү ярилцлаа

Сайн уу Намайг Мөнхжаргал гэдэг

Сайн уу Би бол Жон Смит Та автобус хүлээж байна уу

Тийм ээ Та аль улсаас ирсэн бэ

Би Австралиас ирсэн

Та энд аялахаар ирсэн үү

Тийм ээ Аялахаар ирсэн. Монгол орны үзэсгэлэнт газраар аялмаар байна

Энд ямар санагдаж байна вэ?

Монголчуудын найрсаг зан надад үнэхээр таалагдаж байна Танай улс үнэхээр үзэсгэлэнт байгальтай юм

За миний автобус ирлээ Тантай уулзсандаа таатай байна Баяртай гэж хэлээд Мөнхжаргал автобусанд суухаар явлаа

Жон Смит Баяртай гэж гараа даллав (Ж.Баяраа)

2 Харилцан яриаг цэвэр сайхан, алдаагүй хуулж бичээрэй.

- Харилцан ярианы үг, өгүүлбэрт тохирох цэг тэмдгийг тавьж бичих
- Үсгийн бичих хэв маягийг баримтлах
- Үсгийн өндөр намыг зөв тохируулж, муруй хазгай биш бичих
- Үсэг хоорондын холболт зөв байх
- Үг, үсгийн хоорондын зайг ижил хэмжээтэй бичих
- Үгийг үзэг салгахгүй тасралтгүй бичих
- Догол мөр гарган хуулж бичих

<ul style="list-style-type: none"> <li>• Хандаж хэлсэн үед</li> <li>• Анхаарал татахаар</li> <li>• Анхааруулж сануулсан</li> <li>• Сэтгэл хөдлөл илэрхийлсэн үед</li> </ul>	!	Асууж, тодруулах үед	Том үсэг	<ul style="list-style-type: none"> <li>• Өгүүлбэр эхэлж байгаа үед</li> <li>• Ярилцаж буй хүмүүсийн нэрийг бичих үед</li> </ul>
Үргэлжлэл байгааг илэрхийлэх үед	...	Харилцан ярианы цэг тэмдэг	-	Харилцан яриа болохыг ялгахын тулд
<ul style="list-style-type: none"> <li>• Тоочсон үед</li> <li>• Хоёр өгүүлбэрийн дунд</li> </ul>	,	<ul style="list-style-type: none"> <li>• Энгийн хүүрнэсэн үед</li> </ul>	“...”	Бусдын хэлсэн үгийг ялгахын тулд



Б. Дараах жишээг уншиж, “Баатрын үг”, “Зохиогчийн үг”-ийн ялгааг ярилц.

- За, миний автобус ирлээ. Тантай уулзсандаа таатай байна. Баяртай! гэж хэлээд Мөнхжаргал автобусанд суухаар явлаа.

За миний автобус ирлээ.  
Тантай уулзсандаа  
таатай байна. Баяртай!

Баатрын үг



... гэж хэлээд  
Мөнхжаргал автобусанд  
суухаар явлаа.

Зохиогчийн үг

1 Дараах жишээг “Баатрын үг”, “Зохиогчийн үг”-ээр ялгаад, учрыг тайлбарлаарай.

Автобусны буудал дээр гадаад хүн байхыг Мөнхжаргал харлаа. Тэрээр түүнтэй уулзаж ийнхүү ярилцлаа  
- Сайн уу? Намайг Мөнхжаргал гэдэг.



В. Чи аялах дуртай улс орондоо байна. Тэндээсээ гэр бүлийнхэнтэйгээ утсаар ярьж байна гэж төсөөлөөрэй. Хосоороо утсаар яриарай.

### Мэнд усаа мэдэлцэх

Аль улсаас ярьж байгаагаа хэлэх  
Чи юу юу үзсэн бэ?  
Тухайн улсын юу нь чамд таалагдаж байна вэ?  
Цаг агаар нь ямар байна вэ?

.....

Асуултад бүрэн, тодорхой хариулах  
Ярианаас лавшруулан, тодруулж асуулт асуух  
Талархлаа илэрхийлж сайн сайхныг хүсэх



Г. Зөв бичье. Балархай эгшгийг яагаад гээснийг үг бүрээр тайлбарлаж ярилцаарай.

Бодлоо, сэдвээр, явдлыг, сэдвийн, багаас, бусдын, сэтгэгдлээ, утгыг, бүтцийг, задалсныг, шатрын, явдлын, бусдад, зэргийг, шүлгийг, хаалгаа, алгаа, эрдмээс, шүлгийн, эрдмийн, хаалгыг, хүүхдийн, олныхоо, хаалгаар, шүлгээ, зэргийг, мөрөөдлөө, өдрийн, төлөвлөснөө, ажлын, зорилгыг, нөхдөдөө

1 Дараах загвараар 3 үг сонгон бичээрэй.

бодол + оо = бодлоо

сэдэв + ээ = сэдвээ

явдал + аа = явдлаа

## ДАСГАЛ 2

А. Аяллын тэмдэглэлийг бие биедээ чанга дуугаар уншиж өгөөрэй.

- Өгүүлбэрүүдийг холбосон нөхцөлийг ажиглаарай.

### Байгаль нуурыг нээсэн долоо хоногийн аялал

Манай ангийнхан амралтаараа “Дэлхийн цэнхэр сувд” хэмээн алдаршсан Байгаль нууртай танилцах аялалд гарсан юм.

**Өдөр 1.** 18:00 цагт Улаанбаатар хотоос автобусаар хөдөлж, Сэлэнгэ аймгийн “Сайханы хөтөл”-д очив. Үнэхээр үзэсгэлэнтэй сайхан газар байлаа.



**Өдөр 2.** Өглөө эртлэн аян замдаа гаргаад, зорьж тэмүүлсээр Байгаль нуурынхаа хөвөөнд буулаа. Төсөөлж байснаас ч гайхалтай сайхан нуур юм. Бид уулга алдаж, дээр дээр үсэрч, алга ташиж, тэврэлдэн баярлаж байв.

**Өдөр 3.** Өнөөдөр тайлбарлагч ах бидэнтэй хамт аялангаа Байгаль нуур бол дэлхийн хамгийн цэнгэг устай нуур болохыг тайлбарлав.

**Өдөр 4.** Өнөөдөр усан онгоцоор аялаад, зургаа авхуулаад үнэхээр сайхан өдөр байлаа. Гитар тоглолоо. Дуу дуулцгаав. Өдрийг зугаатай сайхан өнгөрүүлэв.

**Өдөр 5.** Үүлгүй, дулаахан өдөр болж, сэтгэл сайхан байв. Үдийн хоолоо идээд Буриадын нийслэл “Улаан-Үд” хот руу хөдөллөө.



**Өдөр 6.** Ангиараа аяллынхаа талаар ярилцаж, биеэ биеэ тэврээд, сайхан найзууд болсноо ярилцав.

**Өдөр 7.** Эх орныхоо хилээр ортол, эх орон минь биднийг баяртай угтав.

1 Өгүүлбэрүүдийг холбосон нөхцөлүүдийг ялгаж бичээрэй.



## Б. Өгүүлбэрийг задлан ярилцъя.

- 1 Нийлмэл өгүүлбэрийг энгийн өгүүлбэр болгон задалж бичээрэй.  
Хэдэн өгүүлбэр байна вэ?  
Өгүүлбэрүүдийг холбосон нөхцөлүүдийг ялгаж бичээрэй.  
Жишээ нь:

**Өдөр 6.** “Ангиараа аяллынхаа талаар ярилцаж, бие биеэ тэврээд, сайхан найзууд болсноо ярилцав.” – гэсэн нийлмэл өгүүлбэрт 3 энгийн өгүүлбэр байна.

- Ангиараа аяллынхаа талаар ярилцаж,
- биеэ биеэ тэврээд,
- сайхан найзууд болсноо ярилцав. гэсэн 3 өгүүлбэр байна.

Өгүүлбэрүүдийг “-ж, -ээд” гэсэн нөхцөлөөр холбосон байна.

Задлан тайлбарлах өгүүлбэр:

**Өдөр 5.** Үүлгүй, дулаахан өдөр болж, сэтгэл сайхан байв. Үдийн хоолоо идээд  
Буриадын нийслэл “Улаан-Үд” хот руу хөдөллөө.

- 2 Дараах гурван энгийн өгүүлбэрийг хүснэгтэд байгаа холбох нөхцөлөөс сонгон, нийлмэл өгүүлбэр болгож бичээрэй. Хэн ямар нөхцөлөөр холбосныг ярилцаарай.

**Өдөр 4.** Гитар тоглолоо. Дуу дуулцаав. Өдрийг зугаатай сайхан өнгөрүүлэв.

- 3 Дараах өгүүлбэрийн “-ортол” гэсэн үгийн “-тол” нөхцөлийг өөр нөхцөлөөр сольж болох, болохгүйг ярилцаарай.

**Өдөр 7.** Эх орныхоо хилээр ортол, эх орон минь биднийг баяртай угтав.  
Эх орныхоо хилээр ормогц, эх орон минь биднийг баяртай угтав.  
Эх орныхоо хилээр оронгуут, эх орон минь биднийг баяртай угтав.



Монгол хэлэнд өгүүлбэрүүдийг холбодог “Холбох нөхцөл”-ийг уншиж, мэдэж аваарай.

Холбох нөхцөл	Жишээ	
(-ж, -ч)	орж	Бороо орж байгаль сэргэв.
(-аад <sup>4</sup> )	ороод	Цас ороод хүйтэн болов.
(-н)	мандан	Өглөөний нар мандан шувууд жиргэнэ.
(-саар <sup>4</sup> )	дуулсаар	Дорж гуай дуу дуулсаар айсуу.
(-вч)	Хэлэвч	Хэлэвч ойлгохгүй өнгөрөөнө.
(-магц <sup>4</sup> )	ирмэгц	Ахыг ирмэгц эгч явав.
(-тал <sup>4</sup> )	хэлтэл	Болдыг хэлтэл би гэнэт санав.
(-хлаар <sup>4</sup> )	хэлэхлээр	Ахыг хэлэхлээр би санав.
(-вал <sup>4</sup> , -бал <sup>4</sup> )	арилбал	Манан арилбал онгоц цагтаа ниснэ.
(-нгуут <sup>2</sup> )	оронгуут	Хичээл оронгуут хүүхдүүд дэвтрээ гаргав.
(-нгаа <sup>4</sup> )	явангаа	Дэлгүүр явангаа замдаа ярилцав.

## ДАСГАЛ 3

А. Дууны үгийг уншаарай. Юу ойлгов?, Юу мэдрэв? Ярилцаарай.

### Сайн байна уу?

Газар газрын найзууд аа

Сайн байна уу?

Гараа атган танилцъя аа.

Сайн байна уу?

Цэлмэг тэнгэр шувуунд хэрэгтэй.

Цэнгэг усан загасанд хэрэгтэй.

Нарны туяа цэцгэнд хэрэгтэй.

Найз нөхөд надад хэрэгтэй.

Орон орны найзууд аа

Сайн байна уу?

Олуул сайхан танилцъя аа.

Сайн байна уу?

Дахилт

Алс алсын найзууд аа

Сайн байна уу?

Ая дуугаар танилцъя аа.

Сайн байна уу?

Дахилт

Улс улсын найзууд аа

Сайн байна уу?

Уран бүжгээр танилцъя аа.

Сайн байна уу?

(Үг. Ж.Дашдондог, ая: Т.Чимэддорж)



### Үгийн утгыг мэдье

**ЦЭЛМЭГ** - Тэнгэр үүл манан, шороо шуургагүй тунгалаг: цэлмэг өглөө

**ЦЭНГЭГ** - Тунгалаг, цэвэр сайхан: цэнгэг агаараар амьсгалах

“Монгол хэлний хураангуй тайлбар толь”-оос

1 Асуултын дагуу ярилцаарай.

- ✓ Шүлгийн ямар үг анхаарлыг чинь татсан бэ? Яагаад вэ?
- ✓ Шүлгийг уншиж, дууг сонсоход юу бодогдов? Юу төсөөлөгдөв?
- ✓ Зохиолч энэ шүлгээрээ бидэнд юу ойлгуулах гэсэн юм бол?

Б. Тодруулсан үгсийг арын үгээр сольж бичиж болох, болохгүйг тайлбарлаарай.

Газар газрын найзууд аа

Орон орны найзууд аа

Алс алсын найзууд аа

Улс улсын найзууд аа



нутаг нутгийн

тив тивийн

хол холын

хот хотын

Гараа атган танилцъя аа

Олуул сайхан танилцъя аа

Ая дуугаар танилцъя аа

Уран бүжгээр танилцъя аа




бие биеэ тэврэн

бүгдээрээ

баяр хөөрөөр

уран үгээр


 В. Шүлгээ цээжилье.

- Шүлгээ дахин анхааралтай унш. Аль мөрийн үгс давтагдаж байгааг ажиглаарай.
- Мөрийн доторх үг бүрийн эхний үсгийг бичээрэй.
- Түүнийгээ хараад үгсээ санахыг хичээгээрэй.
- Бадаг бүрийн үгийг ингэж бичээд цээжилсэн эсэхээ шалгаарай.

Жишээ нь:

Газар газрын найзууд аа	Г, г, н - аа
Сайн байна уу?	С, б уу
Гараа атган танилцъя аа	Г, а, т - аа
Сайн байна уу?	С, б уу

- 1** Шүлгээ цээжилсэн бол уран уншаарай. Дуу хоолойны өнгө, биеийн хөдөлгөөн, нүүрний хувирлаа тохируулаарай.

 Г. Хэн олон орны нэр хэлэх вэ? Тэмцээн зохиоё. Нэрсийг бичиж, уншаарай.




Австрали улс

Бельги улс




Вьетнам улс

Франц улс

 Д. Дараах өгүүлбэрт өгүүлбэр нэмж, дэвтэртээ бичээрэй.

1. (-ж, -ч) – Казахстан улсад очиж...
2. (-аад) – Германд очоод ...
3. (-н) – Канад улсад аялан...
4. (-соор) – Египетийн Нил мөрнөөр хөвсөөр ...
5. (-магц) – Польш улсын хилээр гармагц ....
6. (-тал) – Энэтхэгийн онгоцны буудалд буутал ...
7. (-хлаар) – Австралийн байгалийн үзэмжийг харахлаар ...
8. (-вал) – Мексикчүүдийн хувцсыг харвал ....
9. (-нгуут) – Кубын тамирчинг ялангуут ...
10. (-нгээ) – Туркийн багийг дэмжингээ ...

## ДАСГАЛ 4

 А. Эхийг анхааралтай уншаарай.

- Уншсанаа бусдад ойлгомжтой ярья.
- Хэсэг тус бүрд харгалзуулсан асуух үгээр асуулт зохиож бичье.



Улс орнууд шинэ жилийн баярыг янз бүрээр тэмдэглэдэг. Энэ тухай танилцъя.

1. Гацуур мод нь үргэлж ногооноороо байдаг тул хүмүүс мөнх амьдралын бэлгэдэл гэж үздэг. Тиймээс гэрээ гацуур модоор чимэглэдэг байна.
2. Эртний хүмүүс чанга дуу чимээ нь муу муухай зүйлийг зайлуулдаг гэж үздэг байжээ. Тийм учраас шинэ жилээр ёслолын буудлага хийдэг болжээ.
3. Италичууд шинэ оны өмнө бүхий л хуучин зүйлээсээ салах хэрэгтэй гэж үздэг. Иймээс 31-ий шөнө хуучин зүйлсээ цонхоор гарган шиддэг байна.
4. Энэтхэгт шинэ жилээр хүн бүр эелдэг зантай байхыг хичээнэ. Учир нь уурласан хүн жилийн турш өөдлөхгүй гэж үздэг.

ЯАГААД?

ЯМАР УЧРААС?

ЮУНААС БОЛЖ?

ЯМАР УЧРААС?



### Үгийн утгыг мэдье

**ээлдэг** - зан байдал зөөлөн, эелдэг зан, ааш араншин сайтай

**өөдлөхгүй** - сайжрахгүй - Ажил амьдрал нь ер өөдлөхгүй юм.


“Монгол хэлний хураангуй тайлбар толь”-оос

- 1 Наурызын баярын утга учир, бэлгэдлийн талаар “тиймээс”, “тийм учраас”, “иймээс”, “учир нь” - гэсэн холбоосыг ашиглан жишээ хэлээрэй.



Б. 2, 3, 4 дүгээр хэсгийн өгүүлбэрүүдийн учир шалтгааны уялдаа холбоог дараах загвараар илэрхийлж бичээрэй.

Жишээ нь: 1 дүгээр хэсэг






В. Зүг чигийг заасан үгсийг мэдэцгээе. Үгсээр гэр, сургууль, дэлгүүр хаана байдаг тухай бусдад зааж тайлбарласан 5 өгүүлбэр зохиож бич.

Жишээ нь:

- Сургууль маань манай гэрийн зүүн хойно байдаг.
- Манай гэр их дэлгүүрийн чанх өмнө зүгт байдаг.



Г. Өгүүлбэрийг гүйцээж бичээрэй.



1. Дундговь аймаг нь Улаанбаатар хотын ..... зүгт байдаг.
2. Сэлэнгэ аймаг Архангай аймгийн ..... зүгт оршдог.
3. Архангай аймаг нь Завхан аймгийн ..... зүгт байдаг.
4. Дорноговь аймаг нь Хэнтий аймгийн ..... зүгт оршино.
5. Сүхбаатар аймаг нь Хэнтий аймгаас ..... зүгт байдаг.
6. Баян-Өлгий аймаг нь Увс аймгийн ..... зүгт оршино.
7. Хэнтий аймаг нь Дорнод аймгийн ..... зүгт байдаг.
8. Дундговь аймаг нь Дорноговь аймгийн ..... зүгт оршино.



Гээгдэхгүй эгшгийн дүрмийг мэдэж авъя.

1. Оноосон нэрийн балархай эгшгийг гээхгүй. Жишээ нь: Улаанбаатарын, Баян-Өндөрөөс

Дараах үгсэд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад эгшиг нь гээгдэхгүй үгсийн ард ✓ тэмдэг тавиарай.

Хонгорын  элс, Арцатын  өвөр, Цэнгэлээс  ирэх,  
 Дуламын  хүү, Санчирын  аав, Идэрийн  ном,  
 Энэтхэгийн  хойг, Дарханы  зам

2. Эгшигт гийгүүлэгч эгшиггүйдэхэд хүрвэл балархай эгшгийг гээхгүй.

77 77 77

Жишээ нь: са**м**барын, сэл**б**эгээс, хөдөл**м**өрөөр

хэл**л**эгийг тогтоох, өгүүл**б**эрийн утга,  
 тайл**б**арыг унших, тэн**г**эрийн заадас,  
 бүргэдийн үүр, бөм**б**өгөө шидэх,

хөгл**ө**рөөд харагдах уулс, бөгл**ө**рөөд  
 битүүрэх, тагл**а**раад битүүрсэн,  
 цугл**а**раад очсон.

3. Заримдаг гийгүүлэгч эгшиггүйдэхэд хүрвэл балархай эгшгийг гээхгүй.

99 99 99

Жишээ нь: нө**х**цөлийн, бод**с**оноос, тус**с**аныг

Нө**х**цөлөө өөрчлөх, бус**д**адаа түгээх,  
 нө**х**дөдөө талархах, мал**ч**дадаа  
 хүргэх, төл**ч**дөдөө туслах, зоч**д**одоо  
 бэлэглэх, чав**х**дасыг хөглөх

Өвд**т**өлөө мөлхөх, баг**т**дагийг нь авах,  
 туйлд**с**аны дараа, нар тус**с**аныг хараад,  
 шаргал**т**саныг хараад, бага**д**дагийг нь  
 солих, өссөнөө бодох, түг**ш**сэнээ нуухгүй

4. Үйл үгийн “-х”-ийн өмнөх балархай эгшгийг гээхгүй.

Жишээ нь: Идэх**э**эс, авчрах**а**ар, харах**ы**н бичих**и**йн учир, хооллох**о**ор суух,  
 амрах**а**а мартаx, туслах**а**а мартаагүй, зогсох**ы**г хориглох, ичих**ээ** мэдэхгүй,  
 хазах**а**ас болгоомжлох, цантах**а**ас хамгаалах

- “бодох” гэсэн үгийг нэрийн тийн ялгалаар хувилгаж бичээрэй.

.....

5. Ялгах эгшгийг гээхгүй. Жишээ нь: аргалын, хоногийг, үнэрээс, ургацын

- Үгсийг зөв холбож бичээрэй.

Дасгал + ын = ..... дэвтэр, ялгах + аа = ..... мартаx, нагац + аас =  
 ..... асуу, чанар+ ын = ..... баталгаа, санал+ аа = ..... өгөх

6. “-ж, -ч, -ш”-ээс бусад гийгүүлэгчийн дараа орсон “-и” эгшгийг гээхгүй.

Жишээ үгсийг сайтар ажиглаарай.

танх**и**мын хурал, соли**р**ын бороо, хор**и**гийг цуцлах, янг**и**рын сүрэг, тамх**и**ны иш,  
 анг**и**рын зулзага, тах**и**лын боов, гурил**а**а исгэх, хур**и**мын бөгж

## ДАСГАЛ 5



А. Баримтыг эвлүүлж, мэдээ бичээрэй. Гарчиг өгөөрэй.

Мэдээний бүтцийг анхаараарай.

Хэн?

Юу?

Хаана?

Хэзээ?

Яагаад?

Юу болов?



**Хэн?** Оюутны “High Tech” клуб

**Юу?** автомат роботын тэмцээн

**Хаана?** Улаанбаатар хотноо

**Хэзээ?** 2019 оны хавар

**Яагаад?** Оюутан, сурагчдын техник сэтгэлгээ, зохион бүтээх авьяас чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэх, бие даан суралцах үйл ажиллагааг сайжруулах

**Юу болов?** Өөрийн бүтээсэн роботоо уралдуулах, шоо цуглуулах, хөл бөмбөг тоглуулах



Б. Зургийг мэдээ болгож яриарай.

### Бүргэдийн баяр



В. “амьсгал, болжмор, тайлбар” – гэсэн гурван үгийг дараах жишээтэй адил тайлбарлаж бичээрэй.

“Аргал, хоргол, шаргал” гэдэг үгс нь 2 үетэй байна. Хоёрдугаар үед нь -га, -го орсон байна. “Хоргол” гэсэн үгэнд “-ын, -ыг” залгаж “хорголыг” гэж бичнэ.

Тиймээс “аргалын, хорголын, шаргалын” гэж адилхан бичнэ шүү дээ. Учир нь “-г” гийгүүлэгчийн дараа орсон “-а,-о-” богино эгшгүүд нь ялгах бас эгшигжүүлэх үүрэгтэй учраас гээж болохгүй юм байна.

# VI БҮЛЭГ. ЭРҮҮЛ АМЬДРАЛ

## ДАСГАЛ 1



А. Эхийг уншаад, мэдэхгүй жимсний нэр байвал бие биеэсээ асуугаарай. Бүлэг бүрд нэг нэг өөр хүнс нэмж нэрлээрэй.

### Хоол хүнсний бүлэг

Хүүхдүүд ээ, та нар хоол хүнсийг хэдэн бүлэгт хуваадгийг мэдэх үү? Хүн эрүүл амьдрахын тулд хоол хүнсээ зөв сонгож сурах нь чухал. Бүх төрлийн хоол хүнсийг 6 бүлэгт ангилдаг. Хүний биед хэрэгтэй шим тэжээлийн бодисыг хэр агуулсан бэ? гэдгээс хамааран хуваадаг байна. Үүнд:

**Нэгдүгээрт:** Жимс, жимсгэний бүлэг

- алим, лийр, усан үзэм, гүзээлзгэнэ

**Хоёрдугаарт:** Үр тарианы бүлэг

- буудай, арвай, шар будаа, эрдэнэ шиш

**Гуравдугаарт:** Хүнсний ногооны бүлэг

- лууван, байцаа, манжин, сармис

**Дөрөвдүгээрт:** Мах, махан бүтээгдэхүүний бүлэг

- мах, хиам, өндөг, загас

**Тавдугаарт:** Сүү, цагаан идээний бүлэг

- сүү, ааруул, тараг

**Зургаадугаарт:** Өөх тосны бүлэг

- өөх, ургамлын тос, шар тос, өрөм



Б. Даалгаврыг хийгээрэй.

- Үгсийг үеэр таслаарай. алим, арвай, байцаа, загас
- 3 дугаар бүлгийн үгсэд “-ийн, -ы” нөхцөлийг залгаж бичээрэй.
- “үзэм, өндөг, тараг, өрөм” гэсэн үгсэд “-аар<sup>4</sup>” нөхцөл залгаж бичээд, дүрмийг тайлбарлаарай.
- 1 дүгээр бүлгийн бүтээгдэхүүний өнгийг бичиж, холбоо үг үүсгээрэй.
- 5 дугаар бүлгийн үгсэд “бүрэх, хөөрүүлэх, тавих” гэсэн үйл үгсийг утга тохируулж холбож бичээрэй.
- 2 дугаар бүлгийн үгсээс сонгон 2 өгүүлбэр зохиогоорой.
- 4 дүгээр бүлгийн үгсэд 2 асуулт зохиож бичээрэй.



В. Өгүүлбэрийг анхааралтай уншаад, тохирох нөхцөлийг бичиж, өгүүлбэрийг төгсгөөрэй. ( -на, -нэ, -но, -нө, -жээ, -чээ, -лаа, -лээ, -лоо, -лөө, -в )






- Дүү маань өчигдөр сайхан айраг уу... .
- Би өдөр ногоотой хоол захиал.... .
- Ээж минь төмс шарж бай.... .
- Ах маань өчигдөр будаатай хуурга хий.... .



Г. Эхний эгнээний зураг бүрийн санааг хоёр өгүүлбэрээр илэрхийлж бичээд, найздаа зөвлөгөө өгөөрэй. Хоёр дахь эгнээний зургийн дагуу найзаасаа зөвлөгөө сонсоорой.

Зөвлөгөө өгөхийн тулд:

- Тухайн зүйлийнхээ талаар уншиж, дэвтэртээ тэмдэглээрэй.
- Найздаа буруу, зөвийг ойлгуулахын тулд жишээ сайн хэлээрэй.
- Сайн сонсогч байхаа мартав аа.



Д. Хүүхдүүд ээ, багаараа сэдвийн хүрээнд уншиж судлан хэлэлцүүлэг хийгээрэй.

### Манай сургуулийн хоолны газар

- Сургуулийнхаа хоолны газар иддэг хоол хүнсээ бүлэглэх, аль бүлгээс олон хүнс хэрэглэдэг талаар дүгнэх
- Сургуулийнхаа хоолны газрыг ямар байгаасай гэж хүсдэгээ илэрхийлэх
- Өөрийн санаагаа жишээгээр сайн тайлбарлах
- Санаа бодлоо итгэлтэй илэрхийлэхийн тулд яриагаа сайн бэлдэх

### Анхааралтай уншаарай.


Хэлэлцүүлэгт бие биеэ анхааралтай сонсох нь маш чухал. Бусдын яриаг яаж сонсож байгаагаар хүмүүсийг “Идэвхтэй сонсогч”, “Идэвхгүй сонсогч” гэж ангилдаг.

Чи ямар сонсогч вэ? Идэвхтэй сонсогч:

- Ярилцаж байгаа хүн рүүгээ анхаарлаа хандуулдаг.
- Толгой дохиж анхаарч сонсож байгаагаа илэрхийлдэг.
- Асуух зүйлээ тэмдэглэж байгаад дараа нь асуудаг.

Идэвхгүй сонсогч:

- Ярьж байгаа хүний яриа дуусаагүй байхад ярьдаг.
- Хүний яриаг бүдүүлгээр тасалдаг.
- Хүн ярьж байхад өөр зүйл хийдэг, өөр зүйл боддог.

 А. Анхааралтай уншаад, юу ойлгосноо ярилцаарай.

### Би хооллох төлөвлөгөө зохиов

Би сар гаруйн өмнөөс эрүүл хооллох тухай судалж өөрийн амьдралд нэвтрүүлэхээр шийдсэн. Шинэ зүйлд суралцахад үргэлж л хичээл зүтгэл шаарддаг.


Хоолны төлөвлөгөө бол чи болон танай гэр бүл нэг долоо хоног, нэг сарын туршид юу идэх вэ? гэдгээ шийдэх юм. Би ажлынхаа цайны цагаар авч явсан тав хоногийн хооллох төлөвлөгөөгөө танилцуулъя. Зөвхөн өдрийн хоолны цэс шүү.

Тав хоногийн өдрийн хоолны төлөвлөгөө.

гараг	хоол	миний сэтгэгдэл
даваа	Гурвалжин будаатай хуурга: (тахинаны мах, дүүпүү, броколь, лууван)	Тэр чигтээ эрүүл хооллолт байсан.
мягмар	Овьёос + шинэ тараг	Овьёос нь ер нь өдрөө даадаг байх. Ходоод амарч байгаа юм шиг мэдрэмж төрсөн.
лхагва	Будаатай хуурга: (хонины мах, лууван, өндөг, будаа)	Энэ хоолыг ээж минь надад бэлтгэж өгсөн. Ээжийн сэтгэл шингэсэн амттай шинэхэн хоолоор өдрийг амжилттай давсан шүү.
пүрэв	Ногоотой шөл: (хонины мах, бууцай, юуцай, сонгино, лууван, шош)	Ходоод маань их хөнгөн байсан. Хоол хурдан шингээд сайхан мэдрэмж төрсөн.
баасан	Жигнэсэн байцаатай хуурга: (мах, ногоон сонгино, чинжүү, байцаа)	Бусад хоолноос ялгаатай нь бүх хүнсээ жигнэж болгосон.

Миний таван өдрөөр бэлтгэсэн хоолны төлөвлөгөө тун амжилттай байсны дээр сэтгэл санаа өөдрөг болж, гадуур хооллох гэдгийг мартаж орхив. Гэрээсээ эрүүл, шинэ хоол бэлтгэж авчрах төлөвлөгөө үнэхээр “зохиж” байсан шүү.

### 1 Үгийн утгыг мэдье.





## Б. Хооллох төлөвлөгөө байх хэрэгтэй юу? сэдвээр хэлэлцүүлэг хийгээрэй.

“Хоолны төлөвлөгөө бол чи болон танай гэр бүл нэг долоо хоног, нэг сарын туршид юу идэх вэ? гэдгээ шийдэх юм.”

- ✓ Гэртээ хоолны төлөвлөлт хийдэг үү?
- ✓ Хоолны төлөвлөлт хийхийн ач тус юу вэ?
- ✓ Гадуур хооллох, гэртээ хооллох хоёрын аль нь эрүүл мэндэд тустай вэ?
- ✓ Эрүүл хооллох талаар чи хаанаас мэдээлэл авдаг вэ?



Бие биеийнхээ ярианаас тодруулан асуугаарай.



Бие биедээ ээлж дараагаар асуулт тавиарай.



Ярьж байгаа найз руугаа толгой дохиж, инээмсэглээрэй.



Өөрийгөө хэр сайн сонсогч байснаа дүгнээрэй.



## В. Өгүүлбэр бичье.

- 1 Хүнсний бүтээгдэхүүний найрлагын хүснэгтэн мэдээллийг уншаарай. Бүтээгдэхүүнээс гурвыг сонгон тайлбарлаж бичээрэй. Найз нартаа яриарай.

Жишээ нь: Сүү: Нэг аяга буюу 200 гр сүү нь 125 калори илчлэгтэй, 11 гр нүүрс ус, 6 гр уураг, 6 гр өөх тос агуулдаг.

Хүнсний бүтээгдэхүүний ангилал, төрөл	хэмжээ	илчлэг (ккал)	шимт бодис (гр)				
			нүүрс ус	уураг	өөх тос		
 Сүүний төрөл	сүү	200г	1 аяга	125	11	6	6
	тараг	200г	1 аяга				
	ааруул	25г	2г дунд				
	аарц	125г	хагас аяга				
	ээдэм	20г					
	бяслаг (монгол)	15г					
	ээзгий	30г	2 ц.т халбага				
	хуурай сүү	25г	5 ц.ж халбага				

- 2 Цэгийн оронд утга тохирох үгийг сонгож, өгүүлбэрийг гүйцээгээрэй.

	Өгүүлбэр:	Сонгох үг:	
1	..... жингүй байх	илүүдэл	хэт их
2	Өглөөний цайгаа ..... уух	заавал	тогтмол
3	Ургамлын гаралтай ..... их хэрэглэх	бүтээгдэхүүнийг	ногоог
4	Кальци агуулдаг бүтээгдэхүүнийг ..... хэрэглэх	түлхүү	үргэлж

3 Үгсийг зөв байрлуулж, “Эрүүл амьдаръя” гэсэн зөвлөмж бичээрэй.

- уух, цайгаа, Өглөөний, тогтмол
- Шингэн, уух, тогтмол, зүйл
- хэрэглэх, бүр, идээ, өдөр, Цагаан
- хүнсний, хэрэглэх, ногоог, Жимс
- хийжүүлсэн, Чихэр, хоолноос, ундаа, татгалзах, түргэн

4 Үйл үг бүрээр дөрвөөс доошгүй үгтэй өгүүлбэр зохиогоорой.

шарж байна. чанана. жигнэв. буцаллаа.



**Зөв бичье.** "-ъ, -ь" тэмдэг үсгийн зөв бичих дүрмийг уншиж, ярилцаарай.

Эр үгэнд “-я, -ё” эгшиг өмнөх гийгүүлэгчээсээ салангидуудагдахаар орвол өмнө нь хатуугийн тэмдгээр тусгаарлаж бичнэ.

Жишээ нь: *Авъя, олъё, угтъя, сонсъё, уншъя, харъя, бодъё, чадъя, хадъя, босъё, гаръя, суръя.*

Эм үгэнд “-е” эгшиг өмнөх гийгүүлэгчээсээ салангидуудагдахаар орвол өмнө нь зөөлний тэмдгээр тусгаарлаж бичнэ.

Жишээ нь: *өгье, үзье, тэнцье, мэдье, хүсье, бичье, идье, нисье, үзье, өгье, хэлье, тэмцье*

Эгшиг ба зөөлний тэмдгийн дараа “-я, -е, -ё, -ю” залгахад өмнө нь хатуу, зөөлний тэмдэг (-ъ, -ь) бичихгүй.

Жишээ нь: *саная, хичээе, олгоё, байя, хөгжөөе, хүргэе, барья, орхиё, цохъё, харья, сольё, бүтээе.*



Г. Аль үгийг зөв бичсэн байна вэ? Тэмдэглээрэй.

- |                                |                                   |                                  |                               |
|--------------------------------|-----------------------------------|----------------------------------|-------------------------------|
| <input type="checkbox"/> аялъя | <input type="checkbox"/> танилца  | <input type="checkbox"/> тоголъё | <input type="checkbox"/> яра  |
| <input type="checkbox"/> аялая | <input type="checkbox"/> танилцъя | <input type="checkbox"/> тоглоё  | <input type="checkbox"/> ярья |

1 Аль үгийг зөв бичсэн байна вэ? Тэмдэглээрэй. Олсон үгийнхээ дүрмийг тайлбарлаарай.

- |                                    |                                    |                                    |                                    |
|------------------------------------|------------------------------------|------------------------------------|------------------------------------|
| <input type="checkbox"/> хөөцөлдөө | <input type="checkbox"/> хөөцөлдье | <input type="checkbox"/> хөөцөлдэе | <input type="checkbox"/> хөөцөлдие |
| <input type="checkbox"/> судлая    | <input type="checkbox"/> судалье   | <input type="checkbox"/> судалъя   | <input type="checkbox"/> судалая   |

## ДАСГАЛ 3



А. Шүлгийг уран, тод уншаарай. Шүлэгт аль ногоо, жимсний “хэлбэр”-ийг, аль ногоо, жимсний “өнгө”-ийг тодотгосон байгааг ажиглаж ярилцаарай.

### Амин дэм



Улаан лууван



Хумстай сармис



Шар манжин



Улаан алим



Ногоон сонгино



Улбар жүрж



Навсгар байцаа



Бөндгөр шийгуа



Бөөрөнхий төмс



Бор үзэм

Бултаараа амттай амин дэм  
Бүгдээрээ амттай амин дэм

1 Шүлэгт дүрсэлсэн ногооны өнгө болон хэлбэрийг өөрчилж бичье.

**хэлбэр:**

лууван  
манжин  
сонгино  
байцаа


**өнгө:**

төмс  
шийгуа  
үзэм  
сармис

2 Ногоог юутай адилтгаж зурсныг ажигла. Нэг ногоо юм уу, жимс сонгоод зураарай. Яагаад тэгж зурснаа тайлбарлаарай. Сонгосон ногоо, жимснийхээ ашиг тусын тухай нэг өгүүлбэр бичиж уншаарай.



**Байцаа:** Би чиний ходоод гэдэс эрүүл байхад тустай.



**Тарвас:** Би чиний биеийн шингэнийг нөхөж өгнө.



**Сонгино:** Би ханиадны нянг устгана.

**Лууван:** Би А амин дэм ихтэй тул нүдэнд тустай.





Б. Цэгийн оронд утга тохирох үгийг сонгож, өгүүлбэрийг гүйцээж бичээрэй.

- Туулай ..... дуртай.
  - 1. лууван                      2. лууванд                      3. лууванг
- ..... навч олон давхар байдаг.
  - 1. байцаа                      2. байцаанд                      3. байцааны
- .....шөл биед тустай.
  - 1. сармистай                      2. сармисны                      3. сармис
- ..... цардуул их байдаг.
  - 1. төмснөөс                      2. төмстэй                      3. төмсөнд



В. Дараах нэрсийг зургаас олж заагаарай.



1 Зургаас сонирхолтой асуух өгүүлбэр дөрвийг зохиож, бие биеэсээ асуугаарай.

Жишээ нь:

Явган явах хурдан уу?  
Дугуйгаар явах хурдан уу?



Г. Үгсэд "-я, -е, -ё" залгаврыг зөв залган бичээрэй. Үгсийг зөв дуудан уншаарай.

хураа	соль	инээ	шид	хуул
тойруул	тохир	гүйлд	уулга	хад
гүйцээ	ороо	хорь	оё	бүр
урь	өг	аял	асар	уя
тэл	буц	нэмнэ	бич	тэмдэглэ
баримтал	сана	захь	заа	оно



А. Хурдан, ойлгож уншъя. Минутын уншлага хийгээд, өөрийгөө үнэлээрэй.



### Аяллын маршрут

Хүүхдүүд ээ, та нар аялах дуртай юу? Эзэн Чингис хааны өлгий нутаг, байгалийн үзэсгэлэнт Хэнтий аймгийн “Дадал сум”-ын нутгаар аялахыг урьж байна.

Дадал сум нь Улаанбаатар хотоос 600 километр зайтай оршдог.

Өглөө эртлэн босож, эзэн Чингис хааны өлгий нутгийн зүг хөдөлнө.

Хэнтий аймгийн төвөөр дайран, цааш давхисаар “Дадал сум”-д ирж хононо. Шинэхэн цөцгий, буриад талхтай өглөөний цайгаа уусны дараа байгалийн үзэсгэлэнт “Гурван нуур”-ын дэргэд байх Чингисийн гэрэлт хөшөөг үзээд, цааш Чингис хааны төрсөн газар “Дэлүүн болдог”-т очно.

Тэндээсээ эртний түүхт “Түнхлэг горхи”-ны уснаас амсаж, үдийн хоолоо нарсан ойн цоорхойд идээд, “Анчин Баавайн гэр музей” үзээд буудалдаа ирж амарна.

Маргаашийн ургах нарнаар байгалийн үзэсгэлэнт “Онон, Балж гол”-оор аялал үргэлжилнэ. Аяллын цүнхээ аваад, хамтдаа дурсамж бүтээцгээе.

Өөрийгөө үнэлээрэй:

1 минутад уншсан үгийн тоо

Амандаа үглэж уншсан уу?

Нүдээрээ гүйлгэн уншсан уу?




Б. Дараах загварыг хараад эхийн “Эхлэл – гол – төгсгөл” -ийг зөв олсон эсэхийг ярилцаарай. Мөн бол яагаад вэ? Биш бол яагаад вэ? гэж ярилцаарай.

эхлэл

Хүүхдүүд ээ, та нар аялах дуртай юу? Эзэн Чингис хааны өлгий нутаг, байгалийн үзэсгэлэнт Хэнтий аймгийн “Дадал сум”-ын нутгаар аялахыг урьж байна.

Хаашаа аялах вэ?

гол

Дадал сум нь ..... Онон, Балж гол”-оор аялал үргэлжилнэ.

Хаагуур хаагуур аялах вэ?

төгсгөл

Аяллын цүнхээ аваад, хамтдаа дурсамж бүтээцгээе.

Аялалд уриалсан.

- 1 Дараах хоёр хэсгийн аль нь “Эхийн эхлэл”, аль нь “Эхийн төгсгөл” хэсэг байж болохыг ярилцаарай. Аль үгнээс тийм бодол төрж байгаагаа тайлбарлаарай.



"Байгалийн сайхан цогцолсон хангай говийн дундах сувдан цэнхэр нууранд эргэж заавал ирнэ дээ" гэсэн орхиж явмааргүй хоргодох сэтгэлээ тээсээр хот руугаа буцлаа.

Удаан хүлээсэн зун цаг ирж, аяллын бэлтгэлээ базаан, их хотоос ургахын улаан нартай уралдан хөдөллөө.



В. Чи аялалд явахдаа юу юу авч явах вэ? Яагаад түүнийг авч явах ёстойг тайлбарлаж яриарай.

- 1 Зурагт байгаа аяллын хэрэгслийг нэрлээрэй. Холбоо үг бүтээгээрэй.



Жишээ нь:

хоёр нүдний дуран



Г. Тухайн үгсэд “-я, -ё, -е” нөхцөлийг залган бичээд, дүрмийг тайлбарлаарай. Үгсийг зөв дуудан уншаарай.

хар	мэд	гарга	бод	үзүүл	өргө	морд	олго
тар	мэдэгд	нээ	гар	бэхэл	шийд	ангил	эмж
сөгд	хай	уутал	харай	мэхий	бахарх	жигнэ	тушаа

## ДАСГАЛ 5

### Мэдээг

- Үзсэн харснаа бусдад түгээхийн тулд
- Бусдад сургамж өгөхийн тулд
- Бусдын хийсэн сайн үйлээр бахархахын тулд

хүргэдэг



Ангидаа болсон  
үйл явдал



Сургууль дээр  
болсон явдал



Аймагтаа, нийслэлд  
болсон үйл явдал



А. Мэдээг уншаад, асуултын дагуу задалж ярилцаарай.

### Хөдөлгөөн – Эрүүл амьдрал



Манай сургуулийнхан бага, дунд, ахлах ангийн сурагчдын дунд “Хөдөлгөөн ба эрүүл амьдрал” уриатай явган аяллыг 2022 оны 09 сарын 24-ний амралтын өдрөөр зохион байгуулав.

Байгалийн сайханд явганаар аялах энэ үйл ажиллагааг жил бүрийн намар зохион байгуулдаг.

Явганаар аялах нь биеийн тамирын дасгал болоод зогсохгүй утаанаас холдож, эрүүл агаар амьсгалах боломжийг олгоно. Оюуны хөдөлмөр эрхэлж буй сурагчид хотын дуу чимээ, утаа униар, цахилгаан долгионы орчноос холдож ядарсан бие, тархи оюунаа амрах сайхан боломж байдаг тул хүүхдүүд маш идэвхтэй оролцдог юм. Эрүүл амьдрахын үндэс нь хөдөлгөөн юм.

хэн?	юу?	хаана?
хэзээ?	яагаад?	юу болов?

1

Танай сургууль “Эрүүл амьдрах” талаар ямар ажил зохион байгуулдаг вэ? Эргэцүүлэн бодоорой.



Санамжийг уншиж, ойлгож аваарай.

Мэдээ бичихдээ нэг үгийг олон давтах, зарим үгийг илүү хэрэглэх, бас буруу байрлуулах зэрэг алдаа гаргахаас сэргийлээрэй. Найруулгын алдааг ийм тэмдгийн тусламжтайгаар засдаг юм шүү.

Үг давтсан бол: хадгалаарай

Үг илүүдсэн бол: нарны шил өнгөтэй

Үг дутсан бол: Нарны хөх, цэнхэр шил- нарны хөх, цэнхэр өнгөтэй шил

Үг буруу байрлуулсан бол: очсон

Зэрэгцээ үгийн байр солих бол: "Хөх, цэнхэр өнгөтэй нарны шил - нарны хөх, цэнхэр өнгөтэй шил

## VII БҮЛЭГ. АМЬТАД

### ДАСГАЛ 1



А. Харилцан яриа зохиож бичье. Асуулт, хариултаа товч, тодорхой бичээрэй.



- Муур хулгана хоёр юуны тухай ярьж байгаа бол?
- Муур юу гэж асуусан бол?
- Хулгана юу гэж хариулсан бол?
- Харилцан яриаг төсөөлөөрэй.
- Төсөөлж байгаа санаагаа тэмдэглээрэй.
- Тэд юу гэж ярилцсаныг зохиогоорой.

Хүмүүсийн харилцан яриаг тэмдэглэхдээ богино зураас (-) хэрэглэнэ.

Богино эгшиг, гийгүүлэгчээр төгссөн эр үгэнд **"-уу"**, эм үгэнд **"-үү"** бичнэ.

"-в,-л,-м,-н" үсгээр төгссөн үгэнд **"бэ?"** бичнэ. "-в,-л,-м,-н" -ээс бусад үед **"-вэ"** бичнэ.

Урт, хос эгшгээр төгссөн үгийн дараа **"-юу, -юү"** - г эгшиг зохицох ёсоор залгана.



Б. "Ямар амьтан бэ? Таагаарай" тоглоом тоглоё. Асуултаа товч, тодорхой хэлээрэй.

**Тоглоомын дүрэм:** Нэг амьтны зураг сонгон, найзынхаа ар талд тогтооно. Найз чинь ямар амьтан болохыг асуулт асуусаар мэдэж авна. Асуултын жишээ: Том жижиг, өнгө зүс, хуурай газрын, усны, хөдөлгөөн, юу иддэг ...




- Энэ амьтан нисдэг үү?
- Үгүй ээ, чадахгүй.
- Энэ амьтан хуурай газрын амьтан уу?
- Тийм ээ, хуурай газар амьдардаг.
- Энэ амьтан том уу?
- Тийм ээ, том.
- Энэ амьтан хүрэн өнгөтэй юу?
- Тийм ээ, хүрэн өнгөтэй.
- Тэгвэл тэмээ мөн үү?
- Биш ээ, тэмээ биш.
- Тэгвэл баавгай юу?
- Тийм ээ, баавгай мөн.



В. Цэгийн оронд “Зохиогчийн үг”, “Баатрын үг” нэмж, үлгэрийг гүйцээж бичье.



Жишээ нь: Дараах үлгэрийн эхний өгүүлбэрт “Зохиогчийн хэлсэн үг”, “Баатрын хэлсэн үг”-ийг өнгөөр ялгав.



Нэгэн удаа илжиг бард хандан “Өвс бол цэнхэр өнгөтэй” гэж хэлж гэнэ.

**Бар:** “Яалаа гэж, өвс чинь ногоон өнгөтэй байхгүй юу” ..... (зохиогчийн үг)

**Илжиг:** “Эрхэм дээдэс ээ, өвс бол цэнхэр өнгөтэй биз дээ?” .....(зохиогчийн үг)

**Арслан:** “Тийм ээ, үнэн. Өвс цэнхэр өнгөтэй” ..... (зохиогчийн үг)

**Илжиг:** “Бар өвсийг ногоон гээд надтай санал нийлэхгүй, маргалдаад байгаад нь миний дургүй их хүрч байна. Түүнийг шийтгэж өгнө үү.” ..... (зохиогчийн үг)

**Арслан:** ..... (баатрын үг) гэж тунхаглав...

Илжиг жигтэйхэн баяртайгаар “Өвс бол цэнхэр өнгөтэй, өвс бол цэнхэр өнгөтэй” гэж дуулсаар цааш одов.

1 “Үйл явдал цааш яаж үргэлжлэх бол” гэдгийг таамаглан ярилцаарай.



Г. Үлгэрээ гүйцээгээд бие биедээ уншаарай.

- Хэн хамгийн сонирхолтой “Зохиогчийн үг”, “Баатрын үг” бичсэн байна вэ?
- Чамд илжиг, бар, арслан гурвын хэн нь таалагдаж байна вэ? Яагаад вэ?
- Чи аль баатар нь байсан бол юу хийж, юу хэлэх байсан бэ? Ярилцаарай.

## ДАСГАЛ 2



А. Багаараа хамтарч, нэгэн өдрийн тэмдэглэл бичье.

- Бүгдээрээ сумынхаа фермд нэгэн өдрийг өнгөрүүлж байна гэж төсөөлье. Ажил өрнөсөн фермийн талаар дэлгэрэнгүй тэмдэглэл бичиж үлдээе.
- Багууд юуг тэмдэглэх вэ? гэдгээ сонгож бичээд, дараа нь нийлүүлж, уншъя.

- ✓ Фермд юу юу байна вэ? нэрлэе.
- ✓ Фермд ямар ямар үйл явдал болж байна вэ?
- ✓ Фермийн юмс ямар ямар өнгөтэй байна вэ?
- ✓ Үйл явдал фермийн хаана хаана болж байна вэ?
- ✓ Фермийн цаг агаар, байгаль орчин ямар байна вэ?
- ✓ Фермд өнгөрүүлсэн нэг өдрийн сэтгэгдэл ямар байсан бэ?


Тэмдэглэл бичсэн он сар өдөр



## ДАСГАЛ 3



А. “Хурдан морины цол”-д адууны шинжийг юу юутай адилтгасан байна вэ? Яагаад вэ? гэдгийг зургийг харж тайлбарлаж яриарай.



Заан сайхан соёотой  
Засмал сайхан дэлтэй




Хун цэнгийн дуутай  
Хулан тахийн хурдтай



1 Шүлгийг уншиж, тайлбарлаж ярилцаарай.

Дөрвөн хөлтэй ширээ шиг  
Дөрвөлжин зоотой арслан шиг  
Уул хангайн буга шиг  
Усан цээлийн загас шиг  
Жиргэн нисэх шувуу шиг  
Жирэлзэн үзэгдэх  
Зэрэглээ шиг



Хурдан морины биеийг  
яагаад “Ширээ, арслан,  
буга” шиг гэсэн юм бол?

Хурдан морины хурдыг  
яагаад “Загас, шувуу,  
зэрэглээ шиг” гэсэн юм бол?



### Үгийн утгыг мэдье

**зоо** - мал амьтны нуруу

**цээл** - урсгал усны гүн цүнхээл газар

**зэрэглээ** - газрын уур дээш хөөрч алсад усны урсгал мэт харагдах үзэгдэл


“Монгол хэлний хураангуй тайлбар толь”-оос



А. Үлгэрийг “Үлгэрч өвөө” шиг уншаарай. Үлгэрийн баатруудыг хуваарилж аваад, дуу оруулж, жүжигчлэн тоглоорой.

- ✓ Аль баатар ямар зантай вэ?
- ✓ Гадаад төрх байдал нь ямар вэ?
- ✓ Дуу хоолойны өнгө нь ямар байх вэ? зэргийг төсөөлж яриарай.

### Заан хулгана хоёр



Эрт урьд цагт Энэтхэг оронд нэгэн баян хаан байжээ. Түүний эрдэнэсийн дээд чандмань эрдэнийг нэгэн хулгана авсан учир хаан ихэд хилэгнэж, түүнийг барьж шийтгэхийн тулд гүн харанхуй, хүйтэн худаг ухуулжээ.

Гэтэл тэр худагт нь гэмгүй нэгэн хөөрхий хулгана унаад, гарч чадаагүй тул өлбөрөхөд

хүрэв. Энэ үед хааны тэжээсэн нэгэн заан худгийн дэргэд ирж, учрыг мэдээд худаг руу сүүлээ унжуулан, эцэж тамирдсан хулганад тусалжээ. Зааны сүүлээр дамжин гарсан өнөө хулгана:

- “Энэ их ачийг тань хэзээ нэгэн цагт хариулна аа” гэж бувтнахад, Заан:
- Чи ийм бяцхан амьтан. Миний ачийг яаж хариулж чадах билээ. Би хариу хүсээгүй. Зүгээр л буян санаж тусаллаа гэв. Хулгана:
- “За яах вэ. Тэр цагт учирья. Бяцхан гэж намайг битгий бодоорой” гээд салжээ.

Хожим заан гуунд унаад, хөгширсөн учир босож чадахгүй хэвтэж байхад нь нөгөө хулгана тааралджээ.

Хулгана даруй сүргээ дуудаж, зааны унасан эргийг ухаж, нураагаад ачтанаа авраад амар сайхандаа жаргажээ.



### Үгийн утгыг мэдье

**хилэгнэх** - уурлах, хилэн төрөх

**чандмань** - Үлгэр домогт гардаг хүслийг хангагч эрдэнэ.

**өлбөрөх** - Өлсөхийн туйлд хүрэх

**эцэж тамирдах** - Ядрах

**бувнах** - Амандаа үглэх

**гуу** - ганга жалга

“Монгол хэлний хураангуй тайлбар толь”-оос



Б. "Заан хулгана хоёр" эхийн тухай хариултаас "тийм", "үгүй"-г сонгож ярилцаарай.

Хариулт	тийм	үгүй
Хааны чандмань эрдэнийг нэгэн хулгана авсан учир хаан ихэд хилэгнэсэн.		
Эрдэнэ авсан хулгана нүхэнд унасан.		
Нүхэнд унасан гэмгүй хулгана өлбөрөхөд хүрэв.		
Заан хошуугаа унжуулан эцэж тамирдсан хулганад тусалжээ.		
Заан хариу хүсээгүй, буян санаж тусалсан.		
Хожим заан гуунд унасан учир босож чадахгүй хэвтэж байсан.		
Хулгана бяцхан учир тусалж чадаагүй.		



В. Үлгэрийг дахин уншаарай. Үлгэрээс зохиогчийн үг, баатрын үгийн жишээ 1, 1-ийг бичээрэй.

Энэ их ачийг тань хэзээ нэгэн цагт хариулна аа.

↑

Баатрын үг



Эрт урьд цагт Энэтхэг оронд нэгэн баян хаан байжээ.


↑

Зохиогчийн үг

- Үлгэрт “Зохиогчийн үг”, “Баатрын үг” хоёрын аль нь олон байна вэ?



Г. Аливаа үйл явдал “Эхэлдэг, үргэлжилдэг, төгсдөг”. Уншсан үлгэрээ загварын дагуу батлан ярилцаарай.







Д. Үлгэрийн үйл явдал яагаад үргэлжилдгийг уншиж, ойлгоё.

- Үлгэрийн эхний үйл явдал цааш "Яаж үргэлжилж, яаж өрнөсөөр, яаж төгссөн бэ?" гэдгийг дахин нэг хараарай.


1 Дэвтэртээ үлгэрийн бүх үйл үгийг дарааллаар нь түүж бичье. Эхлэл, төгсгөлийн хооронд ямар ямар үйл явдал болсныг ажиглая.



2 Үлгэрийн үйл явдал ямар учраас цааш үргэлжлээд, өрнөөд байгааг мэдэцгээе. Асуултад "учраас" гэсэн үгийг хэрэглэн, хариулж ярилцаарай.



3 Өнгөөр тодруулсан үгсийг ажиглаарай.  
... авсан учраас хилэгнэсэн, хилэгнэсэн учраас шийтгэхийг хүссэн, шийтгэхийг хүссэн учраас худаг ухуулсан.



4 "Үйл явдал "ШАЛТГААН"-аас болж үргэлжлээд, өрнөж байна" гэдгийг ярилцаарай.



Е. Эхийг уншаарай. "Нохой муур хоёр хоорондоо таардаггүй" гэдгийг зөвшөөрөх үү?

### Нохой муур хоёр

Нохой муур хоёр бие биеэ ойлгодоггүй. Учир нь тэдний биеийн хэл нь өөр юм. Жишээлбэл муур нохойг айлгахын тулд урд савраа өргөдөг. Үүнийг нь нохой "Тоглох гэж байна" гэж ойлгодог. Учир нь нохой тоглохыг хүссэн үедээ ийм үйлдэл хийдэг байна. Харин муур таатай байгаа үедээ цээжээ хүржигнүүлдэг. Гэтэл энэ нь нохойд аюултай санагдана.

Нохой эзнээ хараад сүүлээ өргөж баярладаг. Харин муур эзнийхээ хөлийг шөргөөн намуухан хүржигнэж таатай байгаагаа илэрхийлдэг. Нохой ямар ч үед эзнээ дуудвал баярлан гүйж ирдэг бол муур өөрөө хүсвэл очно. Ингээд л муур нохой хоёр таардаггүй аж.

- 1 Дараах загварыг анхааралтай ажиглаж, бие биедээ тайлбарлаарай. Загвараас "Яагаад, ямар учраас" гэсэн 4 асуух өгүүлбэр зохиож бичээд, бие биеэсээ асуугаарай.

Жишээлбэл муур, нохойг айлгахын тулд урд савраа өргөдөг. Үүнийг нь нохой "Тоглох гэж байна" гэж ойлгодог. Учир нь нохой тоглохыг хүссэн үедээ ийм үйлдэл хийдэг байна.



Харин муур таатай байгаа үедээ цээжээ хүржигнүүлдэг. Гэтэл энэ нь нохойд аюултай санагдана.

Нохой эзнээ хараад сүүлээ өргөж баярладаг.



Харин муур эзнийхээ хөлийг шөргөөн намуухан хүржигнэж таатай байгаагаа илэрхийлдэг.

Нохой ямар ч үед эзнээ дуудвал баярлан гүйж ирдэг бол



муур өөрөө хүсвэл очно.



Учир нь тэдний биеийн хэл нь өөр юм.



Нохой муур хоёр бие биеэ ойлгодоггүй.



Ингээд л муур нохой хоёр таардаггүй аж.



## ДАСГАЛ 5



А. Дараах амьтдын тухай мэдээллийг интернетээс, номоос уншиж, асуултад бүрэн, гүйцэд хариулж бичээрэй.

**Амьтны нэр:** Заан

**Амьдардаг газар:** Африк, Энэтхэг

**Иддэг зүйл:** Өвс, навч, модны үндэс, жимс

**Төрх байдал:** Жижигхэн нүд, том чих, урт хошуу, хоёр соёо, дөрвөн хөл, урт сүүл

**Өндөр:** 3 метр орчим

**Урт:** 6 – 7.5 метр

**Жин:** 4000 кг хүртэл

**Нас:** 60 – 70 жил



**Амьтны нэр:**

**Амьдардаг газар:**

**Иддэг зүйл:**

**Төрх байдал:**

**Өндөр:**

**Урт:**

**Жин:**

**Нас:**



**Амьтны нэр:**

**Амьдардаг газар:**

**Иддэг зүйл:**

**Төрх байдал:**

**Өндөр:**

**Урт:**

**Жин:**

**Нас:**



**Амьтны нэр:**

**Амьдардаг газар:**

**Иддэг зүйл:**

**Төрх байдал:**

**Өндөр:**

**Урт:**

**Жин:**

**Нас:**






Б. Өмнө бичсэн амьтдын тухай баримтаас нэгийг сонгон “Мэдээ” бичээрэй.

- Зарим нэг сонирхолтой баримтыг нэмж болно шүү.
- Тоон болон график мэдээлэл оруулбал сайн шүү.
- Холбогдох сонирхолтой зургийг мөн оруулаарай.
- Мэдээгээ телевизийн нэвтрүүлэгч шиг уншаарай.

1

Өмнө бичсэн баримтыг хэрхэн мэдээ болгосныг анхааралтай уншиж, санаа аваарай.

### Заан хамгаалах өдөр болов.



Заан хамгаалах олон улсын өдрийг 2021 оны 6 дугаар сарын 20-ы өдөр дэлхий даяар тэмдэглэж өнгөрүүллээ.

Заан эрт цагт амьдарч байсан арслан зааны ойрын төрөл, хуурай газар дээрх хамгийн том амьтан. Африк, Энэтхэгт амьдардаг.

Насанд хүрсэн зааны иддэг хоолны хоногийн дундаж хэмжээ 150-300 кг бөгөөд өвс, навч, модны үндэс, бүх төрлийн жимс иднэ.

Зааны ой санамж маш сайн. Гомдоосон, баярлуулсан аль алиныг хэзээ ч мартдаггүй ажээ. Зааны соёог авах гэж маш ихээр устгадаг тул хурдан ховордож байгаа амьтан юм.

Нас: 60 – 70 жил

Жин: 4000 кг хүртэл



Өндөр: 3 метр орчим

Урт: 6 – 7.5 метр

2

Он, сар, өдрийг үгээр илэрхийлж бичээрэй.

2021 оны 6 дугаар сарын 20-ы өдөр



В. Үгсийг зөв дараалалд оруулж, өгүүлбэр бүтээгээрэй.

### Амьтад устаж байгаа шалтгаанаас:

- хэмжээгээр, Ой, устгаснаас, модыг, их
- өөрчлөлтөөс, Цаг, уурын
- буруу, Хулгайн, үйлдлээс, анчдын
- цуурхлаас, өвчинд, сайн гэсэн, Амьтдын, зарим нэг, эд эрхтэн
- хувцас, Амьтны үс, хийдгээс, чимэглэл, ясаар
- бохирдолт, Усны, ихэссэнээс
- болсноос, аргаар, загас, Хориотой, агнах

## VIII БҮЛЭГ. ЭХ ДЭЛХИЙ

### ДАСГАЛ 1



А. Харилцан ярианы дүрийг сонгож, харилцан уншаарай. Бусдадаа ойлгогдохоор, үгээ тод хэлж уншаарай.



- Сайн байцгаана уу? Хүүхдүүд ээ, намайг таньж байна уу? Миний нэр Болат. Өнөөдөр бүгдээрээ “Байгалиа хамгаалах” тухай ярилцъя.

Даулет: -Сайн, сайн байна уу? Тантай уулзсандаа баяртай байна. Энэ миний найзууд Асхар, Арман, Асем



Асем - Гадуур найзуудтайгаа явж байхад гудамжинд хог хаядаг хүүхдүүдтэй зөндөө тааралддаг шүү.

Асхар: -Гэр бүлээрээ зугаалганд явж байхдаа голын усанд хивс, машин угаадаг хүмүүстэй их тааралдсан. Энэ нь усанд амьдардаг олон төрлийн амьтдыг хордуулж байгаа гэсэн үг биз дээ!



Арман: - Гэхдээ байгалиа бохирдуулдаггүй хүмүүс ч байдаг. Бид зугаалгаар буусан газраа маш сайн цэвэрлээд, хогоо уутанд хийж, хогийн цэг дээр хаядаг.

Болат: - Тийм ээ. Эх дэлхийгээ хайрлан хамгаалах нь хүн бүрийн үүрэг гэдэг. Гэхдээ яг яаж хамгаалах ёстой гэж чи боддог вэ?



Асхар: - Чиний хэлдэг зөв зөв. Бид эхлээд мод тарьж, усаа хэмнэж, хог хаяхгүй байхыг бусдадаа уриалах хэрэгтэй.

Даулет - Маш зөв санаа байна шүү! Тэгвэл яг одоо эхэлье. Хэлдэггүй, ярьдаггүй ч эх дэлхий минь бидэнд гомддог л байх даа. Байгаль дэлхий маань бохирдоход хэн буруутай гэж та нар бодож байна вэ?



Асем - Миний бодлоор эх дэлхийгээ мөхөлд хүргэж байгаа гол буруутан нь хүн, аварч чадах нь ч бас хүн та өөрөө шүү.

Болат: - За бүгдээрээ байгалиа хамгаалах талаар уриалгаа бичицгээе. Баярлалаа. Сайхан ярилцлаа.



1 Өмнөх харилцан ярианы талаар ярилцъя. Цэгийн оронд өөрийн санаа бодлоо бичээрэй.

- Харилцан яриаг уншихад ....., ..... надад (баярлах, гомдох, жигших) сэтгэгдлүүд төрж байна. Учир нь .....
- Харилцан ярианаас би .....ойлголоо.
- Харилцан яриаг уншихад .....хиймээр санагдаж байна.



Б. Дараах өгүүлбэр тус бүрийн гол санааг сайтар бодоорой. Өгүүлбэр бүрийн санааг жишээгээр дэлгэрүүлж яриарай.

Миний бодлоор, Эх дэлхийгээ мөхөлд хүргэж байгаа гол буруутан нь хүн.



Хэлдэггүй, ярьдаггүй ч эх дэлхий минь бидэнд гомддог л байх даа.

Эх дэлхийгээ аварч чадах нь ч бас хүн та өөрөө шүү.



Өгүүлбэрийг хурааж бичье.



Үгийн утгыг мэдье:

**хураангуй** - дэлгэрэнгүй биш, товч, бага болгосон нь  
“Монгол хэлний хураангуй тайлбар толь”-оос

□ Хураангуй өгүүлбэр гэж ямар өгүүлбэр вэ?

үйлийн эзэн

+

үйл хөдлөл

=

хураангуй өгүүлбэр

Жишээ нь: **Хүүхдүүд** гудамжинд, сургууль дээрээ зөндөө хог **хаядаг**.



**Хүүхдүүд хаядаг.** (хураангуй өгүүлбэр)



В. Өгүүлбэрүүдийг хурааж бичээрэй.

- Хүмүүс голын усанд хивс, машин, хувцсаа угаадаг.
- Зарим хүмүүс байгалиа хамгаалдаг.
- Бид орчиндоо хогоо хэзээ ч хаядаггүй.
- Бид аялаад буусан газраа маш сайн цэвэрлэдэг.
- Бид хогоо хогийн цэг дээр хаядаг.
- Хүмүүс эх дэлхийгээ мөхөлд хүргэж байна.



Г. Харилцан яриаг алдаагүй, цэвэрхэн хуулж бичихдээ зохих цэг тэмдгийг тавиарай.

- Цэцэг... Сайн байна уу...  
Хуванцрыг бага хэрэглэхийн тулд яах ёстой вэ...

- Бат... Сайн... Сайн байна уу...  
Дэлгүүрээс юм авахдаа гялгар уутан тор авахгүй гэрээсээ даавуун тороо авч гарах хэрэгтэй...



- Цэцэг... Нээрээ тийм байна шүү ... Баярлалаа.

- Бат... Байгаль дэлхий...газар нутгаа хамгаалахын тулд хог бүү хаяарай.



Д. "Эх дэлхийгээ мөхөлд хүргэж байгаа нь хүн та өөрөө" гэсэн сэдвээр богино эх зохиож бичээрэй.

- Эхлээд юу бичих вэ?, Дараа нь юу бичих вэ?, Төгсгөлд нь юу бичих вэ? гэсэн төлөвлөлт гаргаарай.
- Зөв бичих дүрмийн алдаагаа хянаарай.
- Графикийн мэдээллийг бичгээр илэрхийлээд, эх зохиохдоо баримтаар ашиглаарай. Жишээ нь: Дэлхийн нэг өдрийн хог хаягдлын 30%-ийг гялгар уут эзэлдэг байна.



### Үгийн утгыг мэдье

**мөхөл** – сүйрсэн, сөнөсөн байдал

**хаягдал** – хэрэггүй гэж үзэн хаясан юм

**задрах** – бутрах

“Монгол хэлний хураангуй тайлбар толь”-оос



А. Усаа хэрхэн хэмнэх тухай төлөвлөлтийг анхааралтай уншаарай.

1

Өгүүлбэр тус бүрийг хураангуй өгүүлбэр болгоорой.

УСАА ХЭМНЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ



Би гараа, шүдээ  
угаахдаа усаа  
заавал хааж  
байна.

Би шилэн аягатай  
усаар шүдээ угааж  
хэвшинэ.



Би ус тосолгүй шүршүүрт  
богино хугацаанд орж  
хэвшинэ.

Би биеэ савандаж байхдаа  
усаа хаана.



Би гараа  
савандаж  
байхдаа усаа  
хаана.

Би үсээ  
савандаж  
байхдаа усаа  
хаана.



Би суултуурын  
ус бага  
гардаг жижиг  
товчлуурыг дарж  
хэвшинэ.

Би ариун  
цэврийн цаас,  
амны цаас зэрэг  
хог хаягдлыг  
суултуурт биш,  
хогийн саванд  
хаяж хэвшинэ.



Би хувцсаа  
угаахдаа  
усаа түмпэнд  
тосож, угааж  
хэвшинэ.

Би хувцсаа  
мушгихдаа  
усаа хааж  
сурна.



Б. Хурдан, ойлгож уншъя. Минутын уншлага хийгээд, өөрийгөө үнэлээрэй.

### Ерөнхийлөгчид хүргэх миний үг



Сайн байна уу? Эрхэм хүндэт ерөнхийлөгч өө!  
Танд захидал очих өдрийн мэнд хүргэе. Та их ажлын хажуугаар миний захидлыг зав гарган уншиж байгаад би маш их баяртай байна. Энэхүү захидлаараа орчиндоо хог хаяхгүй байх тухай бодож бичлээ.

Өглөө эрт босож сургууль руугаа алхаж явахад гудамжинд хог зөндөө байдаг нь их муухай байдаг. Хогоо машиныхаа цонхоор хаяж байгаа томчууд маш

муухай харагддаг.

Би ахлах ангийн ах эгч нараасаа сургуулиа цэвэрхэн, тав тухтай байлгах талаар суралцдаг. Тэд “Их завсарлагаанаар сургуулийнхаа орчмын хогийг түүж, хогийн саванд хийж байя” уриалга гаргасан. Үүнээс хойш хүүхдүүд хог хаядаггүй болсон. Тиймээс манай сургууль “Хүүхдэд ээлтэй эко сургууль” болсон.

Миний төрсөн нутгийн хөрсөн дээр энд тэндгүй хог хийсэж байхыг би хүсэхгүй байна. Тиймээс “Хог бүү хаяарай” гэж ерөнхийлөгч тантай хамт уриалга гаргахыг хүсэж байна.

Таныг хүндэтгэсэн: 4б ангийн сурагч Ц.Болормаа.

Өөрийгөө үнэлээрэй:

1 минутад уншсан үгийн тоо

Амандаа үглэж уншсан уу?

Нүдээрээ гүйлгэн уншсан уу?

1 Хүснэгтийн дагуу дэвтэртээ бичээрэй.

үйл хөдлөл	шалтгаан нь
...гудамж их муухай байдаг.	
...томчууд маш муухай харагддаг.	
“Хүүхдэд ээлтэй эко сургууль” болсон.	
... уриалга гаргахыг хүсэж байна.	



В. Найз нөхдөдөө хандан, товч уриалга бичээрэй.

#### Хэнд хандах вэ?

- ерөнхийлөгчид
- сумын удирдлагад
- сургуулийн удирдлага, багшид
- найз нөхдөдөө

#### Юунд уриалах вэ?


- хог хаяхгүй байх
- усаа хэмнэх
- гялгар уут хэрэглэхгүй байх
- мод тарих



Г. “Эх дэлхийгээ аврахын тулд бид юу хийх хэрэгтэй вэ?” гэсэн санааг илэрхийлж, зураг бүрээр 2, 2 өгүүлбэр бичээрэй. Өгүүлбэрээ “-я, -е, -ё” нөхцөлөөр төгсгөөрэй.

- Бичихийн өмнө эргэцүүлээрэй.

Би амьдарч байгаа нутаг орон, газар усныхаа төлөө бодитой юуг хийж чадах вэ? Юуг төлөвлөж, хэрэгжүүлж чадах вэ?



Д. Зөв бичих дүрмийн алдаатай үгийг олж, алдааг засаж, дүрмийг тайлбарлаарай.

- Уриалах: Дэвтэрийн цаасаа бүрэн ашиглах талаар нөхдөдөө зөвлөө.
- Алхах: Байгалийн сайханд найз нартайгаа алхья.
- Ажиглах: Гэрээсээ сургууль хүртэл замдаа байгалиа ажиглая.
- Бичих: Эх хэлнийхээ хичээлээр гадаа сууж, орчиноо ажиглаж бичье.
- Ярилцах: Нутаг усныхаа сайхан зүйлсын тухай ярилцая.
- Гүйх: Шиврээ намуун бороотой өдөр бороонд гүйе.
- Сонсох: Шувууны жиргээг сонсоё.
- Харах: Өглөө эрт гэрийнхэнтэйгээ нар мандахыг харъя.

1 Дараах үгсэд "-ийг, -ыг" тохирохыг залгаарай. Балархай эгшиг "Гээгдэх, гээгдэхгүй" байгаа тохиолдлыг ярилцаарай.

хөшиг	хогшил	тогших
бичих	мөчир	хөгжим
хожил	хужир	ачих
учир	уужим	Должин



Монгол хэлний “Төгсгөх нөхцөл”-ийг уншаарай. Яагаад “Төгсгөх нөхцөл” гэсэн учрыг жишээ өгүүлбэрээс харж ярилцаарай.

Бие	Нөхцөл	Жишээ
I бие	-я, -е, -ё	Түүнтэй явъя.
	- сугай - сүгэй	Хөлсийг олгосугай.
II бие	0	Эндээс яв.
	- аарай <sup>4</sup>	Хамт хийгээрэй.
	- аач <sup>4</sup>	Дүүдээ өгөөч.
	- гтун - гтүн	Хөлсийг олгогтун.
	- уузай - үүзэй	Ажлаа мартуузай.
III бие	- г	Хамт хийг.
	- тугай - түгэй	Мандтугай.
	- аасай <sup>4</sup>	Зун болоосой.



Е. Эдгээр нөхцөлийн утгаас “Захирсан, шаардсан, зөвлөсөн” зэрэг тухайн өгүүлэгчийн сэтгэлийн өнгө аяс илэрч байгааг уншиж ойлгоорой. Дараах өгүүлбэрүүдийн тодруулсан нөхцөлийн утгыг тайлбарлаж яриарай.

- Би энэ ажлаа хугацаанд нь хийж дуусга**я**.
- Чи цагаа сайн бари**ач**. Хоцорчихлоо.
- Морь нь хурдан байж айраг түрүү ава**асай**.
- Дурдсан хугацаанд хийж дуусахыг үүрэг болгосугай.
- Ангидаа хурдан ир**эгтүн**.
- Монгол орны гал голомт үеийн үед бадартугай.
- Нөхрөө хараад биеэ заса**арай**.
- Сүүдрээ харж бүсээ заса**арай**.
- Гэрээ засаад төрөө зас.
- Санасан хэрэг нь сэтгэлчлэн бүтэг.
- Чи ангийн жижүүр хийхээ мартуузай.

**Дорлиг:** -Та нар гараан дээр дахин очиг**тун**. Анхаарч байгаарай. Марш, зогс, дахиад гараан дээрээ очоод миний хэлэхийг **сонс**.

**Бат:** -Түргэлээч дээ. Чамаас гуй**я**, Энэ ажлаа хурдан дуусга**я**.

**Дорлиг:** -Чи яасан тэсвэр муутай эр вэ? Дулмаа хүлээж л бай**г**. Хүлээх гэж ямар байдгийг тэр мэдэж ава**г**.

**Бат:** -За за, чиний санаснаар болтугай. Чамд ямар өрөвдөх сэтгэл байх биш дээ.

**Дорлиг:** -Чи тайвшра**ач**. Дасгал одоохон дууслаа шүү дээ.



А. Шүлгээ яаж унших тухай ярилцаад, уншаарай.

- ❑ Үг бүрийн утгыг тунгааж, унших хурд, биеийн хөдөлгөөн, нүүрний хувирал, нүдний харц, дууны өнгөө тохируулж, дохио зангаа хэрэглээрэй.
- ❑ Шүлгээс юу сонсогдож, юу төсөөлөгдөж байгааг мэдэрч уншаарай.

**Гоёхон дэлхий**

Алтан нарны цацраг

Алаг цэцэгсийг минь илбэн байна

Амгалан цэнгэг нуурандаа

Аяны шувууд нь тухлан байна.

Аглаг ногоон ойдоо

Ан амьтан нь хөөцөлдөн байна.

Агаар цэнгэг дэлхийдээ

Хүүхэд бид дуулж байна.

Урсгал тунгалаг ус минь

Үүрд мөнх цэнгэг байг.

Ургах ногоон модод нь

Үүрд мөнх ногоорон байг.

Үүлтэй цэнхэр тэнгэр минь

Үеийн үед цэлмэг байг.

Үзэсгэлэнт гоёхон дэлхий

Үрийн үрд амгалан байг.

Найган ургах ногоон моддыг

Хугалж болохгүйг би мэднэ.

Намиран урсах цэнгэг голыг

Хиртээж болохгүйг бид мэднэ.

Эгдүү хүргэм хөөрхөн амьтдыг

Үргээж болохгүйг би мэднэ.

Эргэх цэнхэр дэлхийгээ

Хамгаалж хайрлахаа бид мэднэ.

Цэнхэр нүдэн дэлхийгээ хайраа түгээж хайрлаарай.

Цэлгэр уудам дэлхийдээ хайраа түгээж дуулаарай.

1

Шүлгийн өгүүлбэр бүрийг хурааж бичээрэй.

Шувууд тухлан байна.

Хүүхэд бид дуулж байна.

Модод нь ногоорон байг.

Дэлхий амгалан байг.

Бид мэднэ.

(Д.Батзориг)



**Үгийн утгыг мэдье**

**илбэх** - илбэн таалах

**амгалан** - сэтгэл санаа төвшин, тайван

**цэнгэг** - тунгалаг, цэвэр сайхан

**тухлах** - тав тухтай, аажуу уужуу хандах

**аглаг** - хүний хөл, хөдөлгөөнөөс зайдуу

**намирах** - салхины аясаар хийсэх

**эгдүү хүрэх** - Нялх хүүхэд, амьтны зулзагыг хараад эгдүү хүрэх

**гараа сунгах** - туслах

**гандаж гундах** - ургамал хатах, ургамлын өнгө шарлаж

“Монгол хэлний хураангуй тайлбар толь”-оос



Б. Зохиогч эх дэлхийгээ бодож бичихдээ ямар ямар үг хэрэглэснийг ажиглаарай.

1 Яагаад ингэж бичсэн юм бол? Миний бодлоор бол ..... гэж яриарай.



Хамгаалж хайрлахаа бид мэднэ.  
Хайраа түгээж хайрлаарай.  
Хайраа түгээж дуулаарай.




В. Юуг юутай ямар учраас адилтгасан бэ? Адил тал нь юу байсан бол? Ярилц.




“Алтан нарны цацраг”

Яагаад нарыг алттай адилтгасан юм бол?



“Алаг цэцэгсийг минь илбэн байна”

Илбэх, илэх нь хүний хийдэг үйл.  
“Нар цэцэг илбэнэ” гэхээр нарыг хүн болгосон байна уу?



“Цэнхэр нүдэн дэлхийгээ ...”

Дэлхийг яагаад нүдтэй адилтгасан юм бол? Хэлбэрийг нь, өнгийг нь хараарай.



Г. Шүлгийнхээ дүрслэлийг сайтар төсөөлж бодоод, шүлгээ цээжлээрэй. Цээжилснээ уран уншаарай.



А. Үлгэрийг анхааралтай уншиж ойлгоод, үлгэрийн гол хэсгийг үргэлжлүүлэн ярилцаарай.



Тэнүүн сайхан тал нутагт нэгэн мэргэн өвгөн мал маллаж, ан гөрөө хийж, амар тайван амьдарч байжээ.

Мэргэн өвгөн нэг өдөр нутаг усаа хараад, бодолд автан сууж байгаад гэнэт зүүрмэглэжээ.

Хувцсандаа энэ дэлхийн бүх амьтан, ургамлыг хатгасан нэгэн үзэсгэлэнтэй эмэгтэй түүн рүү ойртож ирээд хажууд нь суув.

- Амар байна уу? Өвгөн гуай!

- Амгалан байна аа. Таныг хэн гэдэг вэ?

- Би дэлхий ээж байна.

- Та нутаг орноо хайрладаг уу? Таны нутаг үзэсгэлэнтэй хэвээрээ юү? гэж дэлхий ээж асуув.

- Нутаг орон маань миний бага байх үеэс

улам муухай болоод байгаа гэж өвгөн сэтгэл зовж хэлэв.

- Би маш их гайхаж байна. Би та бүхэнд мал сүрэг, ан гөрөөс, олон зүйлийн шувуу, тал хээр, ой мод гээд бүгдийг бүтээж өгсөн. Одоо та нар ямар болгосныг би харуулъя гэв.

Тэгтэл өвгөний нүдэнд ..... юу харагдсан бэ? Үлгэрийн гол хэсгийг үргэлжлүүлж бичээрэй.

1 Бичихийн тулд анхаараарай. Эхлэл, гол, төгсгөл хэсгийн уялдаа холбоог сайн бодоорой.

Эхлээд юу болсон бэ? Дахин уншаарай.

Дараа нь юу болсон бэ? Сайн бодоорой.

Төгсгөлд нь юу болсон бэ? Дахин уншаарай.

Хэзээ ч, юунаас ч айж байгаагүй өвгөн энэ удаа үнэхээр айлаа.

Дэлхий ээж: Та нүдээ аниад, хараарай гэв.

Өвгөн нүдээ нээвэл: Тал нутаг цэлийж, тунгалаг уст горхи урсаж, мал сүрэг бэлчин, хүүхдүүд ус үсчүүлэн наадна. Тэнгэрт болжмор жиргэнэ.

Өвгөн асгартал уйлж: “Дэлхий ээж минь таныгаа бид дахин гомдоохгүй, бид эх дэлхийгээ хайрлана” гэж хэлэв.

1 Эхээс юуг ойлгож авсан бэ? Ярилцаарай.

Бид нутаг орноо хайрлаж байна уу?

Бид юу хийх ёстой вэ?

2 Эхийг уншаад, төрсөн сэтгэгдлээ хуваалцаарай.

Сэтгэгдлээ илэрхийлэхдээ:

Сэтгэгдлээ илэрхийлж ярьж бичихдээ баярласнаа догдолсноо, гомдсоноо, өрөвдсөнөө, жигшсэнээ, бахархсанаа, уйлснаа, инээснээ, уулга алдсанаа, гайхсанаа ... гэх мэт олон өнгө аясаар илэрхийлээрэй. Ингэхдээ ямар үг хэллэг, ямар дүр, ямар үйл явдлаас болж байгаагаа тодруулж, жишээ татаарай.



Б. Өвгөний үйл хөдлөл түүний шалтгааныг ярилцаад, бичээрэй.

Өвгөний үйл хөдлөл	Шалтгааныг бичээрэй
Хэзээ ч, юунаас ч айж байгаагүй өвгөн энэ удаа үнэхээр айлаа.	
Өвгөн асгартал уйлж...	

Яагаад?  
Ямар учраас  
Яах гэж?  
Учир юу вэ?



В. “Дэлхий ээж минь таныгаа бид дахин гомдоохгүй, бид эх дэлхийгээ хайрлана” гэсэн өвгөний хэлснийг биелүүлэхийн тулд та бүхэн юу амлаж чадах вэ?

Өөрийнхөө амлалтыг бичээрэй.

Миний бие .....  
овогтой .....  
амлаж байна.  
1 .....  
2 .....  
3 .....  
4 .....  
5 .....

Найзынхаа амлалтыг уншаарай.

Хэт хэрэглээг багасгах

Явган явах

Усыг хэмнэх

Мод тарих

Хогийг багасгах

Эрчим хүчийг хэмнэх

## ДАСГАЛ 5



А. “Монгол орныг цөлжилтийн аюул нөмөрлөө” сэдвээр мэдээ бэлдээд яриарай. Дараах мэдээллийг ашиглаарай. Өөрсдөө нэмж болно. Гарчиг өгөөрэй.



Хэн?, Юу?,  
Хаана?,  
Хэзээ?, Яагаад?  
Юу болов?

Цөлжих шалтгаан:

- Ой модоо устгаад байвал
- Гол горхио бохирдуулаад байвал
- Нуур голоо ширгээгээд байвал
- Ой модоо огтлоод байвал
- Ой модоо шатаагаад байвал


Ургамал цөөрнө.  
Элсээр хучигдана.  
Нуур, гол горхи ширгэнэ.

Нэгдсэн үндэсний байгууллага 1995 онд "Цөлжилттэй тэмцэх дэлхийн өдөр"-ийг жил бүрийн 6 дугаар сарын 17-нд тэмдэглэж байхаар зарласан юм.

### ЦӨЛЖИЛТ - МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРТ

### Юу болсон бэ?

● Нэн хүчтэй	9.9
● Хүчтэй	6.7
● Дунд зэрэг	25.9
● Сул	35.3
● Цөлжилт илрээгүй	15.1
● Бусад	10.2



Бичсэн мэдээгээ шалгах өөрийн үнэлгээний асуулт:

- Бичсэн мэдээ нь уншихад ойлгомжтой байна уу?
- Ямар нэгэн үг, өгүүлбэр хасмаар байна уу?
- Ямар нэгэн үг, өгүүлбэр нэммээр байна уу?
- Үгийн байрлалыг солимоор байна уу?
- Үгийг солимоор байна уу?
- Бичсэнээ дахин сайжруулаарай.
- Зөв бичих дүрмийн алдаагаа хянаарай.

# IX БҮЛЭГ. ХАРИЛЦААНЫ СОЁЛ

## ДАСГАЛ 1



А. Эхээс зохиогчийн үгийг хасаж, дүрээ хуваарилж, харилцан уншаарай.

- Дууныхаа өнгийг дүрдээ тохируулан өндөр, нам болгоно.
- Нүүрний хувирал, нүдний харц, хөдөлгөөнөө тохируулна.

### Зараахан

Нэгэн өдөр жижигхэн бөөдий ээжээсээ:

“-Би ямар хүү вэ? Сайн уу? Эсвэл муу юу?” гэж асуув.

Ээж нь:

-Миний хүү чинь уг нь тусч хүү дээ. Чи найзуудаасаа бас асууж болно шүү дээ! гэлээ. Мэлхийнээс асуулаа:

-Чи тун сайн зараа. Чи намайг “Вааг вааг” дуугаа дуулахад дэмжиж алгаа ташиж байсан шүү гэв. Үнэгнээс асуулаа:

-Чиний өргөс намайг хатгасан шүү гэлээ. Шоргоолж:

-Үнэгэнд битгий итгэ. Зараахан чи нөхөрсөг шүү.

Намайг нуруун дээрээ суулган гол гаргаж өгсөн гэлээ.

Хэдгэнэ:


-Намайг цэцэгнээс сэгсрэн гаргаж тус болсон гэлээ.

Галууны дэгдээхий:

-Зараахан бол тусч найз. Намайг ногоон дотор төөрчихсөн байхад ус руу оруулж өгч тусалсан гэв. Туулайн бөжин:

-Чи над руу сэмхэнээр ойртож байсан үнэгийг хөөж тусалсан гэхэд ээж нь:

-Чиний найзууд бүгд үнэнийг хэллээ. Хэн нэгнийг гомдоож болохгүй. Харин тэднийг баярлуулж тус болж яваарай гэж захилаа.



1

Үлгэрийн баатрыг “зараа” биш, “зараахан” гэж нэрлэсэн учрыг юу гэж бодож байна вэ? Санаа бодлоо хэлээрэй.

2

Зараахан юу хийсэн учраас түүнийг юу гэж дүгнэсэн бэ? Бичээрэй.

үйл хөдлөл	дүгнэлт
Дуугаа дуулахад дэмжиж алгаа ташиж байсан шүү.	Чи тун сайн зараа.

3

Дотны найзынхаа хийсэн 2 үйлдлийг бичиж, тэр үйлдлээс нь найзыгаа дүгнэж бичээрэй.



Б. Үгсийг өгсөн нөхцөлөөр хувилгаж бичээд, дүрмийг ярилцаарай.

99

79

79

• дэм**ж**дэг + -ийг, -ээс, нөхөр**с**өг + -ийг, -өөс, баярлуул**д**аг + -ийг, -аас




В. “БИ ЯМАР ХҮҮ (ОХИН) ВЭ? Ярилцъя.

- “Би ямар хүү / охин бэ? Яагаад вэ?” гэсэн асуултыг ойр дотны хүмүүс, найз нөхөд, багшаасаа асуугаад, чин сэтгэлийн яриа өрнүүлээрэй.



Өндөр настанд тусалдаг.  
Өргөсөн юмыг нь дамжилдаг.  
Миний хүү тусч хүү.

Би ямар хүү вэ?  
Яагаад вэ?



Би ямар охин бэ?  
Яагаад вэ?



Жишээ үгс: (Үнэнч, тусархаг, зоригтой, шударга, эелдэг, нөхөрсөг...)



Үйл үгийн "Холбох нөхцөл"-ийг уншиж, тогтоож аваарай.

Тодотгон холбох нөхцөл

Нөхцөл	Жишээ
-даг <sup>4</sup>	алх <b>д</b> аг, хар <b>д</b> аг
-аа <sup>4</sup>	алх <b>а</b> агүй, хар <b>а</b> агүй
-сан <sup>4</sup>	алх <b>с</b> ан, хар <b>с</b> ан
-х	алх <b>а</b> х, хар <b>а</b> х
-маар <sup>4</sup>	алх <b>м</b> аар, хар <b>м</b> аар

Жишээ нь:

“Вааг вааг” дуугаа дуула**х**  
алгаа ташиж бай**сан** шүү  
өргөс намайг хатга**сан** шүү  
гэлээ.

гол гаргаж өг**сөн** гэлээ.

ногоон дотор төөрчих**сөн**  
байхад...

Чи над руу сэмхэнээр ойртож  
бай**сан** үнэгийг хөөж тусал**сан**.

## ДАСГАЛ 2



А. Эхийг зөв, хурдан, ойлгож уншъя. Минутын уншлага хийгээд, өөрийгөө үнэлээрэй.



### Би үүнийг өөрчлөхийг хүсэж байна.

Намайг Хүслэн гэдэг. Би 13 настай. Гэрийнхэн маань надад гар утас авч өгснөөс хойш би цахим ертөнцийн байнгын хэрэглэгч болов. Утас бариад удаан суудгаас шалтгаалж: “Утсаа боль” гэдэг үг надад ядаргаатай санагдаж уурлах, бухимдах, дургүйцэх, гомдох болж, манай гэр бүлд маргаан ч үүсэх болов. Сүүлдээ бүр миний нялх дүү хүртэл утсанд дурлаж, нэхэж уйлах боллоо. Цахим орчинд цагаа их өнгөрүүлснээс гэр бүлийн гишүүд бие биедээ анхаарал хандуулах, нэгийгээ халамжлах, сонсох, ярилцах зэрэг халуун дулаан, амьд харилцаа дутах болов.

Одоо л энэ асуудлыг шийдэхгүй бол бидний харилцаа улам хүндрэхийг би ойлгосон. Иймээс үүнийг өөрчлөхийн тулд хувийн төлөвлөгөө гаргав. Би юуг өөрчлөх вэ? Юуны өмнө “Утсаар тоглодог, юм үздэг цагаа багасгах”. Үүний тулд:

“Сард 1 сонирхолтой ном заавал унших”, “Жилийн турш дуртай спортоороо хичээллэх”, “Гэр бүлийнхэнтэйгээ өдөр бүр ярилцах цаг гаргах, тэдэндээ туслах” зэргийг төлөвлөж байна аа.

Ганц би ч биш, чамд ийм асуудал тулгарч байвал утасны хэрэглээг багасгах өөрийн төлөвлөгөө зохиож, мөрдөөрэй. Амжилт хүсье.

Уншсан үгийн тоо



### Үгийн утгыг мэдье

**бухимдах** - бачуурах, уур хүрч бачимдах

**дургүйцэх** - дургүй хүрэх, татгалзах

**халамжлах** - асрах, хайрлах, анхаарал тавих

**цухалдах** - уурлаж хилэгнэх

*"Монгол хэлний хураангуй тайлбар толь"-оос*

1 Ямар учраас төлөвлөгөө гаргах болсон бэ? Хүснэгтийн дагуу тайлбарлаж яриарай.

Утас авч өгснөөс хойш

Утас бариад удаан суудгаас

ядаргаатай санагдаж уурлах, бухимдах, дургүйцэх, гомдох болж, маргаан ч үүсэх нэхэж уйлах

Бие биедээ анхаарал хандуулах, нэгийгээ халамжлах, сонсох, ярилцах зэрэг халуун дулаан, амьд харилцаа дутах болов.

Өөрчлөхийн тулд хувийн төлөвлөгөө гаргав.



## Б. Өгүүлбэр зохиоё.

- 1 Хүслэн төлөвлөгөөгөө биелүүлээд, утсаар ярихаа боливол "Гэр бүлийн уур амьсгал" ямар болохыг өгүүлбэрээр илэрхийлж бичээрэй.

Халуун дулаан, амьд харилцаа дутах болов.



Бидний харилцаа улам хүндрэхийг би ойлгосон.



- 2 Өнгөөр ялгасан үгийн эсрэг утгатай үгсийг бичээрэй.

"Утсаа боль" гэж хэлэхэд **ядаргаатай** санагдаж **уурлах, бухимдах, дургүйцэх, гомдох, ... маргаан ч үүсэх ....**

ядаргаатай, уурлах, бухимдах, дургүйцэх, гомдох, ... маргаан ч үүсэх



Инээх, тайвшрах  
.....

Бичсэн үгсээс гурвыг сонгон, өгүүлбэр зохиож бичээрэй.

.....



## В. Ном унших төлөвлөгөөг уншаад, үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацааг бичээрэй.

- ...Иймээс үүнийг өөрчлөхийн тулд хувийн төлөвлөгөө гаргав. Би юуг өөрчлөх вэ? Үүний тулд: "Сард 1 сонирхолтой ном заавал унших"

Юу хийх вэ?	өдөр бүр	7 хоногт	сар
Ханын цаасан дээр уншсан, унших, худалдан авах номын жагсаалт гаргана.			
"Сар бүр нэг ном уншина." Ойролцоогоор сард 300 хуудастай ном уншина. Тиймээс өдөр бүр 10 хуудас уншина.			
Өглөөний 20-30 минутыг уншихад зарцуулж хэвшинэ.			
Гол гол санаануудыг номон дээрээ тэмдэглэж, тодруулж уншина.			
Номыг цахимаар сонсоно.			
Таалагдсан эшлэлүүд зэрэг номын талаар тэмдэглэл хөтөлнө.			
Ном уншдаг хүүхдүүдтэй уулзалт зохион байгуулна.			



### Г. Өдрийн тэмдэглэлийг анхааралтай уншаарай.



Өдрийн тэмдэглэлээс:

Хүний яриаг сонсох чадвар минь үнэндээ сул юм. Найз нарынхаа яриаг дуусаагүй байхад тасална. Цухалдана. Уурлана. Зэрэгцэж ярина. Яриаг тасалж, тайлбар тавина. Энэ бол харилцааны маш бүдүүлэг алдаа гэдгийг би мэдэж авсан. Тиймээс энэ байдлаа өөрчлөхгүй бол найз нөхөдгүй болохоо ч ойлгосон. Яаж би үүнийгээ засаж, өөрчлөх вэ? гэж л бодох юм.  
Сүрэн 2014.05.24

1 Багаараа ярилцаад, товч төлөвлөлт гаргаарай.

Асуудал: Хүний яриаг сонсох чадвар минь үнэндээ сул юм.	Яаж би үүнийгээ засаж, өөрчлөх вэ? Би юу хийх вэ?
Яриаг тасална. Цухалдана. Уурлана. Зэрэгцэж ярина. Яриаг тасалж, тайлбар тавина. Энэ бол харилцааны маш бүдүүлэг алдаа.	

2 Зураг бүрийн санааг илэрхийлсэн өгүүлбэр зохиож бичээрэй.



3 “Хувийн төлөвлөгөө”, “Өдрийн тэмдэглэл” хоёрыг харьцуулан ярилцъя.

- ✓ Хүслэнгийн “Хувийн төлөвлөгөө”, Сүрэнгийн “Өдрийн тэмдэглэл” хоёрын ялгаатай тал нь юу байна вэ?
- ✓ Тэгвэл адил тал нь юу байна вэ?
- ✓ Хувийн төлөвлөлтөд өөрийгөө өөрчлөхийн тулд хийх зүйл, түүнийг хэрэгжүүлэх хугацааг бичжээ. Тэгвэл өдрийн тэмдэглэлдээ өөрийнхөө юуг, яагаад, яаж өөрчлөх вэ? гэдгээ бичиж болох уу? Юу гэж бодож байна вэ?
- ✓ Харин хувийн төлөвлөлтөд өдрийн тэмдэглэлдээ бичдэг шигээ сэтгэгдэл, санаа бодлоо бичиж болох уу? Юу гэж бодож байна вэ?



Д. Зөв бичих дүрмээ эргэн саная. Өгүүлбэрүүдийг уншаад, үйлийн төгсгөх ба холбох нөхцөлүүдээс сонгон нөхөөрэй.

Саран гий (...) сайхан шөнө боловч хад байцын ёроолд бараан сүүдэр тунар(...). Янгирын хөлөөр чулуу өнхөр(...) нь дуулдаж, үргэж цоч(...) шувуухайнууд дуу шуу болон далавчаа сүржигнүүл(...). Дээшээ хар(...)ад уулсын оройгоор тусгаарлагд(...) одот цэлмэг тэнгэр ерөнхий дүрсээрээ адил биш боловч олон өнцөгтийг санагдуул(...). Гэнэт холгүйхэн ханиа(...) чимээ гар(...)ад дотор нь арзасхийгээд явчих(...). “Хэтэрхий айвал байхгүй юм харагдаж, дуугараагүй юм сонсогд(...) тухай багшийнхаа ярь(...)ийг санаж өөрийгөө тайвшруул(...).



- Төгсгөх нөхцөл: -жээ, -чээ, -в, -лаа<sup>4</sup>, -на<sup>4</sup>
- Холбох нөхцөл: -даг<sup>4</sup>, -х, -сан<sup>4</sup>, -маар<sup>4</sup>, -аа<sup>4</sup>

1 Балархай эгшгийг нөхөж бичээд ямар үүрэгтэйг нь хэлээрэй.

### Танихад амархан

Эрт цагт баяны хүү, барл...гийн хүү хоёр ном заалг...хаар болж мэрг...н хүнд очжээ. “Маргааш өглөө намайг ирэхэд энэ гэрийг дүүрг...х юм бэлтгээд байцгаа. Энэ гэрийг дүүргэж чадс...н хүнд л эрд...м номыг харамгүй заах болно” гэжээ.

Баяны хүү гэрийг дүүрг...х гэж өр...м бясл...г, ааруул, мах, амтт...н, авчирс...н байжээ. Барл...гийн хүү бага зэр...г арг...л авчирс...н байж гэнэ. Энэ хоёр хүүгийн хэнд нь ном заах бол.

2 Гээгдэхгүй эгшгийн дүрмээр зөв бичсэн үгийг олж сонгоорой.

Дүрэм	1	2	3	4
Оноосон нэрийн эгшгийг гээхгүй.	бодсоноос	нугасаар	Дарханаас	дархнаас
Эгшигт гийгүүлэгч эгшиггүйдэхэд хүрвэл	самбарын	гурилаар	явахыг	хүчдэлийг
Заримдаг гийгүүлэгч эгшиггүйдэхэд хүрвэл	Дорнодын	хоногийг	салбараар	нөхцөлийн
Тодотгон холбох “-х”-ийн өмнөх эгшгийг гээхгүй.	хавхыг	цонхоор	бодохыг	тархиар
Ялгах эгшгийг гээхгүй.	салхиар	нутагаар	үнэрээс	алдарын
“-ж, -ч, -ш”-ээс бусад гийгүүлэгчийн дараа орсон “-и” гээхгүй.	тамирын	ашигийг	эрчимээс	харшилын



А. Үлгэрийг асуултын дагуу анхаарч уншаарай.

### Эвсэг айл

(Солонгос ардын үлгэр)

#### Эхлэл хэсэг:

Хэний, юуны тухай өгүүлэхийг танилцуулсан хэсэг

#### Үлгэрт хэний тухай өгүүлэх бол?

Эрт цагт нэг гол усанд нутагладаг хоёр айл байж гэнэ. Нэг нь мал хөрөнгөөр цөөн, ам бүл олонтой боловч гэртээ элбэг дэлбэг, эв эетэй амьдардаг Пагийнх гэдэг айл ажээ. Нөгөө нь ам бүл цөөн, баян чинээлэг атлаа эв түнжин муутай, хэрүүл маргаан ихтэй Торигийнх гэдэг айл байв. Нутгийнхан Паг гуайн эвтэй найртай магтан, Тори гуайн амьдралыг “Хэрэг алга” гэж сэм ярилцдаг байжээ.

#### Гол хэсэг:

Үйл явдлын өрнөл хэсэг

#### Үлгэрийн эхний үйл явдал цааш яаж үргэлжлэх бол?

Нэг өдөр Тори Пагийн эвсэг амьдардгийн нууцыг мэдэхээр хөршийндөө очив. Энэ үед Пагийн хүү:

- Манай аргамжаатай морь алдуураад тариан талбайд орж хамаг тариаг идчихлээ гэв. Гэрийнхэн цөм ухасхийн гарч морио барьж авлаа. Паг:

- Би өглөө морио бөх аргамжсан бол хаанаас ийм юм болох вэ? гэж өөрийгөө зэмлэхэд гэргий нь:

- Үгүй ээ, Би өглөө мориндоо ахиухан өвс бордоо өгчихсөн бол хаанаас ингэж тарианд орох вэ? Миний муугаас боллоо гэвэл хүү нь:

- Үгүй ээ, надаас л боллоо. Аавын морийг би өвстэй газар бөх аргамжсан бол ийм юм болохгүй байсан гэж аав ээжээсээ санаа зовж зогсов. Голын захад юм угааж байсан охин нь:

- Миний буруу. Би юм угааж байхдаа морио алдуураад явж байхад хардаггүй, миний л буруу гэлээ.

#### Үйл явдал өрнөсөөр, яаж төгссөн бэ?

Энэ яриаг Тори гуай сонсоод Паг гуайнхны эвтэй найртай, сайхан амьдралын учрыг ухаарч гэнэ.

1

Үлгэр “Яаж эхэлж, яаж үргэлжилж, яаж төгсөж” байгааг ярилцаарай.



#### Үгийн утгыг мэдье

нэг гол усанд нутагладаг - Нэг нутагт амьдардаг.

ам бүл – нэг гэрийнхэн

Я.Цэвэл "Монгол хэлний товч тайлбар толь"-оос



Б. Зохиолыг үйл явдлын дарааллын дагуу ангийнхандаа ярьж өгөөрэй.

- Зураглалын дагуу, бусдад ойлгомжтой, цэгцтэй ярихад бэлтгээрэй.
- Баатруудын үг хэллэгийг хэрэглэж яриарай.

**Эхлэл хэсэг:**  
Хэний, юуны тухай өгүүлэхийг танилцуулсан хэсэг



**Төгсгөл хэсэг:**  
Үйл явдлын нэгтгэн дүгнэсэн хэсэг

Эрт цагт нэг гол усанд нутагладаг хоёр айл байж гэнэ.

үйл явдал  
үйл явдал  
үйл явдал

Паг гуайнхны эвтэй найртай, сайхан амьдралын учрыг ухаарч гэнэ.



В. Паг гуайнхны эвтэй найртай, сайхан амьдралын учрыг та бүхэн юу гэж бодож байна вэ? Баатруудын үгсээр жишээлж яриарай.

Гэрийнхэн **цөм ухасхийн гарч** морио барьж авлаа.

...гэж **өөрийгөө** зэмлэхэд

**Миний муугаас** боллоо гэвэл...

Үгүй ээ, **Надаас л** боллоо.

Миний буруу, миний л буруу гэлээ.

...аав ээжээсээ **санаа зовж** зогсов.



Г. Баатруудын хэлэх үгийг төсөөлж зохиоцгооё. “Эвсэг айл” эхийн үйл явдал Тorigийн гэрийнхэнд тохиолдсон бол тэд юу хэлэх байсныг ярилцаад, төсөөлөн зохиож бичээрэй.

...Нөгөө нь ам бүл цөөн, баян чинээлэг атлаа эв түнжин муутай, хэрүүл маргаан ихтэй Тorigийнх гэдэг айл байв.

Манай аргамжаатай морь алдуураад тариан талбайд орж хамаг тариаг идчихлээ гэв.



Бид өгүүлбэрийг хураах аргыг өмнө үзсэн. Одоо дэлгэрүүлье.

- ❑ Өгүүлбэрийг хураангаа өгүүлбэр яаж дэлгэрдгийг ажиглаарай.
- ❑ Хураангуй өгүүлбэр, дэлгэрэнгүй өгүүлбэр хоёрын ялгааг хэлээрэй.

Өгүүлбэрийг хураая.



- Би өглөө мориндоо ахиухан өвс бордоо өгчихсэн.
- Би мориндоо ахиухан өвс бордоо өгчихсэн.
- Би мориндоо өвс бордоо өгчихсэн.
- Би өвс бордоо өгчихсэн.
- Би өгчихсэн.



Өгүүлбэрийг дэлгэрүүлье.

Өгүүлбэрийг хураая.



- Тори Паг гуайнхны эвтэй найртай, сайхан амьдралын учрыг ухаарч гэнэ.
- Тори эвтэй найртай, сайхан амьдралын учрыг ухаарч гэнэ.
- Тори сайхан амьдралын учрыг ухаарч гэнэ.
- Тори амьдралын учрыг ухаарч гэнэ.
- Тори учрыг ухаарч гэнэ.
- Тори ухаарч гэнэ.



Өгүүлбэрийг дэлгэрүүлье.

Дараах өгүүлбэрийг хураая. Хураасан өгүүлбэрээ дэлгэрүүлж, ажиглаарай.

- Би өвстэй газар бөх аргамжсан.
- Нутгийнхан Паг гуайн эвтэй найртайг магтана.



Д. Өгүүлбэрийг дэлгэрүүлж бичье.

- Зургийн санааг хураангуй өгүүлбэрээр илэрхийлээрэй.
- Хураангуй өгүүлбэрээ дараах асуултад хариулагдах үгсээс сонгон, дэлгэрүүлж бичээрэй.

Хаана?

Ямар?

Ягаад?

юуг, хэнийг?  
юуны, хэний?  
юунд, хэнд?  
юунаас, хэнээс?  
юутай, хэнтэй?



## ДАСГАЛ 4



А. Дараах шүлгийг уншиж ойлгоё.

1. Бөмбөрцөг дэлхий хэлбэртэй  
Бүслүүр хавчаар тохирсон  
Бөөрөнхий дугариг тоорцог  
Толгой дээрээ дэгжин



сампин

хавчаар

залаа

бүслүүр




- 1 Асуултын дагуу ярилцаарай.

- ✓ Тоорцог малгайг яагаад дэлхийн бөмбөрцөгтэй адилтгасан юм бол?
- ✓ Энэ дуунд тоорцог малгайг бөмбөрцгийн юутай адилтгасан бэ? (Өнгө, хэлбэр, шинж чанар ...)
- ✓ Харин та бүхэн тоорцог малгайг өөр юутай адилтгамаар байна вэ?

2. Эцэг өвгөдийн хийсэн  
Дөрвөлжин захтай дээл  
Эргэн тойрон мөшгөөртэй  
Элбэг маягийн хувцас



3. Мяндсан дурдан бүсийг  
Маягийг нь тааруулж ороосон  
Мянга түмний үзэсгэлэн  
Манай нутгийн заншил



### Үгийн утгыг мэдье

**мөшгөөртэй** – зах хөвөөг дагуулан хийсэн эмжээр

**дэгжин** - ганган, гоёмсог

**мяндас** - нэгэн төрлийн зөөлөн даавуу

**дурдан** - нэгэн төрлийн торгомсог даавуу

**заншил** - нийтээр уламжилсан хэв журам, ёс

**залаа** - малгайн цацаг *"Монгол хэлний хураангуй тайлбар толь"-оос*



Д. Шүлгийн утгыг ойлгосон бол цээжээр, уран уншаарай.



А. Дараах эхийг хэсэг хэсгээр хувааж, ярилцаж уншъя.

- Уншаад, бие биеэсээ асуулт асуугаарай. Ойлгохгүй үгийн утгыг багшаасаа, найзаасаа асуугаарай.



### Казах түмний хувцас, хэрэглэл

Казахууд бол хувцасны өвөрмөц хэв маягтай ард түмэн юм. Тэд дотуураа хагас задгай энгэртэй, заханд нь хээ угалз шагласан цамц өмсөж гадуур нь хар бараан өнгийн хантааз өмсөнө. Эрэгтэй хүний хантааз богино, эмэгтэй хүний хантааз **уртавтар** байдаг.

- “Уртавтар, урт” гэсэн үгс утгын хувьд ямар ялгаатай вэ?

Гоёлын хантаазыг хар хөх өнгийн хилэн, үслэг, торгомсог материалаар хийж, зах, ханцуйг тод өнгийн саатай торго, хоргой, шүр, сувд, хээ угалз утсаар чимэглэдэг.

- Ямар учраас шар шувууны өд хатгадаг вэ? Ярилц.



Эрэгтэй хүн үнэгний годоор малгай хийж өмсдөг. Годыг булгаар эмжээрлэнэ. Малгайн арын хэсгийг ягаавтар улаан өнгийн торгоор бүрж оёдог. Хамгийн дээд талд нь шар шувууны өдийг хатган оёдог.

- Дараах хэсгийг дэлгэрүүлж ярилцаарай.



Шар шувууны өдийг элдэв муу зүйлээс хамгаалах, баян чинээлэг, аз жаргалтай амьдралын бэлгэдэл гэж дээдэлдэг байна.

- Охидын малгайг энд бичсэнээр зураарай.



Охид нь ангийн үсээр хошмоглосон, оройд нь шар шувууны өд хадсан дугуй шовгор малгай өмсдөг байна. Харин хүүхдүүд хамбаар хийсэн тоорцог малгай өмсөх ба малгай нь яг эсгий гэр шиг харагддагаараа онцлог.




### Үгийн утгыг мэдье

- шаглах** – Ойрхон жигд хатгаж оёх
- хошмоглох** – Юмны зах хормойгоор хөвөөлөх
- үнэгний год** – амьтны шилбэний арьс
- хамба** - торго, хилэн


Я.Цэвэл "Монгол хэлний товч тайлбар толь"-оос

1 Қазақ түмний хувцасны тухай уншаад, ямар сэтгэгдэл төрсөн бэ? Найз нөхдөдөө яриарай.

- Минийхээр бол .....
- Надад их таалагдлаа. Учир нь.....
- Үндэснийхээ хувцсаар бахархах сэтгэл төрлөө. Учир нь.....
- Надад .....санагдаж байна.
- Нэмж хэлэхэд .....гэж санагдлаа.

 Б. Өгүүлбэрийг гүйцээж бичээрэй.

1. Қазақ түмэн шар шувууны өдийг ихэд дээдэлдэг учир нь.....
2. Тэд малгай, алчууринхаа оройд өд хаддаг учир нь .....
3. Хүүхдүүд хамбаар хийсэн тоорцог малгай өмсдөг учир нь .....

 В. Багаараа ярилцаад дараах асуултын дагуу мэдээ бэлтгэж, яриарай.

Сэдэв: Қазадын ард түмний хуримын хувцас

Хэн?

Юу?

Хаана?

Хэзээ?

Яагаад?

Юу болов?



- Нэг баг нь эмэгтэй, нөгөө нь эрэгтэй хувцсыг сонгоорой.
- Дээрх эхэд хувцсыг яаж тайлбарласан бэ? гэдгийг дахин уншиж, санаа аваарай.

- ✓ Эрэгтэй нь ямар хувцас өмсдөг вэ?
- ✓ Эмэгтэй нь ямар хувцас өмсдөг вэ?
- ✓ Хувцас тус бүр нь ямар өнгөтэй вэ?
- ✓ Та нар хуримын хувцас өмссөн хүнийг харахад ямар сэтгэгдэл төрдөг вэ?



Үе, үгийг зөв,  
тод хэлэх



Амьсгалаа зөв  
тохируулах  
Дууны өнгө,  
аялгаа тохируулах



Түгдрэлгүй,  
өөртөө  
итгэлтэй ярих



Ярьж байгаа  
найзынхаа нүүр,  
нүд рүү нь харж  
сонсох

# Х БҮЛЭГ. ЁС ЗАНШИЛ

## ДАСГАЛ 1



А. Дөрвөн улирлын мэндийн үгсийг анхааралтай уншаарай. Мэндийн үг тус бүрийн утгыг ярилцаарай.

1

Мэндийн үгсийг аль улирлын болохыг ялгаж бичээрэй. Зарим үг давхцаж болно. Ялгасан учраа тайлбарлаарай.

Казахын ард түмний мэндийн үгийг мөн адил нэмж бичээрэй.

### Мэндлэх ёсон



Сайхан хаваржиж байна уу?	Сайхан зусаж байна уу?	Намаржаа тавлаг уу?	Өвөлжөө тавлаг уу?
			Өвөлжөөгөөр тавтай сайн уу?

- ✓ Тарган тавтай, дулаан сайхан өвөлжиж байна уу?
- ✓ Төл мэнд, сүрэг өсөж байна уу?
- ✓ Тарган сайхан намаржиж байна уу?
- ✓ Мал тарга авч байна уу?
- ✓ Зутрахгүй, мэнд сайн байна уу?
- ✓ Тариа будаа сайн ургаж, тавлаг сайхан сууж байна уу?
- ✓ Сүү цагаа элбэг, тарган тавтай хаваржиж байна уу?
- ✓ Өвөлжөө бууц тавтай, чоно нохой тайван уу?
- ✓ Өвс ногоо элбэг, тавтай сайхан байна уу?
- ✓ Өнтэй сайхан байна уу?
- ✓ Сөл ногоо сайн уу?
- ✓ Бие амар, мал сүрэг мэнд, тарган сайхан зусаж байна уу?
- ✓ Газрын гарц сайн, элбэг баян сууж байна уу?



### Үгийн утгыг мэдье

**ӨНТЭЙ** – цаг агаар дулаан, зуд турхангүй.

**ТӨЛ** – малын үр зулзага

**ЦАГАА** – буцалгасан айраг, тараг, хоормог, аарц

**ЗУТРАХ** – өвлийн хүйтнээс болж, тав тух алдах

**СӨЛ** – намар гандалгүй үлдсэн ногоо

"Монгол хэлний хураангуй тайлбар толь"-оос



**Б. Мэндийн үгэнд дэлгэрэнгүй, бүтэн өгүүлбэрээр хариулж бичээрэй.**

- ✓ Төл мэнд өсөж байна уу?
- ✓ Мал тарга авч байна уу?
- ✓ Зутрахгүй, мэнд сайн байна уу?
- ✓ Тарган сайхан намаржиж байна уу?



**1** Өмнө бичсэн мэндийн үг, хариу мэндийн үгээр бие биетэйгээ мэндлээрэй.

Мэндлэхдээ анхаараарай.

- Дууны өнгө намуун тогтуун, төв хичээнгүй, чин сэтгэлээсээ



**В. Үгсийг зөв дараалалд оруулж, өгүүлбэр бүтээгээд мэндлэх, хүндлэх ёсны талаар мэдэж аваарай.**

- дүү нь, хүнийхээ, асуудаг юм. Монголчууд, эхэлж, амар мэндийг, ахмад
- золгодог. дороос нь, Ахмадынхаа, түшиж, хүн, Дүү, тохойг
- хадаг, настай, ёс байдаг. хүмүүстэй, барьж, Өндөр, золгох,
- ажил, Таны, бүтэмжтэй, байна уу? алба, сайн,
- морилж, замдаа, тавтай, алжаалгүй, Аян, сайхан, ирэв үү?



**Г. Цэгийн оронд өгсөн үгээс сонгон, мэндийн үгийг гүйцээгээрэй.**

Хонь хариулж яваа хүнтэй таарвал:	Хонин сүрэг сайхан ..... байна уу?	явж	ТОГТОЖ
Аян замд хүнтэй таарвал:	Хэрэг зориг .....юу?	бүтэмжтэй	боломжтой
	Алжаалгүй амгалан ..... явна уу?	сууж	морилж
Багштай уулзахдаа:	Номын багштан таны ..... эрье.	Сайн сайхныг	амар амгаланг
Гүү сааж байгаа хүнтэй таарвал:	Зэллэсэн унага зээр гөрөөснөөс ..... болог.	олон	хурдан



**Д. Өгүүлбэрт буруу бичсэн үг байна уу? Хэрэв тийм бол зөв болгож, хичээнгүй бичээд, өгүүлбэрийн утгыг тайлбарлаарай.**

- Амны билгээс ашдын бэлэг. Монголчуудын үг ярианы бэлгэдэл нь мэндчилгээгээр илэрдэг.

## ДАСГАЛ 2



А. Хоёр төлөвлөлтийн загварыг харьцуулж, анхааралтай уншаарай.

1 Дараах хоёр загварын ижил болон ялгаатай талыг харьцуулж ярих

- Өөрсдийн төлөвлөлтийн загвар ямар болохыг нэмж ярих
- Төлөвлөхийн зорилго, ач тусыг жишээгээр тайлбарлаж ярих

Ярихдаа санаа аваарай.

- Хүн багаасаа сайн дадал хэвшилтэй болохын тулд төлөвлөлт хийж сурах хэрэгтэй. Үүний үр дүнд өдөр, өдрийн ажлаа зөв зохицуулж сурна. Мөн сайныг дадуулж, буруу зуршлаа засна.

Миний мөрөөдөл			Өөрийгөө хөгжүүлэх сарын төлөвлөгөө							
гараг	хийх ажлууд	тэмдэглэл	Би чадна	1	2	3	4	5	6	7
даваа			Дугуйланд явах							
мягмар			Биеийн тамирын дасгал хийх							
лхагва			Эрүүл хооллох							
пүрэв			Ном унших							
баасан			Ярих чадвараа хөгжүүлэх							
бямба			Чөлөөт цагаа зөв өнгөрөөх							
ням										

2 Төлөвлөлтийн тухай уншаад, санааг бүдүүвчээр илэрхийлээрэй.

Төлөвлөлт хийх олон арга бий. Хүн бүр хүсэл мөрөөдөлтэй бөгөөд түүнийгээ зорилго болгон тодорхойлоорой. Зорилгодоо хүрэхийн тулд жилээр, сараар, өдрөөр төлөвлөнө. Өдөр бүрийн төлөвлөлтдөө юуны өмнө хэвшүүлэх зүйлээ бичих нь чухал. Харин төлөвлөсөн ажлаа заавал хийж биелүүлж сурснаар хүн хариуцлагатай болно. Мөрөөдөл биелнэ.



### Үгийн утгыг мэдье

**дадал** - үргэлжлэн давтагдсаар дадлага болсон зүйл

**хэвшил** - хэвшсэн дадал, зуршил

**зуршил** - хэвшиж тогтсон зан, тогтсон хэвшил

**мөрөөдөх** - ямар нэгэн зүйл хийхийг ихэд зөгнөн хүсэх

"Монгол хэлний хураангуй тайлбар толь"-оос



## Б. Өгүүлбэр зохиоё.

- Дараах өгүүлбэрийн “сайныг” гэсэн үгийг “мууг” гэсэн үгээр сольж, өгүүлбэрийг дуурайж зохиож бичээрэй.

Сайныг дадуулахгүйгээр муу зуршилд хэвшвэл засахад тун хэцүү шүү.



- Цэгийн оронд нөхцөлөөс сонгож, өгүүлбэрийг гүйцээгээд уншаарай.

Хүүхэд бүр өөрийн мөрөөдөлтэй бай... . Мөрөөдлөө зорилго болго..., түүндээ алхам алхмаар хүрэхийг хичээ... хүүхэд л мөрөөдлөө биелүүл... . Зорилготой хүүхэд цаг боломжийг зөв ашигла..., илүү ихийг тани... мэд..., баяр хөөр, амжилт, аз жаргалтай бай... чад... . Тиймээс та нар мөрөөдөлдөө хүр... зорилго тавь..., түүнийгээ биелүүл... төлөвлөгөө гарга... .




**Нөхөх нөхцөл:** -х, -даг, -ж, -н, -сэн, -дэг, -на, -аарай

- Өгүүлбэрийг гүйцээж бичээрэй.

Хүн зорилгодоо хүрэхийн тулд .....  
Хүсэл мөрөөдлөө зорилго болгосноор .....

- Зүйр үгийг зөв байрлуулж, утгыг ярилцаарай.



- Өгүүлбэрүүдийг зөв дараалалд оруулж, төлөвлөх дарааллыг мэдэж аваарай

- Төлөвлөх
- Хийх зүйлийнхээ жагсаалтыг гаргах
- Хийх ажил бүр дээр цагийн хязгаар тогтоох
- Өөрийнхөө цагийг хэрхэн өнгөрүүлж буйгаа хянах
- Хамгийн чухал ажлаас эхлэх



В. Өөрийнхөө төлөвлөгөө түүний үр дүнг дүгнэж яриарай.

- Хүсэл мөрөөдөл нь юу байв?
- Түүндээ хүрэх зорилго юу байв?
- Ямар ямар үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэв?
- Үр дүн нь юу байв?
- Хэцүү нь юу байв?
- Урам зориг өгсөн нь юу байв?



- Найзууддаа төлөвлөгөөний талаар зөвлөгөө өгөөрэй.

Өдөр бүр нэг алхам л урагшил.

Өөдрөг бай.

Зоригтой бай.

Цаг хугацааг удирд.

Өөрийгөө урамшуул.



Г. Зөв бичье. Тодруулсан үгсийн эгшигт ба заримдаг гийгүүлэгчийг эгшигжүүлж байгаа эгшгийг олоорой.

- 1 Хэсэг тус бүрийн дүрмийг зөв харгалзуулаарай.

болжморын ангаахай, хэллэгийг тогтоох, тайлбарыг унших, найдварын гэрээ, аргалын утаа, мэргэнээс асуух, өтгөсөө асрах, тэнгэрийн заадас

нөхцөлөө өөрчлөх, бусдадаа түгээх, нөхдөдөө талархах, нар туссаныг хараад

танхимын хурал, ахицыг тооцох, гурилаа исгэх, тохироод явах, ангирын зулзага, онгиороо залуу, халимын нуруу, зоригоор ялах, оргилон асгарах, зангилаад уях

дасгалын дэвтэр, ялгахаа мартаx, нагацаас асуух, дурсгалын зураг, хоёр загалын, чанараа хадгалах, хоногийн хоол, хагараад унах, хоргодоод хоцрох

Хонгорын элс, Арцатын өвөр, Дарханы зам, Дуламын хүү, Идэрийн ном

бичихийн учир, хооллохоор суух, амрахаа мартаx, зогсохыг хориглох

- ▶ Үйл үгийн "-х"-ийн өмнөх балархай эгшгийг гээхгүй.
- ▶ Ялгах эгшгийг гээхгүй.
- ▶ Эгшигт 7 эгшиггүйдэхэд хүрвэл эгшгийг гээхгүй.
- ▶ "-ж, -ч, -ш"-ээс бусад гийгүүлэгчийн дараа орсон "-и" эгшгийг гээхгүй.
- ▶ Оноосон нэрийн балархай эгшгийг гээхгүй.
- ▶ Заримдаг 9 эгшиггүйдэхэд хүрвэл эгшгийг гээхгүй.



А. “Хүүхдийн даахины ерөөл”-ийг “Даахь үргээх найр”-д уншиж байна гэж төсөөлж уран уншаарай.

- Зогсолт, аялга, хурд, амьсгалын хуваарилалт, дууны өнгөө зохицуулж уншаарай.

## Хүүхдийн даахины ерөөл

Зээ,  
Түмэн өлзий бүрдсэн  
Төвшин сайн өдөр өө  
Эрхэм хайрт хүүгийнхээ  
Алтан хонгор даахийг  
Баруун талын шанаанаас нь үргээхэд  
Бадамлянхуа цэцэг дэлгэрч байгаа мэт  
Зүүн талын шанаанаас нь үргээхэд  
Зүйл бүрийн эрдэм цацарч байгаа мэт  
Орой дээрээс нь үргээхэд  
Ой билиг нь хурцдаж  
Оюун ухаан нь нэмэгдэж байгаа мэт.

Эрхэм хайртай хүүгийн  
Эрдэм билгийг ярихад  
Номд мэргэн  
Нойронд сэргэг  
Үйлэнд уран  
Үгэнд цэцэн  
Дайнд баатар  
Далайд усч



Элгээрээ энх сайхан жарган  
Төрлөөрөө төв сайхан оршиж  
Үрээ танихгүй өнөр  
Үрээгээ танихгүй баян  
Баярын магнайгаар  
Баясан жаргахын  
Ерөөлийг дэвшүүлэн айлтгая.



## Үгийн утгыг мэдье

**даахь** - бага хүүхдийн сэвлэг /нялхын үс  
**өлзий** - сайн учрал тохиол  
**төвшин** - энх тунх, тогтуун аятай  
**энх** - амар амгалан, амар төвшин, тайван  
**хонгор** - хүрэвтэр бор өнгө  
**бадамлянхуа** - нэгэн төрлийн цэцэг  
**билиг** - оюун ухаан  
**элгээрээ** - садан төрөл  
**өнөр** - олон  
**үрээ** - 3 - 5 хүртэлх насны эр адуу

"Монгол хэлний хураангуй тайлбар толь"-оос



## Б. Шүлгийг уншиж ойлгоё.

1 Асуултын дагуу ярилцаарай.

- “Хүүхдийн даахь үргээх” – Бага насны хүүхдийн үсийг анх авах ёслолын талаар сонсож байсан уу?
- “Түмэн өлзий бүрдсэн, Төвшин сайн өдөр” Ямар өдөр даахь үргээдэг вэ?
- **Үгийн утга:** “өлзий” – сайн учрал тохиол, “төвшин” – энх тунх, тогтуун аятай
- “Алтан хонгор даахь” – гэсэн үгийн утгыг харъя.
- **Үгийн утга:** “хонгор – хүрэвтэр бор өнгө”, “алтан хонгор” гэдэг нь ямар өнгө вэ?

2 Дараах хэсгийг анхааралтай уншиж, үр хүүхдэдээ юу юуг ерөөснийг ойлгоорой.

“Эрхэм хайртай хүүгийнхээ алтан хонгор даахийг үргээхэд”

Орой дээрээс нь үргээхэд  
Ой билиг нь хурцдаж  
Оюун ухаан нь нэмэгдэж байгаа **МЭТ**.

Баруун талын шанаанаас  
нь үргээхэд  
Бадамлянхуа цэцэг  
дэлгэрч байгаа **МЭТ**

“бадамлянхуа” цэцэг  
“ариун” гэсэн бэлгэдэл



Зүүн талын шанаанаас  
нь үргээхэд  
Зүйл бүрийн эрдэм  
цацарч байгаа **МЭТ**



Эрхэм хайртай хүүгийн эрдэм билгийг харахад

Номд  
мэргэн

Нойронд  
сэргэг

Үйлэнд  
уран

Үгэнд  
цэцэн

Дайнд  
баатар

Далайд  
усч

3 Ерөөлийг уншихад ямар сэтгэгдэл төрснөө хуваалцаарай.

4 Дараах холбоо үгсээс утгын хувьд буруу, зохисгүй холбоо үг байна уу? Үг бүрээр ярилцаарай.

“Ерөөл” – (Сайныг бэлгэдэн хэлдэг үг хэллэг) Ерөөл хэлэх, ерөөл дуудах, ерөөл унших, ерөөл айлдах, ерөөл тавих, ерөөл өргөх, ерөөл орших



В. Цэгийн оронд утга тохирох үгийг сонгож, ерөөлийг гүйцээгээрэй.

Эрдэмтэн багшийнхаа сургаалаар  
 Ээлтэй номыг суран  
 Элдэв мэргэжлийг олоод  
 Эх эцэгтээ .....  
 Элгэн садандаа .....  
 Эх орондоо .....  
 Энэ дэлхийд .....  
 Эрхэм сайн хүн болохын  
 Эетэй сайхан ерөөлийг  
 Энд дэвшүүлж айлтгая.

**Нөхөх үгс:** гавьяатай, нэртэй, түшигтэй, энэрэлтэй

1 Үйл явдал тус бүрд 2, 2 мөр ерөөл бичээрэй.



Ном уншиж байгаа найздаа



Дасгал тогтмол хийдэг найздаа



Өндөр настанд тусалж байгаа  
найздаа



Хуримаа хийж буй ах, эгчдээ

2 Зөв бичих дүрмийн алдаатай үгийг олоод, зөв болгож бичээрэй.



- Дуутай бороо орох үед айраг бүлхийг цээрлэнэ.
- Дээл хувцас дээгүүр алхаж гархыг цээрлэнэ.
- Нойтон модны мөчир хугалхыг цээрлэнэ.
- Ганц савхаар хоол идхийг цээрлэнэ.
- Хүний дэргэд аяга таваг, сав суулгаа чанга тавхыг цээрлэнэ.
- Хүнд цай хоол барихдаа ганц гараар өгхийг, авхыг цээрлэнэ.

Г. Зүйр цэцэн үгийг анхааралтай уншиж, тус бүрийн санааг ярилцаарай.

Ганц хүн айл болдоггүй.  
Ганц мод гал болдоггүй.

Нэг үхрийн эвэр доргивол  
Мянган үхрийн эвэр доргино.

Ганц цуцал галын эх  
Ганц үнээ малын эх

Ганцаас газар дүүрнэ.  
Чимхээс атга дүүрнэ.

Нэг бүдэрвэл  
Долоо бүдрэх

Ганцаараа шийдвэл гарз их  
Олноороо шийдвэл олз их

Нэг өдөр танилцаж,  
Мянган өдөр нөхөрлөнө.

1 Зүйр цэцэн үгсээс сонгон, шалтгааныг тодруулах гурван асуулт асууж, хариулж ярилцаарай.



яагаад?  
ямар учраас?  
ях гэж?  
учир юу вэ?

Ингэж  
ярилцаж  
болох юм.



яагаад гэвэл ...  
учраас  
тийм учраас  
тэгсэн учраас

Яагаад олноороо шийдвэл  
олз их байдаг вэ?

Яагаад вэ? гэвэл ганц хүний  
шийдвэрээс олон хүний шийдвэрт  
алдаа бага байдаг.

2 Үг тус бүрээр өгүүлбэр зохиогоорой.

ганц, гарз, олз, атга

чимх, чимэх

3 Зүйр үгсээс юуг ойлгов? Ярилцаарай.



Ганцаас олон хүчтэй.



???



### Үгийн утгыг мэдье

**атга** - нэг гарын алга, хурууг хумисны доторх зай хэмжээ

**чимх** - хоёр хуруугаар хавчсан хэмжээ

**гарз** - эд хөрөнгөнд учирсан хохирол

**олз** - үнэ өртөггүй олсон юм.

**цуцал** - галд дутуу шатсан мод

**өрөөсөн** - хосоор байдаг зүйлийн нэг

“Монгол хэлний хураангуй тайлбар толь”-оос



Д. “Би ингэж бодож байна” гэсэн хэсгийг уншаад, “тийм”, “үгүй” гэсэн хариултаас сонгон, учрыг тайлбарлан ярилцаарай.

Би ингэж бодож байна.	тийм	үгүй
“Ганц” - гэсэн үг нь “нэг”, “өрөөсөн” гэсэн үгтэй утга адилхан.		
“Нэг хүн айл болдоггүй Нэг мод гал болдоггүй” - “ганц” гэсэн үгийг “нэг” гэсэн үгээр солиход зүйр үгийн утга нь хэвээрээ байна.		
“Нэг бүдэрвэл долоо бүдрэх”, “Нэг үхрийн эвэр доргивол мянган үхрийн эвэр доргих” - зүйр үгсийн утга нь адилхан.		
“Нэг өдөр танилцаж, мянган өдөр нөхөрлөнө” гэсэн өгүүлбэрийн “-ж” нөхцөлийг “-н, -аад” нөхцөлөөр сольж болно.		
“Ганц цуцал галын эх” - “цуцал” гэсэн үгийг “мод” гэсэн үгээр соливол утга нь өөрчлөгдөнө.		

1 Цэгийн оронд тохирох урт эгшгийг нөхөж, өгүүлбэрийг алдаагүй, цэвэрхэн хуулж бичээрэй.

Монголч....д нэг....н тоог бүх тоо т....ллын суурь, нэг....с олон .....сдэг гэж үзэж бэлгэш....дэг. Өөр.....р хэлбэл нэгээс мянга болно, цөөн....с олон болно хэм.....н үздэг байна. Нэгтэй ойролц..... утгатай “ганц”, “цор”, “өр.....сөн” гэсэн үгс байна.

2 “Үг” гэсэн үгийг тодотгож болох үгсийг жагсаан, холбоо үг бичээрэй.

Жишээ нь:

Ширүүн үг

Чалчаа үг

Мэндийн үг

Цэцэн үг

Худал үг



Е. Зураг тус бүрийн санааг илэрхийлж, 3 дэлгэрэнгүй өгүүлбэр зохиогоорой.





А. Мэдээг анхааралтай уншаарай. Мэдээг бүтцээр задалсныг ажиглаарай.

хэн?

юу?

**Монгол улс “Ботго авхуулах зан үйл”-ийг ЮНЕСКО-д бүртгүүлжээ.**



Монголчуудын уламжлалт "Ботго авхуулах зан үйл"-ийг **хаана?** ЮНЕСКО-гийн яаралтай хамгаалах шаардлагатай соёлын өвийн жагсаалтад **хэзээ?** 2015 оны 12 дугаар сарын 01-ний өдөр **юу болов?** бүртгүүлэв. Энэ бол Монгол улсаас ЮНЕСКО-д бүртгүүлж буй 13 дахь өв бөгөөд Монгол хүн бүрийн бахархал юм.

**яагаад?** Ботго авхуулах нь монголчуудын малтайгаа хэрхэн харилцдагийг харуулсан зан үйл. Ингэ хоёр жилд нэг удаа ботголох бөгөөд ботгоо голох тохиолдол их байдаг.

Тиймээс ингийг хөөсөлж, аялгуу эгшгээр аргадахад нулимс бөмбөрүүлэн уярч, өнчирсэн, гологдсон ботгонд бага багаар дасаж, ботго шигээ хайрладаг байна. Дуу, аялгуугаар ингэнд ботго авхуулдаг өвөрмөц арга өөр хаана ч байхгүй юм.



### Үгийн утгыг мэдье

**ЮНЕСКО** - Нэгдсэн Үндэстний Байгууллагын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага

**өв** - өнгөрсөн үеэс уламжлан авсан соёл

**соёл** - хүн төрөлхтний бүтээсэн эд баялаг, оюун ухааны ололтын цогц

**зан үйл** - хүний аж амьдралтай холбоотой элдэв үйл хөдлөл

**голох** - чамлаж үл тоох, үл хайхрах

**аргадах** - арга звийг нь олох; зөөлөн ухуулах

**хөөслөх** - ингэ аргадах

*Я.Цэвэл "Монгол хэлний товч тайлбар толь"-оос*

1

Өөрийгөө телевизийн нэвтрүүлэгч гэж төсөөлөөд мэдээг дахин уншаарай.



- 👉 Үе, үгийг зөв, тод хэлэх
- 👉 Үгийг сольж гээлгүй унших
- 👉 Амьсгалаа зөв тохируулах
- 👉 Дууны өнгө, аялгаа тохируулах
- 👉 Түгдрэлгүй унших

2 Мэдээг хураасныг анхааралтай уншаарай. Мэдээний санаа бүрэн гарсан байна уу? Харьцуулж хараарай.

- хэн?
- юу?
- хаана?
- хэзээ?
- яагаад?
- юу болов?

хэн?                      юуг?                      хаана?    хэзээ?    юу болов?  
 Монгол улс “Ботго авхуулах зан үйл”-ийг ЮНЕСКО-д 2015 онд бүртгүүлжээ.  
 Яагаад?  
 Дуу, аялгуугаар ингэнд ботго авхуулдаг өвөрмөц арга өөр хаана ч байхгүй.

Б. Нийлмэл өгүүлбэрүүдийг задалж, энгийн өгүүлбэр болгож бичээрэй. Хэдэн энгийн өгүүлбэр байгааг ярилцаарай. Өгүүлбэрүүдийг “-на<sup>4</sup>” нөхцөлөөр төгсгөөрэй.

Ингийг хөөсөлж, аялгуу эгшгээр аргадахад нулимс бөмбөрүүлэн уярч, өнчирсэн, гологдсон ботгонд бага багаар дасаж, өөрийн ботго шигээ хайрладаг байна. Дуу, аялгуугаар ингэнд ботго авхуулдаг өвөрмөц арга өөр хаана ч байхгүй юм.

1 Шалтгааныг хэлээрэй.


Үйл явдал	шалтгаан
"Ботго авхуулах зан үйл"-ийг бүртгүүлсэн.	
Монгол хүн бүрийн бахархал юм.	
... нулимс бөмбөрүүлэн уярч	
...өнчирсэн, гологдсон ботгонд бага багаар дасаж...	

яагаад гэвэл...  
 учраас...  
 тийм учраас...  
 тэгсэн учраас...

В. Доомбор хөгжмийн онцлогийг 4 - 5 дэлгэрэнгүй өгүүлбэрээр илэрхийлж бичээд, бие биедээ уншиж өгөөрэй.



## ДАСГАЛ 1

 А. Эхийг анхааралтай уншаад, даалгаврыг хийгээрэй.



### Аз жаргалтай дэлхий

Цогтоогийнх ам бүл тавуулаа амьдарна. Тэдний гурван хүүхдийг ухаалаг, тусархуу ёстой л атгасан гар шиг хүүхдүүд шүү хэмээн хөрш айлын Должин эмээ ямагт магтана. Аав ээж хоёр нь албан ажил ихтэй тул оройдоо халуун ам бүлээрээ цугларч, бөөн дуу шуугиан болцгооно. Энэ үдэш Цогтоо хоолны ширээ тойрон суугаа гурван хүүхдээсээ ийн асуулаа.

-За миний хүүхдүүд том болоод юу больё гэж бодож байна даа? гэвэл ууган хүү эргэлзсэн янзгүй.

-Аав аа! Би нисгэгч болно гэлээ. Харин дунд охин нэлээд гайхсан янзтай нүдээ эргэлдүүлэн, дал мөрөө өргөж, аав руугаа том харснаа,

-Аав аа! Би хүн болмоор байна гэх нь тэр. Гэр дүүрэн инээд, наргиа боллоо. Аргагүй шүү дээ. Аав нь асуултаа буруу асуусан байх нь ээ.

Уг нь том болоод юу болох тухай биш, ямар мэргэжилтэй болохыг хүсэж байгааг нь асуух байж шүү дээ.

-Аан тэгэлгүй яах вэ. Миний охин чинь ачлал, энэрэлтэй сайн хүн болно. Аавыгаа уучлаарай.

Ингэхэд миний охин том болоод ямар мэргэжилтэй хүн болох вэ? гэвэл дунд охин: - Аав аа!

Би алтан гартай эмч болно. Тэгээд эмээ, өвөө гээд л бүх хүмүүсийг эмчилнэ хэмээн бахархалтай нь аргагүй хариуллаа.

Харин бага охин чимээгүй л ямар нэгэн юм зурсаар байлаа. Тэр ярилцах дургүй байгаа бололтой.

Гэтэл "Аз жаргалтай дэлхий" гэсэн нэртэй зураг зурсан байв. Дүүгийнхээ зурсан зургийг харсан ах эгч хоёр нь:

-Хүүе ээ, "Миний дүү чинь маш гоё зураг зурсан байна шүү дээ" гэхэд бага дүү Нарая:

-Бид нэг дэлхийтэй учраас хүн бүр эх дэлхийгээ цэвэрхэн байлгаж, хайрлан хамгаалах ёстой гэж багш маань хэлсэн хэмээн зурсан зургаа тайлбарлаж өглөө. Ах эгч, аав ээж, хөрш айлын эмээ хүртэл зургийг харж сэтгэлээ баясган, авьяаслаг охиноо магтав. Нарая "Аз жаргалтай дэлхий"-гээ тэвэрсэн хэвээр...

-Аав аа! Би байгаль хамгаалагч болно оо. Тэгээд ан амьтан, ургамал ногоо, уул усаа хамгаална гэж хэлээд инээмсэглэв. Тэр үнэхээр сэтгэл хангалуун байлаа.

Хүсэл мөрөөдлөө дэлгэсэн энэ үдшийн яриа Цогтоогийн халуун ам бүлд итгэл найдвар, инээд хөөр, аз жаргал бэлэглэн байв.

(Б.Уламбаяр)





А. Эхийг анхааралтай уншаад, даалгаврыг хийгээрэй.

### Чулуун цуглуулга



Энэ өдөр миний хорвоод мэндэлсэн баярын өдөр билээ. Хамгийн түрүүнд нагац эгч маань “Эрмүүн ээ, Төрсөн өдрийн баярын мэнд хүргэе. Ээж аавдаа энэрэлтэй, эмээ өвөөдөө асралтай, эх орондоо ээлтэй сайн хүн болоорой” гэж ерөөн, Ч.Батзаяагийн зохиол “Хэн гэдгээ үзүүлээд өг” ном, хайрцагтай чихрийн цуглуулга бэлэглэлээ. Миний хайртай зохиолчийн шинэхэн гарсан номыг бэлэглэсэнд хөл газар хүрэхгүй байв. Энэ

үед Тулга найз маань манайд ирлээ. Би ч найзтайгаа чихрийн цуглуулгаа хувааж идэхээр гаргаж ирвэл “Хөөе, Эрмүүн ээ! Надад нэг санаа төрлөө. Хоёулаа чулуун цуглуулга хийе. Тиймээс чихрийн цуглуулгаа болгоомжтой задална шүү” хэмээн нүдээ онилгон инээлээ. Ингээд чихрийн цуглуулгаа идэж дуусаад, оронд нь өнгө өнгийн чулуу хийгээд, буцаагаад наачихлаа. Анхаарал муутай хүн бол мэдэх ч үгүй гэдэгт итгэлтэй байлаа. Тулга сургуулийн хашааны хаалганы ойролцоо хайрцагтай чулуун цуглуулгаа тавиад, холгүйхэн газраас хоёул ажиглан харж, зогсохоор болов. Тэгтэл юу болсон гэж санана аа.

Эхлээд үйлчлэгч Долгор эгч хөлөөрөө өшиглөчхөөд явчихлаа. Дараа нь биеийн тамирын багш тоож харсан ч үгүй хажуугаар нь гараад явчхав. Харин манай хөрш айлын ах Батсуурь өшиглөж үзсэнээ газраас авч, эргүүлж тойруулж хараад, шууд л өвөртөө хийчхэв. Тулга бид хоёр чулуун цуглуулга эзэнтэй болсонд элгээ хөштөл инээж, Батсуурь ахынд очихоор боллоо. Гэр лүү нь ортол бид хоёрын цуглуулж хийсэн хэдэн хөх чулуу хоймор нь шидээстэй. Нараа эгч уйлчихсан. Батсуурь ах хэрэг хийсэн хүүхэд аятай таг дуугүй дүмбийгээд сууж байна. Тэдний байдлыг харвал Батсуурь ах маань олж өвөртөлсөн цуглуулгаа Нараа эгчид өгсөн нь илт байв. Ядаж байхад өнөөдөр чинь аравдугаар сарын нэгэн шүү дээ. Ахмадын баяраар ижийгээ баярлуулж, хамтдаа тоглолт үзнэ гээд баяр хөөртэй байсан Нараа эгчийгээ уйлуулсандаа би харамслаа. Тун тоогүй юм хийлээ дээ. Дэмий л Дөлгөөнөөс тооны номыг нь авах гэсэн юм гэвэл хөөрхий муу Нараа эгч нулимсаа гарынхаа араар арчин, хүүгийнхээ цүнхнээс тооны ном авч надад өглөө. Сэтгэл өвдөх шиг. Ахиж би хэзээ ч хүн хуурахгүй ээ. Зүггүйтэж хийсэн тэр чулуун цуглуулга ямар муухай хор уршигтай байсныг бодохоор одоо ч нурууны хөлс гардаг юм.

(Б.Уламбаяр)



Б. Даалгавруудаас зөв хариултыг сонгоорой.

1. Нагац эгч нь ямар учраас Эрмүүнд ном бэлэглэсэн бэ?
 

А. Төрсөн өдөр нь учир	В. Номд дуртай учир
С. Найзаа хүндэлдэг учир	Д. Аавдаа асралтай учир
2. “Тиймээс чихрийн цуглуулгаа болгоомжтой задална шүү” ..... нүдээ онийлгон инээлээ” гэсэн өгүүлбэрүүдийг аль холбоосоор холбож бичих вэ?
 

А. гэхээр	В. гэвэл	С. хэмээн	Д. хэдийгээр
-----------	----------	-----------	--------------
3. Эх дэх “**онийлгох**” гэдэг үгийн утгад тохирох хэсгийг зөв сонгоорой.
 

А. Нүдээ том болгон харах	В. Нүдний зовхийг дээш өргөн харах
С. Нүдээрээ ширтэн харах	Д. Нүдний зовхийг буулган харах
4. Эхэд өгүүлснээр Тулга, Тэлмүүн хоёр элгээ хөштөл инээсний учир нь юу байв?
 

А. Чулуун цуглуулга эзэнтэй болсон	В. Чулуун цуглуулгыг хийсэн
С. Чулуун цуглуулгыг Долгор эгч өшиглөсөн	Д. Чулуун цуглуулга хор уршигтай
5. “...санаа төрөх...” гэсэн хэллэгийн утгыг эргэцүүлэн бодоод тохирох хэсгийг зөв сонгоорой.
 

А. Шинэ санаа олох	В. Мартсанаа санах
С. Ойлгосноо хэлэх	Д. Товч тайлбарлах

**1** Даалгаврын дагуу бичээрэй.

6. “...Надад нэг санаа төрлөө” гэсэн өгүүлбэрийг **ямар?** гэсэн асуултад хариулагдах үгээр дэлгэрүүлэн дэвтэртээ бичнэ үү.  
.....  
.....
7. “... хөл газар хүрэхгүй...” гэсэн хэлц үгийн утгыг дэвтэртээ тайлбарлаарай.  
Тайлбар: .....
8. Эх дэх “... **хор уршигтай байсаныг бодохоор одоо ч нурууны хөлс гардаг юм**” гэсэн өгүүлбэрээс алдаатай бичсэн үгийг олж засаарай.

Алдаатай үг: .....	Зассан нь: .....
Зөв бичгийн дүрмийн тайлбар .....	

9. Энэ эхийг яагаад “Чулуун цуглуулга” гэж нэрлэсний учрыг тунгаан бодож 20-30 үгэнд багтаан тайлбарлан бичнэ үү.  
.....  
.....



А. Эхийг анхааралтай уншаад, даалгаврыг хийгээрэй.



### Өвийн хэлхээ

Нар хүүшлэн буй зуны үдэш Аргалантын дөрөлжид хаяа дэрлэн буусан хэдэн цагаан гэр холоос бөмбийн харагдана. Тэдний нэг нь Гонгор хүүгийнх бөгөөд энэ жил тэр тавдугаар ангиа төгссөн билээ. Хот айлын хонь, хургыг зөрүүлэх, гүүн зэл дээр очиж унага татахаас өгсүүлээд Гонгорын хийх ажил мундахгүй. Ажил хийвэл дуустал, давс хийвэл уустал гэсэн ардын сайхан үг яг л Гонгорт тохирох мэт.

Нэг өдөр Гонгор адуугаа хураан, булгийн эхэнд очтол нутаг усандаа мэргэн хэмээн хүндлэгдсэн саахалт айлын Дамба өвөө тааралдах нь тэр. Идэр залуудаа Дамба өвөө аймаг, сумын наадамдаа шаггүй сайн сур харвадаг байжээ. Тэгээд л зуны амралтаар ээж, аавдаа тусалж байгаа хөвгүүдээс харваач болох ирээдүйтэйг нь битүүхэн дотроо эрж хайж байсан тул Гонгорыг сүрхий сайн харваач болно доо хэмээн бодсоноо дуулгаад амжлаа. Гонгор хүү өвгөний яриаг сонсоод баярласан гэж жигтэйхэн.

- Нээрээ юу? Өвөө. Би сур харвах сан гэж үнэхээр хүсдэг гэвэл мэргэн Дамбын нүдэнд баяр гийж, маргааш уулзахаар боллоо.

Гонгор хүү маргааш өглөө нь эртлэн босож, нар зүүн уулын оройгоор хөөрөх үед эцгийн хамт багшдаа шавь орохоор алд цэнхэр хадаг өвөртлөн, өвгөнийхийг зорив. Тэд амар мэнд мэдэлцэх зуур Дамба өвөө ийнхүү хуучиллаа.

-Сурын харвааны хамгийн эртний хэлбэр нь аль болох хол зайд байг цэцэн мэргэн онохын төлөөх зэв нүүлгэх тэмцээн юм. Эрт үед зэвт сум хэрэглэдэг байсан учраас зэв нүүлгэх гэж нэрлэж байж. Харин болцуут сум бол арай хожуу үүссэн.

Өнгөрсөн зууны шувтарга үед монголын дорнод нутгийн харваачид өөрсдийн явуулдаг нэгэн зүйл тэмцээнээ зэв нүүлгэх гэж нэрлэсэн байдаг. Ер нь дөчин алд газраас хорин сум тавьж илүү оносон нь түрүүлдэг зэргээс харвал монгол хүний авхаалж самбаа, хурд хүч, оюуныг сорьсон үндэсний бахархал юм даа хүү минь хэмээн өгүүлж, духны хөлсөө арчин суув.

Тэрээр бяд муутайхан гараараа үрчлээтсэн хөх нүүрээ илэн, Гонгорыг ширтэх нь “Хожмын өдөр Дэрстийн тохойгоос улсын дархан мэргэн төрнө дөө” гэж бодож байгааг илтгэнэ.

Дамба өвгөний ярианаас үндэсний сурын харваа бол монгол түмний бахархал, эцэг өвгөдөөс уламжилсан үл тасрах өвийн хэлхээ юм шүү гэдгийг би маш сайн ойлгож авсан.

Энэ үес нутгийн уулс дэргэд дүнхийн, их үдийн наран чанх дээр төөнөх авай.

(Б.Уламбаяр)



Б. Даалгавруудаас зөв хариултыг сонгоорой.

1. “Нар хүүшлэх” гэдэг үг ямар утга илэрхийлж байна вэ?
 

А. нар халхлан сүүдэр буух	В. нар уулын оройд тусах
С. нар хөөрөх	Д. нар шарах
2. “Баяр гийх” гэдэг үгийн эсрэг утгатай үгийг сонгоорой.
 

А. ихэд баярлах	В. баярлаж хөөрөх
С. гуниг төрөх	Д. баяр гуниг хослох
3. Эх дэх **мундахгүй** гэдэг үгийн утгад тохирох хэсгийг зөв сонгоорой.
 

А. бага	В. Ховор	С. Хомс	Д. их
---------	----------	---------	-------
4. Эхэд өгүүлснээр мэргэн Дамбын нүдэнд баяр гийсний учир нь юу байв?
 

А. Гонгор ажилд сайн учраас	В. Гонгор сайн харваач учраас
С. Гонгор сурын харваа сурах болсон	Д. Гонгор бусдад тусалдаг учраас
5. Гонгор хүү эцгийн хамт алд цэнхэр хадаг өвөртлөн өвгөнийхийг зорьсны учир нь юу байв? Тохирох хэсгийг сонгоорой.
 

А. Дамба өвөөтэй танилцах гэж	В. Багш, шавийн барилдлага барих гэж
С. Нум сум сонирхох гэж	Д. Харваж үзэх л гэж

**1** Даалгаврын дагуу бичээрэй.

6. Болцуут сумны тухай Дамба өвөө юу гэж хуучилсан бэ?

.....  
 .....

7. “... хөл газар хүрэхгүй...” гэсэн хэлц үгийн утгыг тайлбарлаарай.

Тайлбар: .....

8. "Нар хүүшлэн буй зуны үдэш Аргалантын дөрөлжид хаяа дэрлэн буусан хэдэн цагаан гэр холоос бөмбийн харагдана". гэсэн өгүүлбэрээс өгөх оршихын болон гарахын тийн ялгалт үгийг олж ялган бичээрэй.

1..... 2.....

9. Өгүүлбэрийн утгыг харьцуулан, өөрийн санаа бодлоо дүгнэн бичээрэй.

Дамбын нүдэнд даруй баяр гийж, маргааш уулзахаар боллоо.

Дамбын нүдэнд даруй баяр гийж, маргааш уулзахаар боллоо. .....	Гонгор хүү эцгийн хамт алд цэнхэр хадаг өвөртлөн, өвгөнийхийг зорив. .....
Дүгнэлт: ..... .....	

10. Энэ эхийг яагаад “Өвийн хэлхээ” гэж нэрлэсний учрыг тунгаан бодож, 20-30 үгэнд багтаан тайлбарлан дэвтэртээ бичнэ үү.

.....  
 .....

# МОНГОЛ ХЭЛ Ү ГАРЫН АВЛАГА

Хос хэлний сургалттай ерөнхий боловсролын  
сургуулийн 5 дугаар ангид үзнэ.

Зохиогчийн баг

Ахлагч:

Гишүүд:

Б.Цасанчимэг

Б.Аяужан

А.Хавдолда

Т.Сауле

Редактор:

Д.Эрдэнэсан

Х.Султанмурат

Зураач:

Н.Буян

Хэвлэлийн эх бэлтгэгч:

Ц.Сугар

Формат: 84x108/16

Офсет хэвлэл. Офсет хэвлэлийн цаас. 80гр/м<sup>2</sup>

Хэвлэлийн хуудас: 15х.х

Хэвлэлийн эхийг “Содпресс” ХХК-д бэлтгэж,  
“Содпресс” ХХК-д 2573 хувь хэвлэв.

ISBN 978-9919-9004-4-1



9 789919 900441

